



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ
ЗАРИМ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ
ҮНЭЛГЭЭ**

2024

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

5 сар

Улаанбаатар хот



Судалгааг захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)

Судалгааны багийн гишүүд:

О.Энххүслэн

Хувийн эрх зүйн секторын Эрдэм
шинжилгээний ахлах ажилтан (LL.M.)

Б.Ариунжаргал

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын Эрдэм шинжилгээний ажилтан

Э.Сэлэнгэ

Хувийн эрх зүйн секторын Эрдэм
шинжилгээний ажилтан

Д.Дэмидханд

Хүний эрх, олон улсын эрх зүйн секторын
Эрдэм шинжилгээний ажилтан

Т.Билгүүн


Хүний эрх, олон улсын эрх зүйн секторын
Эрдэм шинжилгээний ажилтан



ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
УДИРТГАЛ.....	6
НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ.....	8
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	9
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	9
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	10
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	11
2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	11
2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	12
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	13
АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ.....	16
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ.....	18
ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ.....	27
ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	37
ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	60
ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	71
МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ.....	83
ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	88
СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ.....	91
ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ.....	94
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	101
ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	107



ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	109
ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	113
ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	117
МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	129
ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	132
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	134
ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ	144
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	153

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
МУГХУСАЗЗ	Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НШШГГ	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ОХУ	Оросын Холбооны Улс
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЗЯ	Хууль зүйн яам
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХӨТЯЭА	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба
УИХТГ	Улсын Их Хурлын Тамгын газар
УИХ	Улсын Их Хурал
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ШШГБ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШХНБД	Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ГБХТТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ЗШШТХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
МУИГХХЗЦТХ	Монгол Улсын иргэн хувийн хэргээр гадаадад зорчих цагаачлах тухай хууль
ХЭХЭЗБТХ	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль
ХЭЗБТХ	Хуульчийн эрх зүйн байдлын тухай Хууль
ХЭҮКТХ	Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль
ШТХ	Шүүхийн тухай хууль
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

УДИРТГАЛ


Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж, Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж тус тус хуульчлан тогтоосон.

Монгол Улс 1961 оноос Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн болсноос хойш Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагаас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 70 гаруй гэрээнд, үүнээс хүний эрхийн суурь 18 гэрээний 17-д нэгдэн ороод байна. Монгол Улсад шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хангах, зөрчигдсэн эрхийг сэргээх, хүн эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн бие даасан 590 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлсний мөрөөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг арга хэмжээ авах чиглэлээр 11, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ахмад настан зэрэг хүн амын эмзэг бүлгийн иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр 31, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 4, гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 27, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр 23, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 9, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах чиглэлээр 3, ялгаварлан гадуурхах бүх хэлбэр, тэр дундаа ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхахтай тэмцэх чиглэлээр 14, олон улсын гэрээнд нэгдэн орох, дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, хүний эрхийн гэрээний хэрэгжилтийг сайжруулах, хүний эрхийн олон улсын механизмтай хамтран ажиллах чиглэлээр 8, шүүхийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр 8, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ хүртэх эрхийг хангах чиглэлээр 12, Хүний эрхийн Үндэсний Комиссын чиг үүргийг бэхжүүлэх чиглэлээр 10, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиглэлээр 5, бусад 16 зэрэг нийт 170 зөвлөмжийг өгснийг бид үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь 2001-2024 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлын талаарх нийт 23 удаагийн илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн хүний эрхийг хангах хууль эрх зүйн орчныг сайжруулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг арилгах, хүний эрхийг хамгаалахтай холбоотой саналыг танилцуулж, илтгэлийн мөрөөр авах арга хэмжээний талаар Улсын Их Хурлаас холбогдох шийдвэрүүд баталж ирсэн байдаг.

Дээрх илтгэлүүдэд иргэний болон улс төрийн эрхүүд, тухайлбал, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, тайван жагсаал, цуглаан хийх, амьд явах эрх, сонгох, сонгогдох эрх, халдашгүй чөлөөтэй байх эрх, өргөдөл гомдлоо шийдвэрлүүлэх эрх, эрүү шүүлт ба хүний эрх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх, түүнчлэн эдийн засаг, нийгэм соёлын эрхүүд, тухайлбал, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрх,



сурч боловсрох эрх, хөдөлмөрлөх эрх, хүний эрхийн боловсрол, аж ахуй эрхлэх, зохистой хоол хүнсээр хангагдах эрх, зорилтот бүлгийн эрхүүд, тухайлбал, хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, үндэсний цөөнхийн эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүн худалдаалах гэмт хэрэг ба хүний эрх, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийн талаар тусгасаар ирсэн байна.

Ийнхүү “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагатай байна.

Дээрх үндэслэлийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийг боловсруулсан байна.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу тус “Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийн төслийн үр нөлөөг үнэлэхэд оршино. Ийнхүү үнэлэхдээ “Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийн зохицуулалт, агуулга нь нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилгод нийцэж буй эсэх, зохион байгуулалтыг өөрчилж буй зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, шинээр тусгагдсан зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, хуулийн төсөл нь хууль зүйн техникийн хувьд алдаатай эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгсөн болно.

“Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар үнэллээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ сонгох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Зардал¹
6. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал,

1. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээ болон хуулийн төслийн бүтэц нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилго, хууль батлагдах хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх;
2. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдэд өөрчлөгдсөн зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжтой эсэх;
3. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдэд тусгагдсан нэр томъёонууд нь ойлгомжтой эсэх, мөн хууль зүйн техникийн алдаа бий эсэх;
4. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдэд шинээр орж ирсэн зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх;
5. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх зэргийг шалгах;

¹ Хуулийн төслийн “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг “Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийн зардлын тооцоо сэдэвт судалгаа гүйцэтгэсэн байх тул дэлгэрэнгүйг тус судалгаанаас үзнэ үү.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий хуулийн төслүүдийн зохицуулалтуудыг сонгож авлаа. Өөрөөр хэлбэл, тухайн хуулийн төслүүдийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс шинээр орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож үр нөлөө үнэлнэ.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөө тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрээр тус бүрд нь авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Иймд Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс дээрх асуудлын дагуу зорилгодоо хүрсэн эсэхийг “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар үр нөлөөг тооцно. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдлын хүрээнд сонгосон хуулийн төсөл	Сонгосон зүйл заалт
1.	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 7.4-7.8 дугаар зүйл Хуулийн төслийн 21.12 дугаар зүйл
2.	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь хэсэг Хуулийн төслийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэг
3.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 31 дүгээр зүйл Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1, 35.10 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг.
4.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 2.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг,

		6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг
5.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 3.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг
6.	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 8.6 дахь хэсэг, 8.6 ¹ дахь хэсэг
7.	Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэг болон 14 дүгээр зүйл
8.	Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэг
9.	Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.5.8 дахь хэсэг
10.	Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь хэсэг, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь хэсэг
11.	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг
12.	Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь хэсэг
13.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 13.6 дахь хэсэг
14.	Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь хэсэг
15.	Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах агуулгын хүрээнд зохицуулалтуудыг сонгон “Практикт хэрэгжих боломж” гэх шалгуурын үр нөлөөг тооцсон болно.

№	Практикт хэрэгжих боломжийн хүрээнд сонгосон хуулийн төсөл	Сонгосон зүйл заалт
1.	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 7.4-7.8 дугаар зүйл Хуулийн төслийн 13.4 дүгээр зүйл, 29.12 дугаар зүйл
2.	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг

3.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 36 дугаар зүйл
4.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 190 дүгээр зүйлийн 190.5 дахь хэсэг
5.	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 8.6 дахь хэсэг, 8.6 ¹ дахь хэсэг
6.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ
7.	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 7.4 дэх хэсэг 10.3, 10.5 дахь хэсэг, 10.6.1-10.6.3 дахь заалт, 13.10 дахь хэсэг
8.	Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 17.3 дахь хэсэг
9.	Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ
10.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс нэр томъёоны тодорхойлолттой холбоотой хэсгийг болон хууль зүйн техникийн алдаатай зохицуулалтыг сонгон авч үнэллээ.

№	Ойлгомжтой байдлын хүрээнд сонгосон хуулийн төсөл	Сонгосон зүйл заалт
1.	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ
2.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ
3.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсэг
4.	Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ
5.	Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 5 дугаар зүйл

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэх байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх учраас тодорхой байгууллага, иргэний эрх ашиг хөндөгдөж буй зохицуулалтыг сонгон авах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, тухайн төслөөр зохицуулж буй эсхүл шинээр оруулсан зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх учраас иргэн, хуулийн этгээд,

төрийн байгууллагын эрх үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөх зохицуулалтыг сонгон авлаа.

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын хүрээнд сонгосон хуулийн төсөл	Сонгосон зүйл заалт
1.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	55 дугаар зүйл
2.	Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 7 дугаар зүйл

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бид тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг. Тус хуулийн төслийн хүрээнд биржийн холбогдох үйл ажиллагаа нь бусад хуулийн зохицуулалттайг нийцэж буй эсэх талаар шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх нь ач холбогдолтой гэж үзлээ.

№	Харилцан уялдааны хүрээнд сонгосон хуулийн төсөл	Сонгосон зүйл заалт
1.	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ
2.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг
3.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 1.8 дугаар зүйл, 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг
4.	Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэг болон 14 дүгээр зүйл
5.	Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ
6.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ
7.	Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ
8.	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ
9.	Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төсөл бүхэлдээ

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ


Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгслийн дагуу үнэлгээ өгөхөөр тогтлоо.

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Практикт турших
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Өмнөх үе шатуудад журмын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтсон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлал, хууль боловсруулах хэрэгцээ, шаардлага болон тус хуулийн хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх

2.	Практикт хэрэгжих боломж	<p>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</p> <p>Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</p>	Практикт хэрэгжих байдлыг баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар хэрэгжих эсэхийг судлах
3.	Ойлгомжтой байдал	<p>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</p> <p>Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</p>	Тодорхойлоогүй нэр томъёонуудыг тайлбарлах байдлаар санал болгох, хуулийн төсөл боловсруулах нийтлэг шаардлагад нийцүүлэх саналыг гаргах
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	<p>Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</p> <p>Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</p>	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх асуудлын хүрээнд баримт бичгийн судалгаа хийж дүгнэх
5.	Харилцан уялдаа	<p>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</p> <p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p> <p>Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	Харилцан уялдааг судлах, ингэхдээ холбогдох хуулийн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийх



		Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	
--	--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Хуулийн төслөөр иргэний мэдээлэл авах эрхийг хангах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд мэдээлэл ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлах шаардлагаар Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг УИХ-д тайлагнах, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсгийн аж ахуй нэгж, байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг уг хуулийн 12.5 дахь хэсэгт заасан журмын дагуу мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх үүргийг хүлээхээс гадна дээрх тайлан мэдээг олон нийтэд заавал мэдээлж байх үүргийг тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгод нийцжээ.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Аргачлалын 4.10 дахь хэсэгт “Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгах хэрэгслийн хүрээнд дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтооно” гэж заасны дагуу дараах агуулгын хүрээнд харилцан уялдааг үнэлэв.

1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Нийцэж буй талаар өмнөх хэсэгт дурдсан.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуулийн төслөөр энэ хэсэгт өөрчлөлт оруулаагүй.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслөөр шинэ нэр томъёо оруулаагүй.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Зөрчилдсөн заалт байхгүй.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардал байхгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэгт холбогдох Засгийн газар, Засаг дарга, аж ахуй нэгж байгууллагын тайлагнах үүргийн хүрээг өргөтгөж олон нийтэд давхар мэдээлдэг болох үүрэг хүлээлгэсэн ч мэдээлэх давтамжийг тодорхой заагаагүй байна. Засгийн газрын агаарын бохирдлыг бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний

		тайлангаас гадна иргэд агаарын чанарын мэдээг өдөр тутам авах боломжтой эсэхийг тодруулахад Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар өдөр тутам нийслэлийн агаарын чанарын мэдээг бэлтгэн нийтэд мэдээлдэг байна. ² Уг харилцаа нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан Агаарын чанарын мэдээ гаргах журам, Агаарын чанарын индексээр агаарын чанарыг үнэлэх, мэдээлэх журмаар зохицуулагддаг байна. ³ Иймд хуулийн төслөөр давхардуулан хуульчлах шаардлагагүй тул төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй гэж үзэв.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Давхардал байхгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Боломжгүй.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт байхгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Агаарын чанарын мэдээллийг ил тод болгох зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16.17 дахь хэсэгт “Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасантай нийцэж байна.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Жендэрийн эрх тэгш байдлыг зөрчсөн зохицуулалт байхгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт байхгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Зөрчлийн тухай хуульд мэдээлэх үүргээ гүйцэтгээгүй аж ахуй нэгжид хүлээлгэх хариуцлагыг дараах байдлаар тодорхойлсон. 7.4 дүгээр зүйл. Агаарын тухай хууль зөрчих

² Агаарын чанарын мэдээ, <http://agaar.mn/article-view/1267> болон <https://aprd.ub.gov.mn/>

³ Агаарын чанарын индексээр агаарын чанарыг үнэлэх, мэдээлэх журам, 2018, <http://agaar.mn/article-view/692>, Агаарын чанарын мэдээ гаргах журам, 2018, <http://agaar.mn/article-view/691>.

	<p>1. Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа өөрийн үйл ажиллагааны тухай мэдээлэл, озон задалдаг бодис, түүнийг орлуулах бусад бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импорт, үйлдвэрлэлийн тухай мэдээлэл, агаарын бохирдлын эх үүсвэрийн тухай мэдээлэл, агаарт гаргасан бохирдуулах бодисын агууламж, хаягдлын хэмжээ, дотоод хяналтын мэдээг:</p> <p>1.1. тогтоосон хугацаанд мэдээлээгүй;</p> <p>1.2. зориуд буруу мэдээлсэн;</p> <p>1.3. нуун дарагдуулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ


“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

1. Хуулийн төслийн 31 дүгээр зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т “Монгол хүний эрүүл мэнд, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж тус тус заажээ.⁴

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11-д “...улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална...” гэж, мөн зүйлийн 14-т “...Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно...” гэж тус тус заажээ.

⁴ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2024 он.



Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон дээрх эрхийг баталгаажуулж 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг баталсан бөгөөд тухайн үеийн Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг, зөрчилд тооцохоор хуульчилсан бөгөөд үүний дараа 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд /2017 оны 7 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн/ гэр бүлийн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэгт тооцож, зарим гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуульчилсан бөгөөд 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийг хуульчилжээ.

Харин Гэр бүлийн тухай хуульд зааснаар гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хамаарах бөгөөд гэр бүлийн гишүүнд гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүн хамаарах ба төрлийн хүн гэж гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг, харин садангийн хүнд гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхэд тус тус хамаарч байна. Энэ утгаараа гэр бүл нь нийгмийн анхдагч орчин юм.

Харин Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд тус хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг хуульчилсан бөгөөд үүнд:


- эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд;
- тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү хамаарахаар зохицуулсан.

Үүнээс гэр бүлийн хүчирхийлэл нь зөвхөн Гэр бүлийн тухай хуульд заасан гэр бүлийн гишүүн гэх ойлголтоос илүү өргөн хүрээг хамарч байгааг дурдах нь зүйтэй.

Гэр бүлийн хүчирхийлэл нь ихэвчлэн эдийн засаг, эрх мэдлийн тэгш бус харилцаатай гэр бүлийн гишүүдийн дунд үйлдэгддэг. Тиймээс ч ганц удаагийн санамсаргүй үйлдэл бус харин тодорхой зорилготой, олон дахин давтагдаж, даамжрах шинжтэй байдаг. Манай улсын хувьд 2022 онд цагдаагийн байгууллагад энэ төрлийн 1729 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 1664 хүнийг хохирогчоор тогтоогдсон байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь ихэвчлэн нуугдмал хэлбэрт байдаг. Хэдийгээр цагдаагийн байгууллагад энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил ихээр бүртгэгдэж байгаа боловч энэ нь практикт үйлдэгдэж буй нийт гэр бүлийн хүчирхийллийн үнэн бодитой тоо биш гэж судлаачид үздэг. Тухайлбал,

ХЭҮК-оос гаргасан 2023 оны тайланд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ахмадууд холбогдох байгууллагад төдийлөн мэдээлдэггүй байна. ХЭҮК-ын судалгаанд оролцогч ахмадуудын зөвхөн 15 хувь нь цагдаа, хороо, хэсгийн ахлагч, нийгмийн ажилтанд мэдэгдсэн бол 85 хувь мэдээлээгүй гэж хариулжээ. Мэдэгдээгүй шалтгаанаа хаана



хандахаа мэдэхгүй, үр хүүхдийнхээ нэр төрийг бодсон, дарамт шахалтаас айсан, хандаад нэмэргүй байсан, өвчтэй, хэвтэрт гарах боломжгүй гэж тайлбарлажээ.⁵

Нөгөөтээгүүр, гэр бүлийн хүчирхийлэл нь зөвхөн гэр бүлийн гишүүдийн хооронд үүссэн үл ялих маргаан бус хүний бие махбодь, сэтгэл санаа, эрүүл мэнд, өөртөө итгэх итгэл, нэр төр, алдар хүнд болон өөрөө шийдвэр гаргах эрхэд бүхэлд нь халдсан нийгмийн аюулын шинж чанар ихтэй, ноцтой хэрэг бөгөөд далд хэлбэрээр удаан хугацаанд даамжрах нь илүү хохирол, хор уршиг учруулж, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөл болдог. Тухайлбал, 2011-2016 оны байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас 80 хүн амь насаа алдаж, 3299 хүн хүнд гэмтэл авсан бол гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүнийг алах гэмт хэрэг 2017 онд 12, 2018 онд 7, 2019 онд 12, 2020 онд 21 хэрэг тус тус үйлдэгджээ. Иймд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэг нь аюулын зэргийн үнэлгээг үнэн бодитой хийж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх юм.

Аюулын зэргийн үнэлгээ нь хүчирхийлэлд өртсөн хохирогчийн хувьд хамгийн чухал бөгөөд үнэлгээг хийлгэснээр дараагийн үйлчилгээнд холбон зуучлах, нөхцөл байдлыг үнэлэх зэрэг үндсэн суурь судлагдахуун болж өгдөг тул аль болох хялбар, түргэн шуурхай, бодитой үнэлэх боломжийг олгодог байх нь чухал юм.⁶

ГБХТХ-ийн 31 дүгээр зүйлд “Аюулын зэргийн үнэлгээ”-тэй холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд тус хуулийн 31.1-д “...Цагдаагийн алба хаагч хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийнэ...” гэж заажээ. Харин хуулийн төсөлд тус зохицуулалтыг илүү нарийвчилсан байдлаар буюу төслийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, гомдол, мэдээллийн тохиолдол бүрд хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийнэ” гэж тусгажээ. Энэ нь одоогийн хуулийн зохицуулалтаас ялгаатай нь гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, гомдол мэдээлэл тохиолдол бүрд аюулын зэргийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бүрдэж байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл даамжрах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд ихээхэн ач холбогдолтой эерэг нөлөөлөл бүхий зохицуулалт болж байна.

2. Төслийн зарим зохицуулалт⁷ хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслийн⁸ үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх зорилгод хүрсэн эсэхийг үнэлсэн байдал

⁵ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, ХЭҮК, УБ., 2023 он, 419 дэх тал.

⁶ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан журмуудын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, МУГХУСА33, 2023 он, 15 дахь тал.

⁷ Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1, 35.10 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг.

⁸ Хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ конвенцид нийцүүлэх зорилгоор боловсруулсан хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, 2024 он.

Тус хуулийн төслийн танилцуулгад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад хуульд ижил зохицуулалт агуулсан хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх санаачилгатай ажилласан этгээдийг урамшуулах, гэр бүлийн хүчирхийллийн тоон мэдээллийг бүртгэх, хөтлөх, солилцох харилцааг холбогдох хууль болох Хууль зүйн туслалцааны тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулахаар тусгаж давхардлыг⁹ арилгана гэж тусгажээ.

Хууль хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлын ач холбогдлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан 7 төрлийн үйлчилгээнээс¹⁰ зөвхөн эрх зүйн туслалцаа авах үйлчилгээний хүрээнд дурдвал, ХЗДХ-ийн сайдын тушаалаар баталсан эрх зүйн туслалцаа үзүүлэх журамд зөвхөн насанд хүрээгүй хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлэхээр зохицуулсан нь нийт гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамруулж чадаагүй байна. Иймд тус асуудлыг Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуультай уялдуулан зохицуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Түүнчлэн, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах талаар ЭХХШТХ, ЗШШТХ, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Прокурорын тухай хууль гэсэн нийтлэг хуулиудад зааснаас гадна Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд “Улсын ерөнхий прокурор хохирогчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран баталж, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авна” гэсний дагуу Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан журам”-ыг баталсан хэдий ч тус журамд хохирогчид авах хамгаалалтын арга хэмжээний төрлийг тодорхой заагаагүй¹¹ гэх мэт асуудлууд байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Тиймээс ч Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг бусад хууль тогтоомжтой уялдуулах, хуулийн давхардал, хийдлийг арилгах, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх зорилгоор хуульд өөрчлөлт оруулах нь зүйн хэрэг юм.

ГБХТтХ-ийн дор дурдсан зохицуулалтад дараах байдлаар өөрчлөлт оруулахаар хуулийн төсөлд тусгажээ.

ГБХТтХ болон хуулийн төслийн зохицуулалт

№	Зүйл, заалт	Хуулийн зохицуулалт	Төслийн зохицуулалт
1	2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,” гэсний дараа “ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, ” гэж нэмсүгэй.

⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2024 он.

¹⁰ Аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээ

¹¹ “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь /Судалгааны товч тайлан/, УБ, 2021, 16 дахь тал.


2	19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалт	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах;	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34.3 дахь хэсэгт заасан журмын дагуу урамшуулах.
3	35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг	Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлнэ.	Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.6-д заасан үйлчилгээг үзүүлнэ.
4	35 дугаар зүйлийн 35.10 дахь хэсэг	Түр хамгаалах байрны стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална.	Түр байрлуулан хамгаалах үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар зохицуулна.
5	37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг	Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн хохирогчид Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.7-д заасан үйлчилгээг үзүүлнэ.	Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмаар зохицуулна.
6	39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг	Хохирогчид өмгөөллийн үйлчилгээг хуульд заасан журмын дагуу үзүүлнэ.	Хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон харилцааг Хууль зүйн туслалцааны тухай хуулиар зохицуулна.
7	44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189.10-т заасан журмаар зохион байгуулна.

Төслийн дээрх зохицуулалтууд нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зохицуулалтыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хууль зүйн туслалцааны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуультай уялдуулан бусад хуулиар тусгайлан зохицуулсан харилцааг тухайн хуулиас эш татан хэрэглэх боломжийг бүрдүүлж, хууль хоорондын уялдаа холбоог хангахад чиглэсэн эерэг нөлөөлөл бүхий зохицуулалт болсон байна.

Иймд хуулийн төслийн дээрх зохицуулалтууд нь хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслийн үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, зорилгод хүрсэн байна.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудал нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль




гэх мэт хууль, эрх зүйн актуудаар зохицуулагдаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинэчлэн батлагдаж, хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан стандарт, журмууд батлагдан хэрэгжиж эхэлснээр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны ажиллах, үйлчилгээ үзүүлэх хууль эрх зүйн орчин бүрдэж, жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин сайжирсан.

Монгол Улсад хамгийн анхны түр хамгаалах байр Улаанбаатар хотод 1995 онд ХЭҮТ-ийн дэргэд байгуулагдаж байсан бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төв 2009 онд байгуулагдаж байсан бол 2023 оны байдлаар улсын хэмжээнд 21 аймаг, 6 дүүрэгт нийт 17 нэг цэгийн үйлчилгээний төв, 16 түр хамгаалах байр байгуулагдан ажиллаж байна. 2018-2020 онд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгээр 7 аймаг, 4 дүүрэгт нийт 11 нэг цэгийн үйлчилгээний төвийг байгуулжээ.

Үндэсний статистикийн хорооноос жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн талаарх иргэдийн мэдлэг хандлага, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны иргэдэд үзүүлэх үйлчилгээ, хүчин чадал, нөхцөл байдалд гарсан өөрчлөлтийг 2019 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулж үнэлж, дүгнэх, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн талаарх иргэдийн дундах мэдлэг мэдээллийн түвшин хэрхэн өөрчлөгдсөнийг өмнөх судалгаатай харьцуулж, дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж боловсруулах зорилгоор улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн гэр бүлийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх 31 нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр, 5050 хүнийг хамруулан¹² судалгаа хийжээ.

Тус судалгааны үр дүнгээс харвал, нэг цэгийн үйлчилгээний төвд 3 хүн тутмын 2 (75 хувь) нь хамгаалуулахыг хүсэж, 18 хувь нь очих газаргүйгээс, 7 хувь нь амь насаа аврахын тулд хандаж очжээ. Тэдний 35.6 хувь нь хүчирхийлэлд өртөж гэмтсэнээс, 34 хувь нь гэр орондоо байх аргагүй болсноос хандсан бол хүчирхийлэгчээс нуугдах (16.8 хувь) зорилгоор болон аав, ээж нь муудалцаад ээжийгээ дагаж ирсэн байсан. Эрэгтэйчүүдийн хувьд гэртээ баймааргүй санагдаад, бардам зан хөдлөөд, ичээд хэрэлдэж чадахгүй болохоороо зөвлөгөө авахаар ирсэн байна. Нэг цэгийн үйлчилгээний төвд ирээд хамгаалалтын (36.6 хувь), сэтгэл зүйн зөвлөгөө (13 хувь), эрүүл мэндийн (3 хувь) болон хууль зүйн туслалцаа (5хувь)-г дангаар болон хамтатган (42.4 хувь) авчээ. Тухайн үйлчлүүлэгчдийн 95 хувь нь хүсэж очсон үйлчилгээгээ бүрэн авч чадсан байна. Туслалцаа авч чадаагүй үйлчилгээнд нарийн мэргэжлийн эмнэлгийн үйлчилгээ болон өмгөөллийн туслалцаа орж байна. Мөн нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байрнаас үйлчилгээ авсан 3 хүн тутмын хоёрынх (64.5 хувь) нь амьдралд эерэг өөрчлөлт гарсан бол 3 хүн тутмын нэг нь ямар нэг өөрчлөлт гараагүй гэж үзсэн. Ямар өөрчлөлтүүд гарсан талаар тодруулахад дахин хүчирхийлэл үйлдэж болохгүй, хуультай гэдгийг нөхөр мэдсэн, архи уух нь багассан, дахин хүчирхийлэлд өртвөл хаана хандахаа мэддэг болсон, асуудлаа шийдвэрлэж чадсан, нөхөр архины эмчилгээнд явж архинаас гарч байгаа, зөвлөгөө авснаар хоорондын харилцаа дээрдэж, өөрчлөгдөж байгаа, асуудлыг хоорондоо сайн ярилцаж шийдвэрлэдэг болсон, гэр бүлийн тэнцвэртэй харилцаатай болсон, тайван байж шийдлээ олсон, өөртөө итгэлтэй болсон,

¹² “Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, хандлагыг үнэлэх /Судалгааны тайлан/, УБ, 2023, 54 дэх тал.



хүчирхийлэл үйлдэгчээс салсан, зодохоо больсон, сонголтоо хийж чаддаг болсон зэргээр хүн тус бүрд өөр өөр өөрчлөлт үр дүнг авчирсан байна. Байдал өмнөхөөсөө дордсон гэсэн хариулт гараагүй нь өмнө дурдсанчлан үйлчилгээний чанар, ажилтнуудын үр чадвар сайжирсантай холбоотой гэж үзэж болохоор байна.¹³

Мөн энэхүү судалгаагаар нийслэл, орон нутгуудад үйлчлүүлэгчдийн тоо, ажлын ачаалал харилцан адилгүй байгаа нь орон нутгийн иргэд үйлчилгээ авах боломж нь хязгаарлагдмал байна уу? эсвэл үйлчилгээ нь орон нутгийн иргэдэд тохиромжтой хэлбэрээр очиж чадах буй эсэх, үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмж, чанар, мэдээллийн нууцлал, аюулгүй байдалтай холбоотой юу гэдэг асуудлаар дахин нарийвчилсан судалгаа хийж үзэх шаардлагатай гэж үзсэн байна. Ингэснээр хүн хүчийг зөв хуваарилах, шаардлагатай байршилд хүний нөөц, ажиллах боломжийг нэмэгдүүлэх, зохион байгуулалтын өөр арга замуудыг судлан нэвтрүүлэх боломжуудыг шинэчлэн төлөвлөхөд чухал ач холбогдолтой¹⁴ болохыг дурджээ.

Харин Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь сэдэвт судалгааны товч тайланд ярилцлагад хамрагдсан хохирогчид нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ өөрсдөд нь ихээхэн ач холбогдолтой байсныг онцолсон бөгөөд хохирогчид өөр өөр дэмжлэг, үйлчилгээ авахын тулд олон газрын хаалга татаж, цаг зав, мөнгө, эрч хүчээ гарздах шаардлага гараагүй нь давхар дарамтад өртөөгүй гэдгийг дурдаж байна.¹⁵

ГБХТХ-ийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн 33.1-д заасан үйлчилгээг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш нэг цэгээс үзүүлэх чиг үүрэг бүхий нэгж нь **эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад** ажиллана” гэж заасан байсныг хуулийн төслийн хүрээнд өөрчилж эмнэлгийн байгууллагын дэргэд ажиллуулахаар заажээ. Тус хуулийн төслийн танилцуулгад дурдсанаар хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалттай Нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээг ялгамжтай байлгахын тулд нэг цэгийн үйлчилгээг зөвхөн эмнэлгийн байгууллагын дэргэд ажиллуулахаар тусгажээ.


“Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, хандлагыг үнэлэх” сэдэвт судалгааны тайланд “...*Нийслэлд ГССҮТ-ийн дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгчид улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлсэн жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдын 22.4 хувьд дангаараа үзүүлсэн, жил бүр үйлчлүүлэгчдийн тоо өсөлттэй байгаад анхаарч зохицуулалт хийж өргөтгөх бодит хэрэгцээ бий болсон байна...*” гэж дурджээ. Үүнээс, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хохирогчдын нэн тэргүүнд хандаж нэг цэгийн үйлчилгээ авах боломжит газар нь эмнэлгийн байгууллага болохын харж болох юм.

Тиймээс ч эмнэлгийн байгууллагын дэргэд нэг цэгийн үйлчилгээг ажиллуулах нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлж, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлж, анхан шатны

¹³ Мөн тэнд, 38 дахь тал.

¹⁴ Мөн тэнд, 43 дахь тал.

¹⁵ “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь /Судалгааны товч тайлан/”, УБ, 2021, 45 дахь тал.



нэгжид ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамтарсан багт бусад салбарынхантай хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлыг мэдээлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг хангахад чиглэсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 оноос хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд төрийн болон төрийн бус байгууллагаас гэр бүлийн хүчирхийллийн гаралт, түүний шалтгаан, нөхцөл мөн нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, хандлага, тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон хэд хэдэн судалгааны ажил хийгдсэн байна.¹⁶

2019 онд “Жендерт суурилсан хүчирхийллийг таслан зогсооход эрүүл мэндийн салбарын оролцоо” сэдэвт судалгаа, 2020 онд “Нэг цэгийн үйлчилгээний төв/түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгааны тайлан”, 2022 онд “Жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн стандартыг үнэлэх судалгаа”, 2023 онд “Жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээний бэлэн байдал үнэлгээний тайлан”, мөн тус онд хийгдсэн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан журмуудын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгааны ажил тус тус хийгджээ.

Энэхүү судалгааны ажлын үр дүнгээс харвал, аль ч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад хүчирхийллийн хохирогчид хувийн, нууцлалыг хангасан зөвлөгөө өгөх, тусламж үзүүлэх асуудлыг хэрхэн зохион байгуулах талаар дотоод журам, механизм болон гэр бүлийн хүчирхийллийн үйлчлүүлэгчид хувийн, нууцлал хангасан зөвлөгөө өгөх зориулалтын өрөө байхгүй байна. Хувийн, нууцлалыг хангасан өрөөнд тавигдах шаардлагыг стандарт нэг цэгийн үйлчилгээний байгууллага болон түр хамгаалах байранд тодорхой зааж өгөх нь чухал. Түүнчлэн, холбогдох байгууллага хоорондын уялдаа сул байгаагаас шалтгаалж стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх нь хязгаарлагдмал болж байна. Мөн нэг цэгийн үйлчилгээ төвд хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй, ахмад настай хохирогчдын онцлог хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх талаар тусгасан ч эдгээр хүмүүст зориулсан төрөлжсөн асрамж, халамж, сувилах үйлчилгээтэй холбоотой асуудал тусгагдаагүй байгааг дурдсан байна.

Хохирогчид бие махбодод нь халдаж цохиж зодсон ч гэмтэл учраагүй бол Зөрчлийн тухай хуулиар, хэрвээ хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол Эрүүгийн хуульд зааснаар шийдвэрлэх бөгөөд мөрдөгч шинжээч томилж гэмтлийн зэргийг тогтоодог. Гэвч зодуулсан гэх зөрчлийн хэрэг хамгийн их бүртгэгдсэн байгаа нь хохирогч шүүх эмнэлгийн дүгнэлт гаргуулах болон ирж очих замын зардалгүй, зодуулсан байдалтай гадуур явахаас санаа зовох, өш хонзонгоос айх зэрэг олон шалтгаанаар шүүх эмнэлэгт үзүүлэлгүй гэмтлийн зэрэг тогтоолгохгүй татгалзсан нь судалгаагаар нотлогдож байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмнэлэгт хэвтэх шаардлагатай болтлоо зодуулж бие махбодод нь гэмтэл учирсан тохиолдолд ч хууль сахиулах байгууллагын алба хаагчид гэмтлийн зэрэг тогтоолгохгүйгээр хэргийг Зөрчлийн тухай хуулийн дагуу мөрдөн шалгаж, хариуцлага тооцох хандлагатай байна. Иймд төлбөрийн

¹⁶ МУГХУСА33, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан журмуудын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”, УБ, 2023, 16 дахь тал.

чадваргүй хохирогчийг үнэ төлбөргүй гэмтлийн зэрэг тогтоолгох боломжийг бүрдүүлэх, өмгөөллийн туслалцаа үзүүлэх нь хохирогч төвтэй хандлага төлөвшүүлэхэд чухал үндэслэл болох байна.¹⁷

Нэг цэгийн үйлчилгээний төв нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүүхдийг хүчирхийлэл дарамтад өртсөнийг эрт шатанд илрүүлж, таслан зогсоохын тулд аюулгүй, хамгаалагдсан орчинд бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийн багийн цогц үйлчилгээг цаг алдалгүй чанартай, нэг цэгээс үзүүлэх зорилготой. Судалгаагаар 2022 онд нийслэлд 5, орон нутагт 11 түр хамгаалах байр, мөн нийслэлд 7, орон нутагт 10 нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж, 4795 хүнд 43 951 хоног буюу нэг үйлчлүүлэгчид ойролцоогоор 9 хоног байрлуулах үйлчилгээ үзүүлжээ.¹⁸

Төсөлд нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хэрхэн хангах талаар тусгажээ. Энэ нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан журмаар зохицуулж буй хохирогчид аюулын зэргийн үнэлгээ хийхтэй холбогдсон харилцаа, нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд цагдаагийн байгууллага хяналт тавихтай холбогдсон зохицуулалтыг хуульд тусгаж захиргааны хэм хэмжээний актын тоог бууруулах, тухайн асуудлыг хуулиар шийдвэрлэхэд чиглэсэн зохицуулалт болжээ.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Хуулийн төслийн зохицуулалт нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхэд дараах байдлаар дүн шинжилгээ хийсэн болно.

Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1.	Төслийн 3 дугаар зүйл	Төслийн 3 дугаар зүйл нь 1, 2, 4-9 гэсэн хэсгээс бүрджээ. Өөрөөр хэлбэл, төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг орхигдуулан 4-9 хүртэл дугаарласан байна.	Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дугаарлалтыг 3 болгож өөрчлөх. Ийнхүү өөрчилснөөр төслийн 3 дугаар зүйлийн 4-9 дэх хэсгийн дугаарт өөрчлөлт орж 3-8 дахь хэсэг болно.
2.	Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг	Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “... <i>тохиолдол бүрт</i> ...” гэж алдаатай бичсэн үгийг засах.	Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт алдаатай бичигдсэн “бүрт” гэх үгийг “ бүрд ” гэж засах.
3.	Төслийн 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсэг	Төслийн 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсэгт “...34.1-т заасан хамгаалалтын үйлчилгээг...” гэснийг өөрчлөх.	Төслийн 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсэгт “... 34.1-д заасан аюулгүй байдлын ”

¹⁷ “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь” судалгааны товч тайлан”, УБ, 2021, 16 дахь тал.


¹⁸ Мөн тэнд, 41 дэх тал.

			хамгаалалтын үйлчилгээг...” гэж өөрчлөх.
4.	Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг	Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт “... эмнэлэгийн” гэж алдаатай бичигдсэнг засах.	Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт алдаатай бичигдсэн үгийг “ ЭМНЭЛГИЙН ” гэж засах.
5.	Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалт Төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг Төслийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.2, 36.4 дэх хэсэг	Төслийн тус зүйл, заалтууд энэ хууль болон бусад хуулийн зүйл, заалтыг эш татсан бөгөөд ийнхүү эшлэхдээ тухайлбал, төслийн 36 дугаар зүйлийн 36.1-д “... энэ хуулийн 33.1-д... ” гэж, 36.2-т “...энэ хуулийн 33.1 дэх хэсэгт... ” гэж ялгамжтай байдлаар бичжээ.	Төслийн тус зүйл, заалтуудад энэ хууль болон бусад хуулиас эш татсан зүйл, заалтыг тусгахдаа бичилтийн нэг хэлбэртэй байвал илүү тохиромжтой. Тухайлбал, энэ хуулийн 33.1-д гэх мэт.
6.	Төслийн 36 дугаар зүйлийн 36.5.1 дэх заалт	Төслийн 36 дугаар зүйлийн 36.5.1-д “нэг цэгийн үйлчилгээний төвийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага эргүүлийн хяналт хэрэгжүүлэх” гэсэн нь найруулгын хувьд ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Иймд тус зохицуулалтыг өөрчлөн найруулах.	Төслийн 36 дугаар зүйлийн 36.5.1-д “нэг цэгийн үйлчилгээний төвийг тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан цагдаагийн байгууллага эргүүлийн хяналт хэрэгжүүлэх” гэж өөрчлөх.
7.	Төслийн 36 дугаар зүйлийн 36.5.2 дахь заалт	Төслийн 36 дугаар зүйлийн 36.5.2 дахь заалтад “теле камерыг 24 цагийн хяналтад” гэснийг төслийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасантай ижил байдлаар “24 цагийн турш” гэж бичих.	Төслийн 36 дугаар зүйлийн 36.5.2 дахь заалтыг “теле камерыг 24 цагийн турш хяналтад” гэж өөрчлөх.
8.	Төслийн 36 дугаар зүйлийн 36.5 дахь хэсэг	Төслийн 36 дугаар зүйлийн 36.5.2 дахь заалтыг давхардуулан дугаарласан байна.	Иймд дугаарлалтыг засаж төслийн 36 дугаар зүйлийн 36.5.2 дахь заалтын сүүлийн зохицуулалтыг 36.5.3 гэх.
9.	Төслийн 36 дугаар зүйлийн 36.5.3 дахь заалт	Төслийн 36 дугаар зүйлийн 36.5.3 дахь заалтыг дээр дурдсанчлан давхардуулан дугаарласан байна. Мөн энэ зохицуулалтад “... нэгийн үйлчилгээтэй...” гэж цэгийн гэх орхигдуулан бичжээ.	Төслийн 36 дугаар зүйлийн 36.5.3 дахь заалтад “ нэг цэгийн үйлчилгээтэй ” гэж засах.

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

ХЗДХЯ-наас Хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх зорилгоор боловсруулсан багц хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төслийн зорилгыг тодорхойлохдоо үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх болно гэж заасан байна.



Төслийн 7.4 дэх хэсэгт “Эрх бүхий байгууллагын хамгаалалтын тусгай алба энэ хуулийн 7.1.3-7.1.9-д заасан хамгаалалтад оролцсон, мэдсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн холбогдох албан тушаалтан, **алба хаагч** ...-аас нууцын баталгаа гаргуулна” гэж заажээ.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 28.1.2-т “**албан тушаалтан, албан хаагчид** төрийн болон албаны нууцыг ашиглах, хамгаалахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх” гэж; Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд **төрийн албан хаагч** гэж; Цагдаагийн албаны тухай хуулийн 5.2.1-д “дээд шатны цагдаагийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийг **доод шатны цагдаагийн байгууллага, алба хаагч** биелүүлэх” гэж; Төрийн бус байгууллагын тухай хуулийн 12.5 дахь хэсэгт Төрийн бус байгууллагын гишүүн, удирдах зөвлөлийн гишүүн, **ажилтан**... гэж¹⁹ тус тус хуульчлагджээ. Эдгээрээс үзэхэд тухайлбал, төрийн албан хаагч болон төрийн бус байгууллагын ажилтан гэх тогтсон ойлголт бийг харж болохоор байна.

Харин хуулийн төслийн дээрх заалтад төрийн алба хаагч, төрийн бус байгууллагын алба хаагч зэргээр хэрэглэгдэх оновчгүй нэр томьёо ашигласан байх тул хууль тогтоомжийг боловсронгуй болгох хуулийн төслийн зорилгод нийцээгүй байна гэж дүгнэх боломжтой. Иймд нийтлэг байдлаар илэрхийлэх үүднээс алба хаагч бус ажилтан, албан хаагч зэрэг тохирох хэлбэрээр тусгах нь зүйтэй.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

1. Хуулийн төслийн 7.4 дэх хэсэг


2/7.4-т “Эрх бүхий байгууллагын хамгаалалтын тусгай алба энэ хуулийн 7.1.3-7.1.9-д заасан хамгаалалтад оролцсон, мэдсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн холбогдох албан тушаалтан, алба хаагч...-аас **нууцын баталгаа** гаргуулна.” гэж заажээ. Уг хэсэгт нууцын баталгааг гаргах хэлбэрийг тусгаагүйгээс практикт нууцын баталгаа үйлдсэн эсэхийг нягтлах, батлахад хүндрэл учрахаар байна.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3.1-т Төрийн нууцтай танилцах эрхийг төрийн **нууцыг задруулахгүй байх баталгааг бичгээр гаргасан** байх шаардлагыг хангасан иргэнд олгохоор заасан байна. Мөн хуулийн 27.1.5-д албаны болон хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон, өөр ажил, албан тушаалд шилжих тохиолдолд өөрт нь итгэмжлэн хариуцуулсан төрийн болон албаны нууц тээгчийг зохих ёсоор хүлээлгэн өгөх, албан үүргийн хувьд танилцсан төрийн болон албаны **нууцыг задруулахгүй байх баталгааг бичгээр гаргах** зэргээр нууцын баталгааг бичгийн хэлбэрээр гаргаж баталгаажуулах хуульчлагдсан практик байгааг харж болохоор байна.

Нууцын баталгааг ямар хэлбэрээр гаргах нь хуулийн төсөлд тусгаагаагүй байх тул нууцын баталгааг гаргах хэлбэр, журмыг хуульчилснаар практик хэрэгжилтэд асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх юм.

2. Хуулийн төслийн 10.3, 10.5 дахь хэсэг

¹⁹ Судалгааны тайлангийн Харилцан уялдаа хэсгийн “Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;” хэсгийг үзнэ үү.



Хуулийн төслийн 3/10.5-д биечилсэн хамгаалалтын арга хэмжээг биечлэн, ил, далд гэсэн хэлбэрээр гүйцэтгэхээр заажээ. Эдгээрийг салгаж үзвэл “биечилсэн хамгаалалтын арга хэмжээг биечлэн гүйцэтгэнэ.” гэж бичигдсэн байх бөгөөд төсөлд биечлэн хамгаалалтыг тайлбарлаагүйгээс ойлгомжгүй байдлыг үүсгэжээ. Биечилсэн хамгаалалтын арга хэмжээ нь нэрнээсээ тодорхой байгаа буюу хамгаалагч гэрч, хохирогчийг хамгаалахдаа биечлэн хамгаалах гэсэн утгатай хамгаалалт байхаар байгаа нь “биечлэн хамгаалах” нь биечилсэн хамгаалалтын хэлбэр болоход оновчгүй байна.

Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/204 дугаар тушаалаар батлагдсан “Биечилсэн хамгаалалтын журам”-д энэхүү хамгаалалтын хэлбэрийг тодорхойлсон байх бөгөөд мөн орчны болон далд хамгаалалтын хэлбэрүүдийг тодорхойлжээ. Иймээс биечилсэн хамгаалалтын хэлбэрүүдийг хуулийн төсөлд заасан мөртөө холбогдох тодорхойлолтыг багтаагаагүй нь практикт хамгаалалтын эдгээр хэлбэрүүд хэрхэн хэрэглэгдэхэд тодорхойгүй байдлыг үүсгэж болзошгүй байна. Иймээс холбогдох хэлбэрүүдийг тодорхойлж хуулийн төсөлд тусгах нь зүйтэй. Мөн “биечлэн хамгаалах” гэснийг өөр үгээр тодорхойлох боломжтой юм.

Мөн дээрх хэлбэрүүд нь хуулийн төслийн 3/10.3-т “биечилсэн хамгаалалтыг...байрлаж болон хөдөлгөөнтэйгөөр, ил болон далд хэлбэрээр” гүйцэтгэхээр заасантай давхцаж байгааг анхаарах хэрэгтэй бөгөөд байрлаж болон хөдөлгөөнтэйгөөр хамгаалах, ил болон далд хэлбэр зэрэгт тайлбар хэрэгтэй гэж үзлээ.

3. Хуулийн төслийн 10.6.1-10.6.3 дахь заалт

Эдгээр заалтууд практикт хэрэгжихэд хоёр асуудал үүсэж байна. Нэгд, Нэгдүгээр түвшний хамгаалалтыг 24 цагаар, тодорхой хугацаанд тасралтгүйгээр зохион байгуулахаар заасан боловч Хоёр болон Гуравдугаар түвшний хамгаалалтыг хэдий хэр хугацаанд, хэрхэн зохион байгуулах нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл нэгдүгээр түвшний хамгаалалтыг зохион байгуулах нөхцөлүүдийг тусгасан бол бусад түвшинд ч адил тусгай зохицуулалт шаардлагатай юм.

Хоёрт, хамгаалалтын түвшин хоорондын ялгаа тодорхойгүй. Үүнээс үүдэн Нэг, Хоёр, Гуравдугаар түвшний аль түвшинд эсхүл ямар тохиолдолд хамгаалалтын арга хэмжээний аль хэлбэрийг хэрэгжүүлэх нь тодорхойгүй нөхцөлийг практикт бий болгохоор юм.

4. Хуулийн төслийн 13.10 дахь хэсэг

Уг хэсэгт Түр хамгаалах байрны үйлчилгээ үнэ төлбөргүй байх бөгөөд зардлыг улсын төсөв болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ гэжээ.

Цагдаагийн байгууллагаас Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу 2016 онд 42, 2017 онд 36, 2018 онд 65, 2019 онд 134, 2020 онд 101, 2021 онд 237, 2022 онд 261, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 86 нийт **962** иргэнийг хамгаалалтад авч, 945 аюулгүй байдлыг хангах хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж ажилласан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-т “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцох бөгөөд хувьсах зардлыг тооцох журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам” батлагдсан. Тус журмаар

гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнийг түр хамгаалах байранд байрлуулж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах нэг хүнд ногдох хувьсах зардлыг тооцох харилцааг зохицуулахаар заасан.

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар нийт 35 “Түр хамгаалах байр”, “Нэг цэгийн үйлчилгээний төв” үйл ажиллагаа явуулж байна. Эхний 11 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, насанд хүрээгүй иргэдийг хамгаалах, туслалцаа үзүүлэх чиглэлээр нийт 35 түр хамгаалах байраар үйлчлүүлсэн иргэдийн тоо 3807, үүнээс насанд хүрсэн эрэгтэй хүн 103, эмэгтэй хүн 1229, хүүхэд 2475 тус тус бүртгэгдсэн байна.

ГБХТХ-ийн хэрэгжилтийн үнэлгээний дүнгээс үзвэл түр хамгаалах байрны зардлын асуудлыг ХЗДХЯ, НХХЯ, ГХУСАЗ салбар зөвлөлөөс, Орон нутгийн ИТХ, ЗД, Олон улсын байгууллагаас, Цагдаагийн байгууллагаас гэх мэтээр харилцан адилгүй санхүүжүүлж байна. Иймээс дээрх хувьсах зардлыг тооцох журам дийлэнх тохиолдолд хэрэгждэггүй, баталсан төсвийн хүрээнд эсхүл ирсэн дэмжлэг туслалцаагаар үйл ажиллагаа явуулж өнөөг хүрсэн байх тул “улсын төсвөөс санхүүжнэ” гэсэн ерөнхий зохицуулалтыг нарийвчлан зохицуулах хэрэгтэй.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Зүйл заалт	Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал
1 дүгээр зүйл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасанчлан хуулийн төсөл нь хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл, үүний доторх хэсэг, хэсгийн доторх заалт, дэд заалт зэрэг бүтэцтэй байдаг. Тиймээс хуульд зүйл, заалт, хэсгийн алийг нь нэмж буйтай холбоотойгоор тухайн нэршлийг сонгон бичдэг. Харин хуульд 10.6.1-10.6.3 заалтыг нэмэхээр хуулийн төсөлд тусгагдсан байхад хуулийн төслийн нэгдүгээр зүйлд зөвхөн дараах “зүйл, хэсэг” нэмсүгэй гэж тусгасан байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.1.4-т заасны дагуу хэсгийн доторх заалтыг орхигдуулсан тохиолдол болсон байна.
2/7.4 дэх хэсэг	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1-д “... холбогдох албан тушаалтан, алба хаагч, гэрч хохирогч, түүний...” гэж тусгагдсан байна. Гэрч болон хохирогчийн аль алийг нь хамруулахын тулд гэрч, хохирогч хоёрын хооронд таслал тавих хэрэгтэй.
3/10 дугаар зүйлийн 10.3-10.9 дэх хэсэг:	Төслийн 1 дүгээр зүйлийн гуравт 10.3-10.10 дугаар хэсгийг нэмсэн ч “10 дугаар зүйлийн 10.3-10.9 дэх хэсэг” гэж заасан нь 10.10 дахь хэсгийг тусгаагүй орхигдуулсан байна.
3/10.3 дахь хэсэг	“байрлаж болон хөдөлгөөнтэйгээр” гэснийг хөдөлгөөнтэйгээр гэж засах;
3/10.4 дэх хэсэг	“нэг бүрийн хэрэгсэл биеийн хүчийг” энэ хэсгийн нэг бүрийн хэрэгсэл гэснийг араас таслал тавих;
3/10.9 дэх хэсэг	“...шийдвэрийг хүлээлгүй хамгаалалтанд...” гэснийг хамгаалалтад гэж өөрчлөх

3/10.10 дахь хэсэг	"...алба хаагч нь гэрч, хохирогчтой...гэрч, хохиргчийн талаар" гэж заасанд эхний гэрчийн араас таслал авах мөн хохирогчийн гэж өөрчлөх;
4/11.4 дэх хэсэг	11.4 дэх хэсгийн төгсгөлийн /"/ тэмдэглэгээг зөв харуулж байршуулах
6/21 ¹ .2 дахь хэсэг	21 ¹ .2. дахь хэсэгт "Энэ хуулийн 21 ¹ .1.заасан" гэснийг "21 ¹ .1-д заасан" гэж; мөн хэсгийн "байгуулана" гэж алдаатай бичсэн байх тул "байгуулна" гэж өөрчлөх.
6/21 ¹ .3.2 дахь заалт	21 ¹ .3.2 дахь заалтад 21-ийн штрикийг орхигдуулсан байна.
7/22.3.1 дэх заалт	"дарамт шахалт үзүүлсэн , дагаж мөрдсөн" гэх хэсгийн таслалын урд талын зайг хасах; Мөн заалтад "махбодид" гэж буруу бичсэн байгаа тул "махбодод" гэж өөрчлөх.
3 дугаар зүйл 1/12.9	Үүнд заасан "чадавхи" гэж бичсэнийг "чадавх" болгон өөрчлөх.

"Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Уг хуулийн төсөлд тийм хэсэг тусгагдаагүй.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	1. Хуулийн төслийн 3/10.3-т "Биечилсэн хамгаалалтыг энэ хуулийн 23.1-д заасан эрх бүхий байгууллагаас томилогдсон, хамгаалалтын ажлын чиглэлээр бэлтгэгдсэн алба хаагч /цаашид хамгаалагч гэх/ гүйцэтгэнэ." гэжээ. Монгол хэлний их тайлбар толь болон эрх зүйн эх толь бичигт " Албан хаагч "-ийг оюуны хөдөлмөр эрхлэн, тогтоосон хэмжээний цалин авдаг хүмүүс, улсын байгууллагын ажилтан; цалин авдаг биеийн хүчний

хөдөлмөрийн бус ба оюуны хөдөлмөр эрхэлдэг ажилтан;²⁰ гэж тус тус тодорхойлжээ. Харин “**Алба хаагч**” нь биеийн хүчний ажилтай холбоотой буюу тухайлбал, Цагдаагийн албаны тухай хууль болон Цэргийн албаны тухай хуулиудад заасанчлан цагдаагийн алба хаагч, цэргийн жинхэнэ алба хаагч зэргээр хэрэглэгддэг байна.

ГХХТХ-ийн 23.1-ийн дагуу биечилсэн хамгаалалтыг гүйцэтгэх хамгаалагч Цагдаагийн алба болон Авлигатай тэмцэх газраас томилогдохоор байна. Гэтэл дээр дурдсанчлан цагдаагийн алба хаагч гэж хэрэглэгдэх боловч Авлигын эсрэг хуульд алба хаагч гэж тусгагдаагүй бөгөөд Авлигатай тэмцэх газрын албан хаагч гэж хуульчлагдсан байна. Энэ нь хуулийн төсөлд заасны дагуу “авлигатай тэмцэх газраас томилогдсон алба хаагч” гэж хууль тогтоомжид тусгагдаагүй нэр томъёог хэрэглэсэн байх боломжтой байна.

Гэхдээ Хөдөлмөрийн тухай хуулийн 8.3.2-т “хугацаат цэргийн **албан хаагчийн**” гэж орсноос үзэхэд алба хаагч, албан хаагч гэсэн нэр томъёог ижил утгаар ойлгох боломжтой мэт харагдаж байна.

Иймд хуулийн төслийн холбогдох хэсэгт тусгагдсан “алба хаагч” гэснийг оновчтой хэрэглэсэн эсэхийг нягтлах шаардлагатай гэж дүгнэлээ.

2. Төслийн 22.3.1-т зааснаар “гэрч, хохирогчийг ... дагаж мөрдсөн бол эрсдэлийн өндөр түвшин” байхаар заасан байна. “Дагаж мөрдөх” гэдгийг хууль зүйн толь бичигт тодорхойлохдоо “олон улсын хүний эрх зүйд эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон зан үйлийн стандартын хүрээнд төрөөс үйл ажиллагаагаа явуулах. Хэрэв энэхүү үйл ажиллагаа нь уг стандартад нийцээгүй тохиолдолд төр хүлээсэн үүргээ үл биелүүлсэнд тооцогдоно.”²¹ гэжээ. Өөрөөр хэлбэл дагаж мөрдөх гэдэг нь англиар *compliance* буюу жишээлбэл, хууль тогтоомжийг дагаж мөрдөх гэх агуулгатай утга нэг байна. Мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд “олон улсын гэрээг дагаж мөрдөх, хуулийг дагаж мөрдөх” зэргээр хуульчлагдсан бөгөөд бусад хууль тогтоомжид ч мөн адил дагаж мөрдөх огноог илэрхийлсэн агуулгаар тусгагдаж байна.

Харин “мөрдөлт” гэдэг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотолгооны зүйлд хамаарах нөхцөл байдлыг тодорхойлохын тулд зайлшгүй чухал ба хангалттай нотлох баримтыг цугларуулах ба шалгах” гэж “мөрдөн мөшгих” гэдэг нь хувь хүн эсхүл бүлэг хүмүүст төр буюу эсхүл түүний төлөөлөгчид санаатайгаар ноцтой дарамт шахалт үзүүлэх, гэмтэл учруулах, зовлон зүдгүүр, түгшүүр бий болгох²² гэж ойлгогддог. Үүнээс гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8.1-д “Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, **мөрдөн мөшгих**, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглоно.” гэж заасан нь эдгээр үйлдлүүд “дагаж мөрдөх” гэснээс ялгаатай буюу тухайн этгээд, гэрч, хохирогчийн араас эрх бүхий төрийн

²⁰ С. Нарангэрэл, “Эрх зүйн эрх толь бичиг, Dictionary of Law, Анхны хэвлэл”, УБ, 2007, 31 дэх тал.

²¹ С. Нарангэрэл, “Эрх зүйн эрх толь бичиг, Dictionary of Law, Анхны хэвлэл”, УБ, 2007, 166 дахь тал.

²² С. Нарангэрэл, “Эрх зүйн эрх толь бичиг, Dictionary of Law, Анхны хэвлэл”, УБ, 2007, 290-292 дахь тал.

	<p>байгууллага, алба хаагчийн мөрдөх албан ёсны үйлдлийг илэрхийлж байна гэж үзэж болохоор байна.</p> <p>Түүнчлэн мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгих болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ хамаарна.” гэж зааснаас үзэхэд хуульд аль хэдийн дагаж мөшгих гэсэн нэр томъёог ашигласан байна. Иймд хуулийн төслийн 22.3.1 дэх заалтын “дагаж мөрдөх” гэсэн үйлдэл нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгодоо нийцээгүй байх тул хуулийн нэгмөр байдлыг хадгалах, агуулгыг тодорхой болгохын тулд “хууль бусаар мөрдөн мөшгих”, “хууль бусаар дагаж мөшгих” зэрэг агуулгаар тусгах нь оновчтой гэж үзэж байна.</p> <p>3. Хуулийн төслийн 5/21¹. 1. дэх хэсэгт “... цагдаагийн байгууллагын эрүүгийн цагдаагийн нэгж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.” гэж заажээ.</p> <p>Хууль тогтоомжоор аливаа байгууллагыг зайлшгүй тохиолдлоос бусад үед, тухайн байгууллагын нэр солигдоход холбогдох бүх хуулиудад зөвхөн нэртэй холбоотой өөрчлөлт оруулахгүйн тулд шууд тухайлан нэрлэн заахаас зайлсхийдэг. Жишээлбэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, төв байгууллага зэргээр хуульчилжээ. Уг хуулийн төслийн дээрх хэсэгт мөн “цагдаагийн байгууллага” гэж ерөнхий байдлаар нэрлэн оруулсан байх тул 5/21¹. 1. дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяа” гэж тусгах нь оновчтой юм.</p> <p>4. 21¹.3.2 дахь заалтад “хоригдогч” гэсэн хэллэгийг ашигласан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 195.5-д “Хорих ял эдэлж байгаа ялтанг “хоригдол” гэнэ.” гээд “хоригдогч” гэх хэллэгийг тодорхойлоогүй байна. Харин Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд зааснаар “Баривчлагдсан, цагдан хоригдсон этгээд /цаашид "хоригдсон этгээд" гэх/” гэж тусгагдсаныг харж болно. Иймд дээрх хуульд нийцүүлэн “хоригдсон этгээд” гэх зэргээр нэрлэн тусгавал оновчтой гэж үзлээ.</p> <p>5. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1/12.8 дахь хэсэгт “эрх бүхий байгууллага өөрийн хүн хүч, техникээр хамгаалалтыг зохион байгуулах” гэсэн байна. Хуульд хамгаалалтын арга хэмжээ гэсэн нэршлээр тусгагдсан байх тул хуулийн нэр томъёотой нийцүүлэх нь зүйтэй. Мөн зүйлд “харуул хамгаалалтын байгууллага” гэсэн нь сул үгтэй бичигдсэн бөгөөд хуульд заасан нэр томъёоноос зөрүүтэй байна.</p>
<p>Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;</p>	<p>1. Хуулийн төслийн 21¹.2. дахь хэсэгт Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах гэрээг байгуулахдаа хамгаалалтын төрлөөс хамаарч байгуулахаар заасан байна. ГХХТХ-ийн 6.1-д зааснаар Хамгаалалтын арга хэмжээ нь аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ; сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ гэсэн 2 төрлөөс бүрдэж байна. Үүнээс, гэрээг байгуулахад хамгаалалтын арга хэмжээний төрлөөс хамаарч өөр өөр гэрээний загвараар гэрээ байгуулах ёстой нөхцөл үүсжээ. Энэ нь цаашид хэрхэн, яаж ялгарах нь тодорхойгүй байна. Мөн гэрээний аль тохирохыг</p>

	<p>байгуулахыг заасан заалт нь хамгаалалтын бүх арга хэмжээнд ялгамжгүй хамаарах тул ийм ялгаа үүсгэсэн байдлыг арилгах нь зүйтэй.</p> <p>Түүнчлэн хамгаалалтын төрөл гэдэг нь хуульд заасан нэр томъёоноос зөрүүтэй байх тул “хамгаалалтын арга хэмжээ” гэсэн хуулийн нэршлийг хэрэглэх нь оновчтой юм.</p> <p>2. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1/12.1, 12.2-т “тусгай техник хэрэгсэл” гэж дундаа таслалгүй орсон байхад 12.4, 12.5-п “техник, хэрэгсэл” гэж тусгагдсан байгаа нь хуулийн төслийн заалтуудын дотоод нийцэлгүй байдлыг үүсгэж байна.</p> <p>Мөн 12.6-д “тусгай хэрэгсэл, техникийг” гэж нэр томъёоны байрлал нь өөрчлөгдсөн байна.</p>
<p>Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;</p>	<p>1. 2/7.4, 3/10.10 дахь хэсэг</p> <p>3/10.10 дахь хэсэгт зааснаар биечилсэн хамгаалалт гүйцэтгэж буй алба хаагч нь гэрч, хохирогчтой ... дур мэдэн гадны хүн нэвтрүүлэх, ...гэрч, хохирогчийн талаар мэдээлэл дамжуулахыг хориглохоор байна.</p> <p>Харин 2/7.4-т “Эрх бүхий байгууллагын хамгаалалтын тусгай алба энэ хуулийн 7.1.3-7.1.9-д заасан хамгаалалтад оролцсон, мэдсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн холбогдох албан тушаалтан, алба хаагч...-аас нууцын баталгаа гаргуулна” гэж заажээ. Төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгааны маягтад тухайн этгээд албан тушаал, ажил үүргийн дагуу танилцсан, эсхүл мэдсэн төрийн болон албаны нууцыг чанд хадгалж, хамгаалахаа баталж, өөрт танилцуулагдсан төрийн болон албаны нууцыг задруулсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны хариуцлага хүлээхийг ухамсарлаж буйг илтгэсэн байдаг. Өөрөөр хэлбэл нууцын баталгаа гэдэг нь манай тохиолдолд хуулийн 7.1.3-т заасан биечилсэн хамгаалалтад оролцогч, үүний талаар мэдсэн этгээд зэрэг нь нууцын баталгаа гаргаж гэрч, хохирогчийг биечлэн хамгаалалтын талаар холбогдох мэдээлэл, гэрч, хохирогчийн байршил зэргийг нууцлах үүргийг хуулийн төслийн 2/7.4 дэх хэсэгт баталгаажуулсан байна гэж үзэж болно. Гэтэл төслийн 3.10/10-т эдгээрийг дахин давтаж хориглосон хэсэг оруулсан байна. Иймд дээрх нууцын баталгаанд хамаарах хэсгүүдийг 3.10/10 дахь хэсгээс хасах саналтай байна.</p> <p>2. 21¹. 4. дэх хэсэгт Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогч нь ГХХтХ-ийн 18 дугаар зүйлд заасан туслалцааг авах, хамгаалалтын арга хэмжээний талаар санал, хүсэлт гаргах, хамгаалалтын арга хэмжээний болон өөрийн аюулгүй байдлын талаар мэдээллээр хангагдах эрхтэй гэжээ.</p> <p>Гэтэл ГХХтХ-ийн 18 дугаар зүйл нь энэ хуульд заасан бүх гэрч, хохирогчид хамаарах заалт байх тул үүнийг дахин давтан хуульчлах шаардлагагүй билээ.</p> <p>Мөн хуулийн 24.1-д “Хамгаалалтад байгаа гэрч, хохирогч энэ хуулийн 21.2-т заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй бөгөөд шийдвэрийг танилцуулснаас хойш 14 хоногийн дотор гомдлоо дээд шатны прокурор болон харьяалах шүүхэд гаргана.” гэж гомдол гаргах эрхийг олгосон. Хуулийн төсөлд зөвхөн</p>

	<p>хоригдож буй гэрч, хохирогчид санал, хүсэлт гаргах эрхийг олгосон нь хуулийн ижил төстэй заалтыг хэрэгцээгүй үед хоёр салгаж бичсэн гэж үзэж байна. Иймд хуулийн 24.1 дэх хэсэгт санал, хүсэлт гаргах эрхийг нэмж өөрчлөлт оруулах нь зүйтэй.</p> <p>Хуулийн 3.3 дахь хэсэгт хамгаалалтад байгаа хүн мэдээллээр хангагдах, мэдээлэл задрахаас хамгаалагдах, өмч болон ажлын байраа хадгалуулах эрхийг заасан байна. Харин хуулийн төслийн дээрх хэсэгт мэдээлэл хангагдах эрхийг нарийвчилж 2 төрлийн мэдээллээр хангагдах эрхийг олгожээ. Энэ нь хэдий нарийвчилсан зохицуулалт боловч мэдээлэл авах эрхийг хязгаарласан зохицуулалт болж болзошгүйг анхаарах хэрэгтэй. Мөн нэгэнт хуулийн 3.3-т уг эрхийг хангасан байх тул эдгээр нэмэлтийг хуулийн мөн зүйл хэсэгт тусгах нь ач холбогдолтой.</p> <p>3. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1/12.8 дахь хэсэгт эрх бүхий байгууллага өөрийн хүн хүч, техникээр хамгаалалтыг зохион байгуулах боломжгүй тохиолдолд гэрээт харуул хамгаалалтын байгууллагаар зарим ажил үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхээр заажээ. Эдгээр үйл ажиллагааг төслийн 12.2 дахь хэсэгт нэг бүрчлэн тоочсон байгаа бөгөөд 12.8 дахь хэсэгт мөн дахин тоочсон нь хууль тогтоомжийн хэмнэлтийн зарчимд харшилж байна. Иймд "... гэрээт хамгаалалтын байгууллагаар 12.2.1-12.2.5-д заасан техник, хэрэгсэл ашиглахтай холбоотой ажил үүргийг гэрээгээр гүйцэтгүүлж болно." гэж өөрчлөх нь зүйтэй.</p>
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

<p>Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;</p>	<p>Тухайн хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.</p>
<p>Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>4.10.15. хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>4.10.16. хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.</p>	<p>3/10.10 дахь хэсэг</p> <p>Хуулийн төслийн 3.10/10-т зааснаар хамгаалалт гүйцэтгэж буй алба хаагч нь гэрч, хохирогчтой хувийн харилцаа тогтоох, хууль бус хүсэлт тавих зэрэг хориглосон хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага тусгагдаагүй байна.</p> <p>Хуулийн 27.1 дэх хэсгийг авч үзвэл “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль тогтоомжийг зөрчсөн хүнд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заажээ. Харин холбогдох хууль гэдэгт Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль хамрагдана гэж үзвэл эдгээр хуулиудад хамгаалалтын ажилтан гэрч, хохирогчид хууль бус хүсэлт тавьсан бол эсхүл хувийн харилцаа тогтоосон бол хэрхэх талаар зохицуулагдаагүй байх тул энэ нь хуулийг хэрэгжүүлэхэд хийдлийг бий болгож байна.</p>

ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Дайчилгааны тухай хуулийн 4.5 дахь хэсэгт зааснаар улсын дайчилгаа явуулахад дараах үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- 4.5.1.дайчилгаа явуулах шийдвэр гаргах;
- 4.5.2.дайчилгааны зарлан мэдээллийг явуулах;
- 4.5.3.зэвсэгт хүчнийг байлдааны цагийн орон тоогоор өргөтгөн зохион байгуулах;
- 4.5.4.төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг дайчилгаа зохион байгуулах горимд шилжүүлэх;
- 4.5.5.улсын санхүүгийн нөөцийг дахин хуваарилах;
- 4.5.6.зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд шилжүүлэх, түүний ажиллагааг дэмжих дайчилгааны даалгавартай нэгжийг байгуулах;
- 4.5.7.тээврийн байгууллагын үйл ажиллагааг дайчилгааны горимд шилжүүлэх;
- 4.5.8. хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулах;**
- 4.5.9.хүн амыг амьжиргааны зайлшгүй хэрэгцээт бүтээгдэхүүнээр хуваарилан хангахад бэлтгэх;
- 4.5.10.дайчилгааны даалгаврын дагуу хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг шаардлагатай нөхцөлд нүүлгэн шилжүүлэх.

Хуулийн төсөлд Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.5.8 дахь хэсгийг хүчингүй болгохоор тусгажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно” гэж, “тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.” Гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, онц болон дайны байдал зарласан тохиолдолд хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг тодорхой шалгуураар хязгаарлаж болох юм.

НҮБ-ийн Ерөнхий Ассамблейс 2011 онд гаргасан Үзэл, бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай тусгай илтгэгчийн тайланд зааснаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах аливаа хязгаарлалт нь дараах үндсэн хэсгээс бүрдсэн, кумулятив шалгуурыг давах ёстой. Үүнд:

(а) Хязгаарлалтыг тодорхой бөгөөд хүн бүрд хүртээмжтэй байдлаар хуулиар зохицуулсан байх;

(b) Хязгаарлалтын зорилго нь “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-н 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зорилгуудад хамааралтай байх. Үүнд (i) бусдын эрх, нэр төрийг хамгаалах эсхүл (ii) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах;

(c) Хязгаарлалт нь зайлшгүй шаардлагатай бөгөөд хүний эрхийг хамгийн багаар хязгаарласан байх;

(d) Түүнчлэн иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж буй хуулийг аливаа улс төр, бизнес, бусад ашиг сонирхлоос ангид, бие даасан

байгууллага хянадаг бөгөөд ингэхдээ аливаа дур зорog, ялгаварлан гадуурхах байдлаас ангид байх ёстой.²³

Дайчилгааны тухай хуулийн 3.1.14 дэх хэсэгт "Дайчилгаа" гэж улс орны эдийн засаг, нийгмийг шаардлагатай үед дайны байдалд шилжүүлэх, зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион байгуулахын тулд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгааны болон санхүүгийн нөөцийг дахин хуваарилах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээг" ойлгохоор заасан байна. Өөрөөр хэлбэл дайны байдалд шилжүүлэх арга хэмжээг дайчилгаа гэж ойлгож байна. Иймд дайны байдал зарласан үед хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гагцхүү хуульд заасан үндэслэл журмаар хязгаарлалт тавих нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, конвенцоор хүлээн зөвшөөрөгдсөн. Гэвч Дайчилгааны тухай хуульд хэвлэл мэдээллийн хэрэгслийг зохицуулахаар заасан ч хангалттай журам тогтоогоогүй нь хүний эрхийг өргөнөөр хязгаарлах нөхцөл бүрдүүлнэ.

Үүнтэй төсөөтэй харилцааг авч үзвэл, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 9.13 дахь хэсэгт заасныг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нарын 2020 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн А/200, А/169 дүгээр хамтарсан тушаалаар "Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам"- г баталсан.

Гамшгийн үед олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх арга хэмжээ авах нь Үндсэн хуулиар зөвшөөрөгдөх боловч хязгаарлалт нь зайлшгүй шаардлагатай бөгөөд хүний эрхийг хамгийн багаар хязгаарласан байх зарчмыг хангахад чиглэсэн тодорхой зохицуулалтгүйгээс гадна цахим орчинд журмаар хяналт тавьж байгааг Үндсэн хуулийн зөрчил гэж үзэх нь бий.

Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8 дахь хэсэг хэт ерөнхий байгаагаас хүний эрх өргөнөөр хязгаарлагдах эрсдэлийг бий болгож байгаа тул түүнийг хүчингүй болгох нь боломжит хувилбар боловч нөгөө талаас дайчилгааг зарласан тохиолдолд хууль зүйн үндэслэлгүйгээр эсхүл журмаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл эсхүл цахим орчинд хяналт тогтоох эрсдэл үүсэж болзошгүйг мөн анхаарах нь зүйтэй.

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ


“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

1. Төсөлд тусгасан албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээтэй холбоотой зохицуулалт Эрүүгийн хууль, хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслийн зорилгод хүрсэн эсэхийг үнэлсэн байдал

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж²⁴ улмаар Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оноос эхлэн дагаж мөрдөх болсон билээ.

²³ La Rue, Frank, UN. Human Rights Council, Special Rapporteur on the Promotion and Protection of the Right to Freedom of Opinion and Expression, 2011.05.27. <https://digitallibrary.un.org/record/706200>.

²⁴ Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, УБ., 2013 он.



Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлд энэ хуулийн зорилгыг *“Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино”* хэмээн тодорхойлжээ. Үүнээс үзвэл, Эрүүгийн хуулийн үндсэн зорилгын нэг нь хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон харилцааг зохицуулах явдал болох нь харагдаж байна.

Мөн хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг олон улсын гэрээ конвенцид нийцүүлэх зорилгоор боловсруулсан хүний эрхийн багц хуулийн төсөл нь үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх зорилготой.

Түүнчлэн, Төслийн 7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт *“...Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөл байдалд гэмт хэрэг үйлдсэн хүнийг эмчлэх, гэмт хэрэг дахин үйлдэх, өөртөө аюул учруулахаас урьдчилан сэргийлгэх зорилготой байна...”* гэсэн нь Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлд заасан *“Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино”* гэсэн зорилготой шууд холбогдож байна. Иймд дээрх зорилгод хүрэх байдлын хүрээнд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг сонгон авч судаллаа.


Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс 2001-2023 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлын талаарх нийт 22 удаагийн илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн хүний эрхийг хангах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг арилгах, хүний эрхийг хамгаалахтай холбоотой саналыг танилцуулж, илтгэлийн мөрөөр авах арга хэмжээний талаар Улсын Их Хурлаас холбогдох шийдвэрүүдийг баталж ирсэн.

2023 онд Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын 22 дахь илтгэлийг Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрлөх эрх, хүүхдийн эрх, ахмад настны эрх, хүний эрхийг хамгаалагчийн эрх, улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал гэсэн 7 сэдвийн хүрээнд боловсруулсан бөгөөд “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ ба хүний эрхийн асуудал” сэдвээр тусгайлан дүн шинжилгээ хийж, дүгнэлт, санал боловсруулсан байна. Ингэхдээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд хууль ёсны төлөөлөгчийн оролцоог хангах, төрөл дэглэм, хугацаа тогтоож буй байдлын талаар²⁵ дурджээ. Тухайлбал, Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэхийг шийдвэрлэх шүүх хуралдаанд хэрэгт холбогдсон сэтгэцийн өвчтэй болон хэрэг хариуцах чадваргүй хүнд хуульд заасны дагуу хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч оролцуулах арга хэмжээ авахгүй байгаа нь хүний эрхийн зөрчил юм. 2012-2021 онд Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй 144 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэр гарсан байх бөгөөд шүүх сэтгэц эмгэг судлалын магадлагааг үндэслэж, 144 тохиолдлын 51 хүнд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ хууль ёсны төлөөлөгчийг оролцуулаагүй бол 3 хүнд холбогдох

²⁵ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2024 он.

хэргийг шийдвэрлэхдээ өмгөөлүүлэх эрхийг хангаж заавал өмгөөлөгч оролцоно гэсэн хуулийн заалтыг биелүүлээгүй байна.²⁶

Шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан байдал /2012-2022 он/



Дээр дурдсанчлан, 2012-2021 онд нийт 144 хүнд шүүхээс эмнэлгийн чанартай хэмжээ авсан бол 2022 онд 23 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан байна. Шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авч шийдвэрлэсэн хэргээс цөөн тохиолдолд шинжээч эмч шүүхийн хэлэлцүүлэгт оролцож, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх хугацааны талаар санал гаргасан байх ба ихэнх тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар албадан эмчлэх хугацааг тогтоосон бол зарим шүүхийн шийдвэрт албадан эмчлэх хугацааг тогтоогоогүй байна.


Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 7.6 дугаар зүйлд албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээний хугацааг дараах байдлаар тогтоож өгсөн байна. Үүнд:

- Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэсэн бол **нэг жил тутам** сэтгэцийн эрүүл мэндийн төв эмнэлгийн магадлан тогтоох комисс өвчний шинж байдлын талаар дүгнэлт гаргах /Төслийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/;
- Донтох эмгэг судлалын тасагт албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх хугацаа **12 сар хүртэл** байна /Төслийн 7.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/;
- Хорих ял шийтгэгдсэний дараа сэтгэцийн өвчний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон этгээдэд шүүх эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэсэн бол **ялтны эдлээгүй үлдсэн хорих ялтай тэнцүү** хугацаагаар хэрэглэх /Төслийн 7.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг/;
- Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх **дээд хугацаа** нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тухайн гэмт хэрэгт оногдуулж болох хорих **ялын дээд хэмжээнээс** хэтэрч болохгүй /Төслийн 7.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг/ гэж заажээ.

Тус албадлагын арга хэмжээг хэрэглэх хугацааг тодорхой байдлаар зааж өгснөөр тус хуулийн зохицуулалтыг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, хүний эрхийг хангах зэрэг эерэг нөлөөллийг бий болгож байна.

2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт 39 хүнд шүүхийн шийдвэрийн дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэн албадан

²⁶ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, ХЭҮК, 2023 он, 87 дахь тал.



эмчилж байгаа хэдий ч дээрх 39 хүний 13 буюу 33.3 хувьд нь ямар хугацаагаар албадан эмчлэхийг шүүх шийдвэртээ тусгаагүй бол 26 хүнд 1 сараас 8 жил хүртэл хугацаагаар уг арга хэмжээг хэрэглэхээр шүүхийн шийдвэрт тогтоожээ. Түүнчлэн, шүүхийн шийдвэрээр тогтоосон хугацаанд сэтгэцийн байдал нь засрал сайжрал олоогүй, эдгэрээгүй бол тухайн этгээдэд хэрэглэсэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг хэрхэн тогтоож, ямар хугацаагаар сунгах нь тодорхойгүй байна. Тухайлбал, шүүхээс хугацааг тогтоогоогүй 13 хүнийг засрал сайжрал олоогүй үндэслэлээр 5-20 жилийн хугацаагаар тус байгууллагад үргэлжлүүлэн албадан эмчилж байна.²⁷ Энэ нь Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлд заасан зохицуулалтад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг тодорхой зохицуулж хуульчлаагүйтэй холбоотой.

Одоогийн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлийн 7-д *“Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно”* гэж заасан. Хэдийгээр Эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно гэж заасан ч практикт сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдолын улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон этгээдийн сэтгэцийн эмгэг хэзээ засарч сайжрахыг шинжээчийн дүгнэлтээр урьдчилан тогтоох боломжгүй гэж шинжээч эмч нар үзэж байна. Судалгаанаас харахад цөөн тохиолдолд шинжээч эмч шүүхийн хэлэлцүүлэгт оролцож хугацааны талаар санал гаргасан байх ба ихэнх тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар хугацааг тогтоосон, зарим тохиолдолд шүүхийн шийдвэрт огт хугацаа заагаагүй байгаа нь практикт эмчилгээний хугацаатай холбоотой маргаантай асуудал байсаар байна.

Манай улсын хувьд Эрүүгийн хууль болон ЭХХШТХ-д эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно гэж ерөнхий байдлаар хуульчилсан нь хүний эрхийг хамгаалах, шүүхийн шийдвэрийг тодорхой хугацаанд хянах үр нөлөөтэй тогтолцоо биш юм. Өөрөөр хэлбэл, хүний эрхийг хязгаарлаж, тодорхой орчинд хяналттайгаар байлгах хугацааг зөвхөн хуулиар нарийвчлан тогтоох боломжгүй бөгөөд мэргэжлийн байгууллагын (эмнэлгийн) дүгнэлтээр тухай бүр шийдвэрлэж байх ёстой. Гадаад орны туршлага, хууль тогтоомжийн харьцуулсан судалгаанаас үзэхэд шүүхийн шийдвэрт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх хугацааг заадаггүй бөгөөд анагаах ухааны практикт сэтгэцийн өвчний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон этгээдийн сэтгэцийн эмгэг хэзээ засарч сайжрахыг шинжээчийн дүгнэлт ч урьдчилан тогтоох боломжгүй гэж үздэг.

Харин албадан эмчилгээний хугацааг эмчлэгч эмч тухайн өвчний эмчилгээний тактик, үр дүн, оношилгоо эмчилгээний стандарт, удирдамж, өвчтөний биеийн байдлаас хамаарч тогтоох нь түгээмэл юм. Ихэнх улсад 6 сар тутам шинжээчийн дүгнэлтийг үндэслэн албадан эмчилгээг үргэлжлүүлэх, дуусгавар болгох, хугацаа сунгах эсэхийг шүүх хянан шийдвэрлэдэг байна. Тухайлбал, ОХУ, БНКУ, Япон Улс, Бельгийн Хаант Улс, Израил Улсад 6 сар тутам, Грек Улсад 2 жил тутамд шинжээчийн дүгнэлтийг үндэслэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэх, сунгах, зогсоох асуудлыг шийдвэрлэдэг.

²⁷ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, ХЭҮК, 2023 он, 89 дэх тал.

Төслийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тус асуудлыг “...Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэсэн бол нэг жил тутам Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Магадлан тогтоох комисс өвчний шинж байдлын талаар дүгнэлт гаргаж, уг дүгнэлтийг харгалзан хугацааг сунгах, өөрчлөх, зогсоох эсэхийг шүүх шийдвэрлэнэ...” гэж тусгасан нь дээрх улс орнуудын туршлагатай нийцэж байна. Мөн төслийн 7.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “...Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ авагдсан хүнд оношилгооны болон эмчилгээний туршилт хийхийг хориглоно...” гэж заасан нь Эрүүгийн хуулийн зорилго, хүний эрхийн багц хуулийн төслийн зорилгод нийцэж байна.

2. Төслийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн зохицуулалт Эрүүгийн хууль, хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслийн зорилгод хүрсэн эсэхийг үнэлсэн байдал


Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т “...халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй...” гэж, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэж, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй” гэж тус тус заасан байдаг. Энэ үүднээс “Эрүү шүүлтээс ангид байх эрх” нь хүний жам ёсны эрх бөгөөд ямар ч үед үл хязгаарлагдах, онцгой эрх юм.

Манай улсын хувьд Монгол Улсын Үндсэн хууль болон эрүүдэн шүүлтээс ангид байх эрхийг хангах, хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээхтэй холбогдох зохицуулалт бүхий 13 хууль тогтоомж, олон улсын олон талт 10 гэрээ, нийт 24 эрх зүйн эх сурвалжаар уг эрхтэй холбогдох харилцааг зохицуулж байна.²⁸

Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1984 онд баталсан Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орж, соёрхон баталсан бөгөөд тус конвенцын нэмэлт протоколд 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр нэгдэн орсон. Энэхүү конвенцийн хэрэгжилттэй холбогдуулан НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын тайланд өгсөн зөвлөмжид Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг конвенцын 1 дүгээр зүйлд заасан “аливаа байдлаар алагчилж, эсхүл айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор эрүүдэн шүүх, мөн гуравдагч этгээдэд хамааралтай байх гэсэнтэй бүрэн нийцүүлэн тодорхойлохыг”²⁹ зөвлөжээ.

²⁸ Эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн Монгол Улс дахь төлөв байдалд хамаарах зарим асуудал /Лавлагаа/, ХЗҮХ, 2024 он.

²⁹ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2024 он.



Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хувьд манай улс 2015 оны Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд *“Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон”* гэж тодорхойлон хуульчилсан нь өмнөх 2002 оны Эрүүгийн хуульд тодорхойлсноос сайжруулсан зохицуулалт болсон хэдий ч тайлбар, мэдүүлэг авахаас бусад нотлох ажиллагааны хүрээнд эрүү шүүлт тулгахаас хамгаалж чадаагүй гэж зарим судлаачид үздэг.

Учир нь тухайн гэмт хэргийг зөвхөн тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор гэж хязгаарласнаас үүдэн бусад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүү шүүлтийн шинжтэй үйлдлүүд орхигдож байх үндэслэлтэй. Учир нь эрүү шүүлт гэдэг нь тодорхой мэдүүлэг буюу өөр бусад мэдээлэл авах зорилгоор албан тушаалтан болон түүний даалгаснаар сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогч буюу шинжээчид зориуд бие махбодын болон ёс суртахууны зовлон шаналал учруулсан өргөн хэмжээний үйлдэл бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд бий болдогтой холбоотой.

Манай улс сүүлийн жилүүдэд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд нэлээд олон хөтөлбөр, үйл ажиллагаа батлагдан хэрэгжиж эхэлсэн. Тухайлбал, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д *“Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно”* гэж; Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 77-д *“Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ”* гэж; Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дөрөв дэх хэсгийн “Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэчлэл”-ийн 4.4.12-д *“Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ”* гэж тус тус заасан байна.

Улсын Их Хурлын нэгдсэн чуулган, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар 2023 оны 4 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2022 оны тайланг хэлэлцүүлсэн. Тус тайлан хэлэлцсэнтэй холбогдуулан Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 4-ний өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоол батлагдаж, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт “ Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн зүйлчлэлд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор зааж тодорхойгүй байдал үүсгэж байгаа зохицуулалтыг өөрчлөх талаар болон эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгээс бусад нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг залруулах талаар хуулийн төсөл боловсруулж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор заасан.

Мөн ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланд дурдсанаар сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээнд эрүү шүүлт тулган мэдүүлэг авах, түүнийг нотлох баримтын хэмжээнд үнэлэх, хүний эрхийг зөрчих асуудал гарсаар байгааг тодорхойлсон байна. Ялангуяа цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунган эрүү шүүлтэд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст сүүлийн 5 жилийн байдлаар нийт 4165 гомдол ирсэн байна. Үүнээс халдашгүй чөлөөтэй байх эрх зөрчигдсөн талаар 722 гомдол ирснээс, **эрүү шүүлтээс ангид байх эрхтэй холбоотой 157**, хууль бусаар баривчлахтай холбоотой 61, хууль бусаар цагдан хорихтой холбоотой 257 гомдол, шударгаар шүүлгэх эрх зөрчигдсөн талаар нийт 834 гомдол ирснээс хилс хэрэгт холбогдсон тухай 328, нотлох баримт шалгуулах асуудлаар 55, шүүхэд гомдол гаргах талаар 102, хууль зүйн туслалцаа авах 297, хохирол нөхөн төлүүлэх 52 гомдол тус тус иржээ.³⁰ Харин 2016 оноос 2023 оны 03 дугаар сар хүртэлх хугацаанд ХЭҮК-т **эрүү шүүлтээс ангид байх 225**, хууль бусаар баривчлах 63, хууль бусаар цагдан хорих 321 буюу нийт 609 гомдлыг иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн байна.³¹


Иймээс ч сүүлийн жилүүдэд Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгтэй холбоотой асуудал олон нийтийн анхаарлын төвд байгаа бөгөөд Прокурорын байгууллагад 2022 онд Эрүү шүүлт тулгахтай холбоотой нийт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 19 хэрэг бүртгэгдсэнээс 4 хэргийг шүүхэд шилжүүлж, 8 хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан бол 2023 онд 29 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан байна.

Эрүүгийн хууль болон хуулийн төсөлд хэрхэн тусгагдсан харьцуулан үзвэл:

№	Зүйл, заалт	Хуулийн зохицуулалт	Төслийн зохицуулалт
1	Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах	Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Төрийн албан хаагч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хоригдол, хохирогч, гэрч, бусад хүнээс тайлбар, мэдүүлэг авах, мэдээ сэлт гаргуулан авах , хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, айлган сүрдүүлэх, алагчлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг

³⁰ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, ХЭҮК, 2023 он, 11 дэх тал.

³¹ Хүний эрхийн үндэсний комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны тайланд хийсэн шинжилгээний танилцуулга, УИХТГ, 2023 он, 6 дахь тал.



			жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
--	--	--	-------------------------------------------------------

Төслийн зохицуулалтаас үзвэл Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг илүү нарийвчлан тусгасан бөгөөд “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ийн хэрэгжилттэй холбогдуулан НҮБ-ийн Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын тайланд өгсөн зөвлөмжид “Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг конвенцийн 1 дүгээр зүйлд заасан “аливаа байдлаар алагчилж, эсхүл айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор эрүүдэн шүүх, мөн гуравдагч этгээдэд хамааралтай байх гэсэнтэй бүрэн нийцүүлэн тодорхойлох”³² гэсэн зөвлөмжид нийцүүлэн өөрчилсөн гэж дүгнэж болох юм.

Олон улсын түвшинд тайлбар, мэдүүлэг авах ажиллагаанд гэм бурууг нь хүлээлгэх зорилгоор эрүүдэн шүүх, албадлагын арга хэмжээ түгээмэл илэрдэг гэж үздэг. Төрийн эрх бүхий албан тушаалтантай уулзаж харилцах, тайлбар, мэдүүлэг өгөх үед нь албадлага хэрэглэн мэдүүлэг авч, эрүү шүүлтийн эрсдэлд оруулдаг арга барилуудыг хэрэглэх нь худал мэдүүлэг авах, шударга ёсыг алдагдуулах, тухайн хүний эрхээ эдлэх боломж хязгаарлагддаг гэдгийг хүлээн зөвшөөрөх болсон.³³

Иймд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн зохицуулалтыг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод болон одоогийн үүсээд буй практик хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүү шүүлт тулгах хэлбэрийг өргөжүүлэн зохицуулж, эрүү шүүлт тулгах эсхүл гутаан доромжлох, шахалт дарамт үзүүлэх сэдэлт, зорилго нь гуравдагч хүн ч эрүүгийн хариуцлага хүлээхээр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй.³⁴

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

1.Төслийн албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтын практикт хэрэгжих боломжийг үнэлсэн байдал


Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө гэдэгт Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт Монгол Улсын иргэнд баталгаатай эдлүүлэхээр заасан үндсэн эрх, эрх чөлөө хамаарна.³⁵ Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийг хамгаалах нэгэн баталгаа нь Эрүүгийн хууль бөгөөд Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг зохицуулдаг. Энэ ч утгаараа Эрүүгийн хууль нь бусад хууль тогтоомжоос илүү хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж байдаг хатуу хууль юм.

³² Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2024 он.

³³ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, ХЭҮК, 2023 он, 453 дахь тал.

³⁴ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 он, 328 дахь тал.

³⁵ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, ХЭҮК, 2023 он, 453 дахь тал.



Тиймээс ч Эрүүгийн хууль нь хүний амьдрах эрх, аюулгүй байдал, амин эрх ашиг, үнэт зүйлсийн үндсэн бөгөөд онцгой хамгаалалт учир Эрүүгийн хуулийн шинэчлэлийн бодлого, зохицуулалт нь орчин цагийн эрх зүйн хөгжлийн түгээмэл хандлага, нийгмийн бодит амьдрал ахуйд нийцсэн, зөв оновчтой, гэмт хэргийн гаралтыг ихэсгэхгүй харин бууруулах буюу тодорхой түвшинд тогтоон барихад чиглэгдсэн, энэрэнгүй, эрх зүйн хийдэлгүй байх зэрэг “олон талт” шалгуур, шаардлагыг хангасан байх ёстой.³⁶

ХЗДХЯ-наас санаачилсан хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслийн хүрээнд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал хөндөгдөж байна. Тэр дундаа Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтад өргөн хүрээний нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөлд тусгажээ.

Шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн хүнийг Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд албадан эмчилж байгаа бөгөөд 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “*Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн ерөнхий ангид заасан үндэслэл, журмын дагуу тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ*” гэж, мөн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “*Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно*” гэж, ЭХХШТХ-ийн 19.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “*Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, хугацааг шинжээчийн дүгнэлт, прокурорын саналыг үндэслэн шүүх тогтооно*” гэж, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.1 дэх хэсэгт “*гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана*” гэж заасан нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хамгаалсан зохицуулалт хэдий ч практикт хэрэглэхэд хүндрэлтэй хүний эрхийн зөрчлийн асуудал гарч байна.

Мөн Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 8-д “*Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох эсэхийг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх шийдвэрлэнэ*” гэж заасан ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ямар тохиолдолд, хэрхэн шинжээч дүгнэлт гаргах, хэн хүсэлт гаргах эсэхийг хуульчлаагүй байна. Практикт хүнд гэмт хэрэг үйлдсэн хүнийг ердийн тасагт, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүнийг тусгай тасагт албадан эмчлэхээр тогтоосон байх бөгөөд ямар үндэслэлээр ердийн болон тусгай тасагт албадан эмчлэхээр шийдвэрлэснийг шүүхийн шийдвэрт тусгаагүй байна.³⁷ Өөрөөр хэлбэл, ердийн болон тусгай тасагт эмчлүүлэх асуудлыг шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлээр шийдэж байна. Учир нь Эрүүгийн хуульд ямар тохиолдол ердийн, тусгай тасагт хэвтүүлэн эмчлүүлэх талаарх зохицуулалтыг тусгаагүй.

Гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй хүнд оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилт судалгааны тайланд дурдсанаар 2017-2023 оны байдлаар нийт албадан эмчилгээнд хамрагдсан 99 хүнийг хүйсийн байдлаар нь авч үзвэл 75 нь эрэгтэй, 24 нь эмэгтэй байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд албадан эмчлүүлж буй 99 хүний 30 нь Улаанбаатар хотын, 69 нь орон нутгийн

³⁶ Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг нийтлэл, 2017 он.

³⁷ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, ХЭҮК, 2023 он, 90 дэх тал.

харьяалалтай хүмүүс байна. Тус 99 эмчлүүлэгчийн эмчилгээний давтамжийг судлан үзвэл 92 нь анх удаа, 7 нь давтан байна. Түүнчлэн, эмчлүүлэгчийн үйлдсэн гэмт хэргийг ангилан авч үзвэл:

Эмчлүүлэгчийн үйлдсэн гэмт хэрэг³⁸

№	Зүйл анги	Эмчлүүлж буй хүний тоо
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн	19
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн	37
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн	7
4	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн	32
5	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн	2
6	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг үйлдсэн	2

Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникт сэтгэцийн эмгэгийн улмаас хүний амь насыг онц харгис хэрцгий аргаар хөнөөсөн, хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан эмчлүүлэгчид албадан эмчилгээ хийлгэдэг. Тиймээс ч тухайн байгууллагад ажиллаж буй эмч, сувилагч, эмнэлгийн байгууллагын ажилтан, харуул хамгаалалтын ажилтны биемахбодид халдах тохиолдол цөөнгүй гардаг.

Энэ талаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлд *“...Цаашид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзаж ямар төрлийн эмнэлэгт эмчлэх талаарх зохицуулалтыг Эрүүгийн хууль, ЭХХШтХ, ШШГтХ-д нарийвчлан зохицуулах нь Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх боломжийг хязгаарлах, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм. Тухайлбал, Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг тухайн этгээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан сэтгэцийн эмгэг судлалын ердийн болон тусгай эмнэлэгт байлгах арга хуульчилж байсан туршлага бий...”* гэж дүгнэжээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус асуудлыг нарийвчилсан байдлаар буюу төслийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт *“...Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх албадлагын арга хэмжээ нь ердийн болон тусгай тасагтай байна...”* гэж, тус зүйлийн 8.1-д *“...ердийн тасагт хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, сэтгэцийн эрүүл мэндийн байдал нь тогтворжсон боловч хэвтэн эмчлэх шаардлагатай хүнийг ердийн хамгаалалт бүхий нөхцөлд албадан эмчлэх арга хэмжээ хамаарна...”* гэж, мөн зүйлийн 8.2-т *“...тусгай тасагт эмчлэх гэдэгт гэмт этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарыг харгалзан өндөржүүлсэн хамгаалалт бүхий албадан эмчлэх арга хэмжээг хамаарна...”* гэж тус тус заажээ. Энэ нь одоогийн Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгон,

³⁸ Гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй хүнд оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилт /Судалгааны тайлан/, ШШГЕГ-ын харьяа ХӨТЯЭА, 27 дахь тал.

тус албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэлийг тодорхой байдлаар зохицуулжээ. Иймд тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Гэхдээ төслийн албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтуудыг цаашид ч илүү боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байгааг дурдах нь зүйтэй.

Манай улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гүйцэтгэж буй эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн тоог судлан үзвэл:

*ШШГБ-аас гүйцэтгэсэн хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл*³⁹
/Зөвхөн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний тоог сонгон авсан/

Шүүхийн шийдвэрийн төрөл	Хэмжих нэгж	Гүйцэтгэвэл зохих		Гүйцэтгэсэн		Үлдэгдэл	
		2021	2022	2021	2022	2021	2022
Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	Этгээдийн тоо	53	65	17	21	36	44

Түүнчлэн, ЭХХШТХ, Шүүх шинжилгээний тухай хуульд заасны дагуу шинжээч эмч мөрдөн байцаалтын явцад гэмт хэрэг үйлдсэн этгээдийн сэтгэцийн байдлыг тодорхойлох шинжилгээг хийж, дүгнэлт гаргадаг. Шинжээчийн дүгнэлт бүрэн бус, эсхүл шинжилгээ хийлгэж байгаа асуудалтай холбоотой шинэ нөхцөл байдал бий болсон тохиолдолд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрээр нэмэлт шинжилгээ хийх, шинжээчийн дүгнэлт, түүний зарим хэсэг үндэслэлгүй, үндэслэлтэй эсэх нь эргэлзээтэй байвал шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрээр дахин шинжилгээ хийлгэх эрх зүйн зохицуулалттайг дурдах нь зүйтэй. Практикт сэтгэцийн эмгэгтэй хүн бодит нөхцөл байдлыг үнэн зөвөөр илэрхийлэх, нийгмийн хор аюулыг ойлгох чадваргүй⁴⁰ гэдгийг эмнэлгийн болон хууль зүйн талаас тайлбарласан байдаг.⁴¹


Практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйл, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/240, А/369 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-д заасан нөхцөл, журмаар дараах байдлаар хэрэгжүүлж байна.

- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх этгээдийг эмнэлэгт хүлээн авах
- Албадан эмчлэх
- Эмчилгээний явц дахь аюулгүй байдлыг хангах ажиллагаа
- Албадан эмчилгээг зогсоох.

³⁹ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2022, МУГХУСА33, 2023 он, 155 дахь тал.

⁴⁰ Л.Эрдэнэбаяр, Сэтгэц судлал, УБ., 2012 он, 447 дахь тал.

⁴¹ Гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй хүнд оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилт /Судалгааны тайлан/, ШШГЕГ-ын харьяа ХӨТЯЭА, 9 дэх тал.



Дээрх үйл ажиллагааг талаар товч дурдвал:

Нэг. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх этгээдийг эмнэлэгт хүлээн авах:

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэр гармагц уг этгээдийг албадан эмчлэх байгууллагад хүргэх үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүлээх бөгөөд шүүхийн шийдвэр, сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, холбогдох бусад баримт бичгийг хамтад нь хүргүүлнэ. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх этгээдийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүлээн авах тасагт эмч, сувилагч хүлээн авч тусгай бүртгэл хөтөлж, өвчний түүх нээн хаягийн хэсгийг бөглөнө. Албадан эмчлүүлэх этгээдийг хүргэж ирсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнаас тухайн этгээдэд албадан эмчилгээ явуулах тухай шүүхийн шийдвэр, сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, магадалгааны актын хуулбар, иргэний болон бусад холбогдох бичиг баримтыг үндэслэн албан ёсоор хүлээн авах ба эдгээр нь өвчний түүх нээх үндэслэл болно. Эмнэлгийн хүлээн авах тасаг нь албадан эмчлүүлэх этгээдэд биеийн үзүүлэлтүүдийн үзлэг, үйлчилгээг үзүүлсний дараа эмчлүүлэгчийг хүлээн авсан баримт бичгийн хамт хэвтүүлэн эмчлэх клиникт хүлээлгэн өгнө.

1. Албадан эмчлэх

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага дараах үүрэг хүлээнэ:

1. Албадан эмчлүүлж байгаа этгээдэд зайлшгүй шаардлагатай шинжилгээ, эмчилгээг цаг тухайд нь хийх;

2. Эмчилгээний явц, үр дүнг үнэн зөв, тодорхой тусгах;


3. Эмчилгээний үр дүн, өвчний шинж байдлыг харгалзан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох эсэх талаар шинжээчийн дүгнэлт гаргуулах зэрэг болно.

2. Эмчилгээний явц дахь аюулгүй байдлыг хангах ажиллагаа

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/98, А/131 дүгээр тушаалаар ШШГЕГ-ын харьяа Баривчлах төв тус клиникт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх харуул хамгаалалтыг хэрэгжүүлэн ажиллах болсон.

3. Албадан эмчилгээг зогсоох

Албадан эмчлүүлэгчийн сэтгэцийн байдлыг магадлан шинжилгээний комисс нь хагас жилд нэг удаа өвчний явцын талаар хэлэлцэж, дүгнэлт гаргана. Шаардлагатай тохиолдолд аль ч үед магадлан шинжилгээний Комиссыг хуралдуулж болно. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн магадлан шинжилгээний комиссоос эмчлүүлэгчийн сэтгэцийн байдал засарсан, хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан ба цаашид



албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэх шаардлагагүй тухай дүгнэлт гарсан бол уг дүгнэлтийг харьяа шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ. Шийдвэр гүйцэтгэгч дүгнэлтийг хүлээн авмагц ажлын 7 хоногийн дотор албадлагын арга хэмжээг зогсоох тухай саналаа, холбогдох материалын хамт прокурорт хүргүүлж шийдвэрлүүлнэ. Албадан эмчлүүлж байгаа этгээдийн сэтгэцийн байдлаас шалтгаалан хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлт, прокурорын саналаар албадан эмчлэх хугацаа дуусахаас өмнө энэ журмын 4.2 дахь хэсэгт заасан дүгнэлтийг гаргуулж болно.


Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхийг зогсоох тухай шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор албадан эмчлүүлэгчийг эмнэлгээс гаргаж, шүүхийн шийдвэрт заасан байгууллага, хууль ёсны төлөөлөгчид биечлэн хүлээлгэн өгөх үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүлээх ба хяналт тавих үүрэг бүхий орон нутгийн сэтгэцийн болон донтолтын эмч нарт албадан эмчилгээ зогсоосон тухай маягтыг ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны 2023 оны 6 дугаар сарын тайлангаас үзвэл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоож албадан эмчилгээ цуцлагдсан нийт 24 эмчлүүлэгч байгаа бөгөөд хууль ёсны асран хамгаалагчид хүлээлгэн өгсөн 18, СЭМҮТ-ийн 6 дугаар клиникт шилжүүлсэн 4, мөн төвийн 4 дүгээр клиникт шилжүүлсэн 1, СЭМҮТ-ийн асрамжийн клиникт өвчний учир албадлагын арга хэмжээг зогсоож шилжүүлсэн 1 эмчлүүлэгч байна.

Албадан эмчилгээг зогсоосон эмчлүүлэгчид харьяа орон нутаг, дүүргийн сэтгэцийн болон донтолтын эмч нь идэвхтэй хяналт тавина. Албадан эмчилгээг зогсоож, эмнэлгээс гаргасны дараа эмчлүүлэгчийн сэтгэцийн байдал дахин хямарвал иргэний журмаар харьяалсан сэтгэцийн эмнэлэгт эмчлүүлнэ. Асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа СЭМҮТ холбогдох байгууллагад хүсэлтээ гарган асуудлыг шийдвэрлэж ажиллана. Албадан эмчлүүлэгч нас барвал үзлэгийн эмч, клиникийн эрхлэгч нар түүний ар гэр, харьяа шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, цагдаагийн байгууллага, тогтоол, магадлал гаргасан, шүүхэд даруй мэдэгдэнэ. Клиникийн эрхлэгч, үзлэгийн эмч нар албадан эмчилгээ дууссан болон нас барсан эмчлүүлэгчийн хяналтын хувийн хэрэг, өвчний түүх, иргэний болон бусад баримт бичгийн хуулбарыг байгууллагынхаа архивд шилжүүлж, иргэний баримт бичгүүдийг нь түүний төрөл төрөгсөд, асран хамгаалагчид албан ёсоор хүлээлгэн өгдөг.⁴² Үүнийг Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 2, 8 дахь хэсэгт заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоохтой холбоотой зохицуулалтыг практик хэрэгжилт гэж үзэж болох бөгөөд тус зохицуулалттай ижил агуулга бүхий зохицуулалт хуулийн төслийн 7.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт тусгажээ.

Мөн Эрүүгийн хуулиас ялгаатай нь төслийн 7.7 дугаар зүйлийн 4, 5 дахь зохицуулалтад донтох эмгэг судлалын тасагт албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх хугацаа дууссан, эмчлэгдсэн бол уг арга хэмжээг зогсоох шийдвэр гаргаж асран хамгаалагч эсхүл асрамжийн төвд шилжүүлэхээр тусгасан байна. Энэ нь хуульд тухайн асуудлын тодорхой байдлаар зохицуулсан зохицуулалт болсон байна. Мөн төсөлд Эрүүгийн хуулийн зохицуулалтаас нэлээд өргөн хүрээнд албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээний зохицуулалт тусгагдаж байгаагийн хувьд хугацааны зохицуулалт ерөнхий байдлаар хуульчлагдаж, сэтгэцийн эмнэлэг ердийн болон тусгай тасагтай байх үндэслэлийг тусгаж, албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ

⁴² Мөн тэнд.



авагдсан хүнд оношилгоо болон эмчилгээний туршилт хийхийг хориглох заалтыг шинээр тусгаж өгчээ. Тус зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжтой бөгөөд цаашид албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтыг улам боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байгааг дурдах нь зүйтэй.

2. Төслийн 13.4 дүгээр зүйлд заасан Хүнийг хууль бусаар хорих гэмт хэрэг, Төслийн 29.12 дугаар зүйлд заасан Хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн зохицуулалтын практикт хэрэгжих боломжийг үнэлсэн байдал

Эрүүгийн хууль нь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, улс үндэстний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг сахин хангах чиг үүрэг бүхий суурь хууль болохын хувьд эрх зүйн шинэтгэл, олон нийтийн анхаарлын төвд байнга байдаг. Эрүүгийн хууль тогтвортой удаан хугацаанд мөрдөгдөж байх явдал чухал боловч уг хуулийн хэрэгжилт, үр нөлөө, нийгмийн эрэлт шаардлагад нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт шинжилгээ хийж, хэрэв нийцэхгүй зүйл байвал түүнийг шинэчлэх, өөрчлөх арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж байх нь зүйтэй. Манай улс 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиа баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлснээс хойш нийт 20 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслийн хүрээнд Эрүүгийн хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хөндөгдөж байгаа бөгөөд тус багц хуулийн төсөл нь үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх зорилготой. Энэ хүрээнд Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа бөгөөд тэдгээрийн нэг нь Хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг юм.

Манай улсын хувьд 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдөр батлагдаж, 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцод нэгдэж, 2014 оны 10 дугаар сарын 9-ний өдөр соёрхон баталсан. Уг конвенцын зорилгод зааснаар “хүчээр алга болгох” гэдэг нь алга болсон аливаа хүний эрх чөлөөг хассан явдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан буюу түүний хувь заяаны талаарх мэдээлэл, эсхүл оршин суугаа газрыг нуусны улмаас тухайн хүнийг хуулийн хамгаалалт эдэлж чадахааргүй байдалд хүргэхүйцээр төрийн төлөөлөгчид буюу төрөөс эрх олгогдсон, дэмжлэг буюу зөвшөөрөл авсан этгээдүүд, эсхүл бүлэг этгээдийн тухайн хүнийг баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасахыг хэлнэ.⁴³

Дээрх тодорхойлолтод заасан гэмт хэргийн зайлшгүй байх ёстой үндсэн шинжүүдийг авч үзвэл:

(1) Тухайн хүний хүсэл зоригийн эсрэг эрх чөлөөг нь хассан байх (тухайн хүнийг баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл бусад хэлбэрээр)

(2) Энэ нь төрийн төлөөлөгч, түүний зөвшөөрөлтэйгөөр, үйл ажиллагаа явуулж буй хүмүүстэй холбоотой байх, дор хаяж тэдгээр нь шууд бусаар хүлээн зөвшөөрснөөр

⁴³ Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенцын 2 дугаар зүйл.

(3) Эрх чөлөөг нь хассан явдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж, алга болсон хүний хувь заяа, байгаа газрыг нь нуун дарагдуулсан зэрэг шинж багтаж байна.⁴⁴

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцын хэрэгжилттэй холбогдуулан Хүчээр алга болгох асуудал хариуцсан хорооноос Монгол Улсаас хүргүүлсэн тайланг хэлэлцэж 2021 онд өгсөн зөвлөмжид “Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан Хүчээр алга болгох гэмт хэрэг нь Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцод заасан тодорхойлолт (“Хүчээр алга болгох” гэдэг нь алга болсон аливаа хүний эрх чөлөөг хассан явдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан буюу түүний хувь заяаны талаарх мэдээлэл, эсхүл оршин суугаа газрыг нуусны улмаас тухайн хүнийг хуулийн хамгаалалт эдэлж чадахгүй байдалд хүргэхүйцээр төрийн төлөөлөгчид буюу төрөөс эрх олгогдсон, дэмжлэг буюу зөвшөөрөл авсан этгээдүүд, эсхүл бүлэг этгээдийн тухайн хүнийг баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасахыг хэлнэ”) -оос агуулгын хувьд ихээхэн зөрүүтэй байгааг анхаарч тодорхойлолтыг конвенцод бүрэн нийцүүлэх, мөн Эрүүгийн хуульд уг гэмт хэргийн субъект (хүчээр алга болгох үйлдлийг гүйцэтгэсэн, тушаасан, турхирсан буюу өдөөсөн, сэдсэн, оролцсон буюу хамтарч гүйцэтгэсэн, уг үйлдлийг хянаж байсан, эсхүл доод албан тушаалтны үйлдлийг мэдсэн ч зохих арга хэмжээ аваагүй удирдах албан тушаалтан) болон хүндрүүлэх нөхцөлийг дутуу тодорхойлсон байгааг анхаарч конвенцод бүрэн нийцүүлэх; хүчээр алга болгох гэмт хэргийг конвенцын 5 дугаар зүйлд нийцүүлэн Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцохыг хоёрдмол утгагүйгээр хүлээн зөвшөөрөх⁴⁵ асуудлыг тусгажээ.

Монгол Улс 2018 онд тус конвенцын хороонд хэрэгжилтийн эхний тайлан илгээсэн бөгөөд тус тайланд дурдсанаар⁴⁶, хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн шинжийг 2015 оны Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд заасан хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг болон 13.9 дүгээр зүйлд заасан хууль бусаар баривчлах, саатуулах гэмт хэргийн төрөл хангаж байна гэж үзсэн. Гэвч эдгээр заалтад тусгасан гэмт хэргүүд нь уг конвенцод заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бүхэлд нь агуулаагүй байгааг дурдаж, конвенцын тодорхойлолтод агуулгыг бүрнээ нийцүүлэх талаар НҮБ-ын Хүнийг хүчээр алга болгохоос хамгаалах хорооноос өгсөн зөвлөмж⁴⁷ -д дурджээ.


Хүнийг хүчээр алга болгохоос хамгаалах хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмжид, Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд тусгасан “хүнийг хууль бусаар хорьсон

⁴⁴ Inter alia, WGEID, Best Practices on Enforced Disappearances in Domestic Criminal Legislation, supra note 5, para. 21, болон Parliamentary assembly, Council of Europe, AS/Jur (2011) 45, 4 November 2011, ajdoc45 2011, Committee on Legal Affairs and Human Rights, The International Convention for the Protection of all Persons from Enforced Disappearances, Report Rapporteur: Mr Christos Pourgourides, Cyprus, Group of the European People’s Party, pp.13 <http://assembly.coe.int/committeedocs/2011/ajdoc45.pdf>, [сүүлд 2022.04.08-нд үзсэн.], -аас үзнэ үү.

⁴⁵ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2024 он.

⁴⁶ Report submitted by Mongolia under article 29 (1) of the Convention, due in 2017 : International Convention for the Protection of All Persons from Enforced Disappearance, Article 2, <https://digitallibrary.un.org/record/3795922?ln=en>, [сүүлд 2022.06.08-нд үзсэн]

including observations on the report submitted by Mongolia under article 29 (1) of the Convention : Committee on Enforced Disappearances, UN. Committee on Enforced Disappearances (20th sess. : 2021 : virtual), <https://digitallibrary.un.org/record/3949022?ln=en>, pp.3 [сүүлд 2022.04.08-нд үзсэн]



үйлдэл” нь зөвхөн “хууль бусаар хорих” гэсэн утгыг илэрхийлдэг тул эрх чөлөөг нь хасах бүх төрлийг хамруулаагүй, хүчээр алга болгох гэмт хэрэг нь хуулийн дагуу эрх чөлөөг хассанаар эхэлж, улмаар уг гэмт хэргийн бусад бүрэлдэхүүнийг агуулах болсноор хууль бус болж хувирах боломжтой⁴⁸ гэжээ. Өөрөөр хэлбэл, хохирогчийг хүчээр алга болохоос хамгаалахын тулд эрх чөлөөг нь хасах ямар ч хэлбэрээс үл хамааран эрх чөлөөг нь хассан үйлдэл бүр дээр үр дүнтэй хэрэгжих ёстой бөгөөд зөвхөн хууль бусаар эрх чөлөөгөө хасуулсан тохиолдлуудаар хязгаарлагдахгүй⁴⁹ юм.

2002 оны Эрүүгийн хуулийн 109 дүгээр зүйлд заасан “Хүнийг хууль бусаар хорих” гэсэн гэмт хэргийг 2015 оны Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэрэг болгон хуульчлахдаа үндсэн гэмт хэргийн санкцад бага зэргийн өөрчлөлт оруулснаас өөрөөр гэмт хэргийн агуулгын буюу бүрэлдэхүүний хувьд өөрчлөлгүйгээр нэршлийг л өөрчилж хуульчилсан. Харин Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн заалтаас үзвэл хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийг “хүнийг хууль бусаар хорих” гэмт хэргээс тусад нь ялгаж зохицуулсан”⁵⁰

Хүчээр болон албадан алга болгосон асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг (The Working Group on Enforced or Involuntary Disappearances) “хүчээр алга болгосон” гэдэг тодорхойлолтод өгсөн ерөнхий тайлбартаа “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд (...) тухайн үйлдлийг төрийн байгууллага, эсхүл Засгийн газрын шууд болон шууд бус зөвшөөрлөөр буюу хүлээн зөвшөөрснөөр, эсхүл түүний дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж буй хувь хүмүүс, зохион байгуулалттай бүлэг (жишээ нь, хагас цэрэгжүүлсэн бүлгүүд) үйлдсэн бол хүчээр алга болгосон гэмт хэрэгт тооцохоор”⁵¹ тусгасан.

Мөн төрийг төлөөлөгч албан тушаалтнаас гадна бусад тушаал, заавар аваагүй ч, төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа болон түүний шууд ба шууд бус дэмжлэгтэйгээр гэмт хэрэг үйлдсэн хувь хүмүүсийн үйлдлийг дотоодын Эрүүгийн хууль тогтоомжид тусгаагүй бол энэ тодорхойлолтыг дутуу байна гэж Ажлын хэсэг үзээд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай⁵² гэжээ. Харин хуулийн төслийн 29.12 дугаар зүйлд “Төрийн албан хаагч, төрөөс эрх олгогдсон, зөвшөөрөл авсан этгээд” энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн байх хэмээн заажээ. Энэхүү гэмт хэргийн зохицуулалт нь субъектийн хувьд төрөөс эрх олгогдсон этгээд гэж оруулсан байх ба энэ нь конвенцод заасан төрийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж буй этгээдэд зарим талаар хамаарч болох юм. Гэвч энэ нь төрөөс аливаа эрх олгогдоогүй ч бусад хэлбэрээр дэмжлэг авсан этгээдэд хамаарах эсэх нь эргэлзээтэй байна. Жишээлбэл, төрөөс аливаа үйл ажиллагаа явуулах эрх (*тусгай зөвшөөрөл г.м*) авсан этгээд төрөөс дэмжлэг авсан гэж тооцогдох уу? Үгүй бол энэ зохицуулалтын субъект нь конвенцод заасан субъектийн шинжийг хангахгүй байна гэж үзэх боломжтой байна.


⁴⁸ Concluding observations on the report submitted by Mongolia under article 29 (1) of the Convention :Committee on Enforced Disappearances, UN. Committee on Enforced Disappearances (20th sess.:2021:virtual), https://digitallibrary.un.org/record/3949022?ln=en_pp.3 [сүүлд 2022.04.08-нд үзсэн]

⁴⁹ A/HRC/7/2, para. 26 (para. 7 of the general comment on the definition of enforced disappearance).

⁵⁰ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, 2022 он, 10 дахь тал.

⁵¹ A/HRC/7/2, para. 26 (para. 1 of the general comment on the definition of enforced disappearance)

⁵² A/HRC/7/2/Add.2, para. 30, Д.Дэмидханд, Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц ба Эрүүгийн хуулийн нийцэл: гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлага,” Хүрэл тогоот 2022” шилдэг илтгэлийн эмхэтгэлээс дам ишлэв.



Түүнчлэн, Конвенцын 3 дугаар зүйлд заасан төрийн зөвшөөрөл, дэмжлэг, зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж буй хүн, бүлэг хүмүүсийн үйлдсэн хүчээр алга болгосонтой адил үйлдлийг мөрдөж, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх зохих арга хэмжээ авах ёстой ба хүнийг хүчээр алга болгохтой холбоотой төрийн онцгой үүрэг нь “харьцуулж болохуйц” төрийн бус этгээдийн үйлдлийг үндэсний хууль тогтоомжийн дагуу тусад нь авч үзэхийг шаарддаг бөгөөд зөвхөн “хүчээр алга болгох” гэсэн өргөтгөсөн тодорхойлолтоор нэгтгэх шаардлагагүй юм.⁵³

Төслийн 29.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Төрийн албан хаагч, төрөөс эрх олгогдсон, зөвшөөрөл авсан этгээд хүнийг хууль бусаар саатуулсан, баривчилсан, хорьсон, хулгайлсан, хууль бусаар нууж эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаарх мэдээллийг нууж, мэдээлэл өгөхөөс татгалзаж эрх чөлөөг нь хязгаарласны улмаас бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол, хор уршиг учруулсан нь энэ хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийн шинжгүй бол...” гэж тодорхойлжээ.

Олон улсын эрх зүйд хүнийг хүчээр алга болгохтой холбоотой бүх тодорхойлолтод хохирогч хуулийн хамгаалалтаас гадуур байдаг. Хүчээр алга болгох гэмт хэргийн энэхүү онцлог нь хохирогчийн бүх эрх, эрх чөлөө эдлэхийг түдгэлзүүлж, түүнийг бүрэн хамгаалалтгүй байдалд оруулдагт оршино.

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц нь “*widespread and systematic*” шинжээрээ хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг заасан олон улсын гэрээнд багтдаг. Өөрөөр хэлбэл энэхүү конвенцын 7 дугаар зүйлийн 1-д заасанчлан оролцогч улс бүр, хүчээр алга болгох гэмт хэргийн онц ноцтой шинжийг харгалзан зохих шийтгэл ногдуулах ёстой.

Манай улсын хувьд хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... Хүнийг хууль бусаар хорьсон нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн шинжгүй...” гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, одоогийн Эрүүгийн хууль дахь “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэрэг нь олон улсын конвенцод заасан тус гэмт хэргийн шинжийг агуулаагүй бөгөөд “Хүнийг хууль бусаар хорих” гэмт хэргийн шинжийг илүүтэй агуулсан зохицуулалтыг “Хүнийг хүчээр алга болгох” гэж томъёолон хуульчилсан байна. Харин хуулийн төсөлд тус 2 гэмт хэргийг ялгамжтай байдлаар тодорхойлж тусгасан байна.

Хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг нь нийгмийн хор аюул ихтэй гэмт хэрэг болохын хувьд “Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг”-т хамаардаг бөгөөд манай улсын хувьд Эрүүгийн хуулийн 13 бүлэг буюу Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэгт хамааруулан тус хуулийн 13.4 дүгээр зүйлд хуульчилсан бөгөөд хуулийн төсөлд “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийг “Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг”-т хамааруулан Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэгт нэмэхээр тусгасан нь оновчтой боловч тус гэмт хэрэгт оногдуулж буй ялын хэмжээ бага, хүнийг хууль бусаар хорих гэмт хэргээс ялгагдах онцлог, шинж нь хэт ерөнхий байна.

⁵³ International commission of Jurists, No More “Missing Persons”: The Criminalization of Enforced Disappearance in South Asia, August 2017, p14, <https://www.icj.org/wpcontent/uploads/2017/08/South-Asia-Enforced-Disappearance-Publications-Reports-Thematic-Reports-2017-ENG.pdf>, [сүүлд 2022.06.10-нд үзсэн.]

Төслийн 29.12 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ

№	Төслийн зүйл, заалт	Оногдуулах ялын хэмжээ
1	29.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1-5 жил хорих
2	29.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	2-5 жил хорих
3	29.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	2-8 жил хорих
4	29.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	5-12 жил хорих
5	29.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	12-20 жил хорих

Үүнээс үзэхэд конвенцод заасан тус гэмт хэргийн онц ноцтой шинжийг Эрүүгийн хуульд тусгаагүй бөгөөд хөнгөн гэмт хэргүүдээс ялгамжтай зохицуулах шаардлагатай.

Мөн 2002 оны Эрүүгийн хуулийн 109 дүгээр зүйлд заасан “Хүнийг хууль бусаар хорих” гэмт хэргийг төслийн 13.4 дүгээр зүйлд буцаан сэргээж байгаа нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, хүчээр алга болгох гэмт хэрэг болон түүнтэй ижил төстэй бусад үйлдлийг орхигдуулахгүй байх сайн алхам болсон ч “хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийн шинжээс хэрхэн ялгарч байгаа нь тодорхойгүй байна. Учир нь төсөлд тусгагдсан уг хоёр гэмт хэрэг бүрэлдэхүүнээрээ бус **“энэ хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийн шинжгүй бол”, “хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн шинжгүй бол”** гэдэг байдлаар л хоорондоо ялгагдаж байна. Хүнийг хууль бусаар хорьсон этгээдэд субъектийн хувьд хэнийг ч (*хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн субъект болох төрийн албан хаагчийг ч*) хамаатуулж болохоор байх тул субъектийн ялгаа заагийг оновчтой тодорхойлох шаардлагатай юм.

Түүнчлэн, Хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн гол онцлог бол уг гэмт этгээдийн ард төрийн байгууллага, засгийн газар зэрэг эрх бүхий этгээд байдаг тул зөвхөн төрийн албан хаагч дангаар (*тухайлбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй төрийн албан хаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч г.м*) хүнийг хууль бусаар хорьсон бол шууд хүнийг хүчээр алга болгох гэмт хэргээр зүйлчилж болохоор байгааг анхааран үзэх нь зүйтэй.

Иймд энэхүү гэмт хэргүүдийн гэмт хэргийн шинж, гэмт хэргийн бүрэлдэхүүний хоорондын ялгааг ялгамжтай байдлаар хуульчлах, мөн зөвхөн төрийн албан хаагчийн үйлдсэн гэмт үйлдлийг хүчээр алга болгох гэмт хэрэгт тооцох нь учир дутагдалтай байх тул хуулийн төсөлд тусгагдсан субъектийг конвенцод нийцүүлэн өөрчлөх хэрэгтэй гэж дүгнэлээ. Түүнчлэн, төсөлд заасан төрөөс эрх олгогдсон этгээд болон төрөөс шууд болон шууд бусаар дэмжлэг авсан этгээдийн хамаарлыг тодруулах шаардлагатай юм.

Мөн манай улсын хувьд эдгээр гэмт хэргүүдийг ялгамжтай байдлаар зохицуулахаар төсөлд тусгасан байх боловч хоорондын ялгааг сайн гаргаж чадаагүй нь шүүхийн практикт, ялангуяа гэмт хэргийн зүйлчлэлийн хувьд асуудал үүсгэж болзошгүй юм.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэх мөн логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгах шаардлагатай. Мөн хууль тогтоомжийн

тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ийг баримталсан эсэхийг тусгайлан шалгана. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн зохицуулалт нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхэд дараах байдлаар дүн шинжилгээ хийсэн болно.

Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1.	Төслийн 1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй: 1/ 7.5, 7.6, 7.7, 7.8 дугаар зүйл Төслийн 2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: 3/ 7.4 дүгээр зүйл.	Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлд албадлагын арга хэмжээний 3 төрлийн хуульчилсан бөгөөд тус зүйлийн 1.2-т эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ гэж тусгасан. Гэтэл хуулийн төсөлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ болгон өөрчилж байгаа боловч Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.2-т заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний гэснийг өөрчлөн найруулах талаар хуулийн төсөлд тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.2-т заасан зохицуулалтыг өөрчлөхгүйгээр тус хуулийн 7.4 дүгээр зүйлд өөрчлөлт оруулж, нэмэлт зохицуулалт тусгах нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Иймд Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтыг албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ болгон өөрчилж байгаа тохиолдолд Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтыг бүхэлд нь өөрчлөх шаардлагатай. Үүнийг харилцан уялдаа хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.
2.	Төслийн 7.5 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэг	Төслийн 7.5 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “...хэвтүүлэн эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ...” гэж, төслийн 7.7 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “...хэвтүүлэн эмчлэх албадлагын арга хэмжээ...” гэж ялгамжтай байдлаар бичжээ.	Төслийн 7.5 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэгт “аюулгүй байдлын арга хэмжээ”, “албадлагын арга” хэмжээ гэж нэг нэр томъёог ялгамжтай байдлаар бичсэн байгааг нэг мөр болгон өөрчлөх. Ийнхүү өөрчлөхдөө Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлд “Албадлагын арга хэмжээний төрөл” гэснийг харгалзан үзэх.
3.	Төслийн 7.7 дугаар зүйл	Төслийн 7.7 дугаар зүйлийг “албадан эмчлэх аюулгүй арга хэмжээг өөрчлөх зогсоох” гэснийг засах.	Төслийн 7.7 дугаар зүйл. “Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг өөрчлөх, зогсоох” гэх.

4.	Төслийн 7.7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг	Төслийн 7.7 дугаар зүйлийн 6-д "...Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно" гэж заасан нь төслийн 7.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан зохицуулалттай агуулгын хувьд ижил байна.	Төслийн 7.7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг болон 7.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт ижил агуулга бүхий зохицуулалтыг давхардуулан тусгасан байх тул 7.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн зохицуулалтыг хасах.
5.	Төслийн 7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Төслийн 7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "... хэрэг шалган шийдвэрлэх үед хэрэг хариуцах чадваргүй..." гэж тусгажээ.	Төслийн 7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг "...хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг хариуцах чадваргүй..." гэж өөрчлөх.
6.	Төслийн 2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: 1/ 6.3 дугаар зүйл. Хэрэг хариуцах чадвар	Төслийн 6.3 дугаар зүйлд хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварт тооцох үндэслэлийг тусгасан бөгөөд ийнхүү тусгахдаа Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулахаар заажээ. Өөрөөр хэлбэл, одоогийн Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадвартай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх болон хэрэг хариуцах чадваргүй байдлыг тодорхойлсон зохицуулалтыг өөрчлөн найруулж байгаа юм.	Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт тус өөрчлөлт орвол хэдэн хэдэн асуудал бий болно. Үүнийг харилцан уялдаа хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.
7.	Төслийн 2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: 5/13.4 дүгээр зүйл. Төслийн 3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.	Төслийн 2 дугаар зүйлээр 13.4 дүгээр зүйлийг өөрчлөн найруулахаар тусгасан боловч төслийн 3 дугаар зүйлд тус зохицуулалтыг хүчингүй болгохоор зохицуулсан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Төсөлд Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлийн өөрчлөн найруулж тусгасан учир төслийн 3 дугаар зүйлийг хасах нь зүйтэй.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Хуулийн төслийн нэр нь Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай бөгөөд энэ нь тухайн зохицуулж буй харилцаандаа хамааралтай байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах, 7.5-7.8 дугаар зүйлийг нэмэхээр тусгасан нь Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ гэх ойлголтыг албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ болгон өөрчилж байгаа мэт харагдаж байна. Гэвч төсөлд Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 7.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад тусгагдсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтыг өөрчлөх, хасах талаар дурдаагүй байна. Иймд ижил агуулга бүхий зохицуулалтыг хоёр өөр нэр томьёогоор илэрхийлэх асуудал үүсэхээр байна. Тус асуудлыг дор дэлгэрүүлэн бичсэн болно. Мөн төслийн 7.5 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэгт хэвтүүлэн эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ, хэвтэн эмчлүүлэх албадлагын арга хэмжээ гэж нэг нэр томьёог өөр өөрөөр бичсэнг нэг мөр болгон засах шаардлагатай бөгөөд ийнхүү засахдаа Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлд “Албадлагын арга хэмжээний төрөл” гэж хуульчилсан байгааг харгалзан үзэх нь зүйтэй.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	<p>Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадвартай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ...” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “...Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдолын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй болсныг хэрэг хариуцах чадваргүйд тооцно...” гэж заасан.</p> <p>Харин хуулийн төслөөр 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Хэрэг хариуцах чадварыг алдагдуулдаггүй сэтгэцийн эмгэг, түр сарнилын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанарыг ухамсарлах, үйлдлээ удирдах, жолоодох чадварт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа сэтгэцийн өөрчлөлтийг хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварт тооцно...” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “...хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвартай байх үедээ энэ хуульд заасан хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, энэ хуулийн 10.2 дугаар зүйл, 10.5 дугаар зүйл, 20.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахын зэрэгцээ албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэнэ...” гэж өөрчлөлт оруулахаар тусгажээ. Энэ нь Эрүүгийн хуулийн хэд хэдэн зохицуулалттай зөрчилдөх нөхцөлийг бүрдүүлж байна.</p> <p>Учир нь тус өөрчлөлт орсноор Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хэрэг хариуцах чадвартай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хэрэг хариуцах чадваргүйд тооцох үндэслэлтэй холбоотой зохицуулалт хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвартай холбоотой зохицуулалт болж өөрчлөгдөх юм.</p> <p>Өөрөөр хэлбэл, хэрэг хариуцах чадвар, хэрэг хариуцах чадваргүй байдал, хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар гэх 3 ойлголт хуульд тусгагдах бөгөөд хэрэг хариуцах чадвартай хүнд эрүүгийн хариуцлага</p>

	<p>хүлээлгэнэ гэх зохицуулалт хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар гэх ойлголт болно. Харин Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өөрчлөлт орсноор Эрүүгийн хуульд хэрэг хариуцах чадваргүй гэх нэр томъёо үлдэх боловч ямар тохиолдолд хэрэг хариуцах чадваргүй гэж үзэх үндэслэл байхгүй болно.</p> <p>Төслийн тус өөрчлөлт Эрүүгийн хуульд орсон ч Эрүүгийн хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 4 дэх хэсэгт хэрэг хариуцах чадвар, хэрэг хариуцах чадваргүй байдлын талаарх асуудал зохицуулагдсан хэвээр байна.</p> <p>Иймд төслийн 6.3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт оруулж буй өөрчлөлтийг эргэн харах нь зүйтэй. Түүнчлэн, хуулийн төслийн өөрчлөлтөөр хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар гэх ойлголтыг хуульд тусгахаар зохицуулсан боловч хэрэг хариуцах чадвартай, хэрэг хариуцах чадваргүй гэмт хэрэг үйлдсэн хүнээс эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял оногдуулах, бусад асуудлын хүрээнд ямар ялгаатай байхыг тусгаагүй нь энэхүү ойлголтыг Эрүүгийн хуульд хуульчлах ач холбогдлыг алдагдуулж байна. Иймд хэрэг хариуцах чадвартай, хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвартай, хэрэг хариуцах чадваргүй гэж ангилан үзэхийн ач холбогдлыг илүү тодорхой болгох нь зүйтэй.</p>
<p>Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх</p>	<p>Төслийн 7.4-7.8 дугаар зүйлд албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд энэ нь Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтын хүрээнд орж буй нэмэлт, өөрчлөлт юм.</p> <p>Гэсэн хэдий ч хуулийн төслийн тус өөрчлөлт нь Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ гэх ойлголтыг бүхэлд нь хамраагүй бөгөөд Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 7.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ гэх ойлголт тусгагдсан хэвээр байхаар байна.</p> <p>Учир нь хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээний төрөл болох тус зүйлийн 1.2-т заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ гэж өөрчлөх талаар тусгаагүй, мөн Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт өөрчлөлт оруулах, хасах тухай дурдаагүй учир тус зохицуулалтад тусгагдсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй холбоотой асуудал хэвээр үлдэнэ. Иймд төслийн дээрх зохицуулалтууд нь Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, мөн хуулийн 6.3 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан зохицуулалттай зөрчилдөж байна.</p>

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулах талаар дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

- Зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, харилцан мэдээлэл солилцох зорилго бүхий зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна;

- Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл нийлүүлэх, солилцох, ашиглах, мэдээлэлтэй танилцах журмыг энэ хуульд нийцүүлэн Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална;


- Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэр гаргасан даруй зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд бүртгэх бөгөөд зөрчлийн хэргийн дугаар системээс олгогдоно;

- Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл тухайн байгууллагын харьяаллын бус болох нь тогтоогдвол энэ хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд даруй бүртгэнэ;

- Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах шийдвэр нь шийтгэлийн хуудас хэлбэртэй байна. Шийтгэлийн хуудас нь цахим хэлбэртэй байж болно.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй 2017 оны Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулах талаар ямар нэг зохицуулалт тусгагдаагүй байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлд тус хуулийн зорилтыг “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.” гэж тодорхойлсон байдаг. Тус нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулснаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хурдан шуурхай, ил тод, найдвартай байдал хангагдаж цаашлаад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ач холбогдолтой.

Монгол Улс цахим засаглалыг хөгжүүлэх чиглэлд хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Нийтийн мэдээллийн ил байдлын тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн бол бодлого, стратегийн хүрээнд Шинэ сэргэлтийн бодлого, Төрийн бүтээмжийн сэргэлт, “Цахим үндэстэн” дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж



эхлээд байна⁵⁴. Тус нэмэлт, өөрчлөлт буюу зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд дараах бодлогын баримт бичиг батлагдсан байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.3-т “Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.” гэж тусгагдсан ба 1-р үе шат буюу 2021-2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээг “2.Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болж хөгжинө.” “3.Цахим хэлбэрт шилжсэнээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээ шат дамжлагагүй, шуурхай болно.” гэж тодорхойлсон. Мөн “Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж, хүнд суртал, авлига үүсэх эрсдэлээс хамгаална.” гэж тус бодлогын баримт бичгийн 2 дугаар хавсралтаар батлагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний 5.3.21-т тусгагджээ.

"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.2-т “Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана.”, 4.1.3-т “Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.” гэж зохицуулсан.

Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/24 тоот тушаалаар батлагдсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэлийн 2.3.5 дахь хэсэгт “Иргэн, хуулийн этгээдийг мэдээллээр хангаж нээлттэй засаглал буюу төрд итгэх итгэл, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлж мэдээлэл хариуцагчаас шаардлагатай мэдээлэл, мэдэгдлийг нэгдсэн байдлаар хүргэх платформыг нэвтрүүлнэ” гэж тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2012 онд батлагдсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийн гуравдугаар зорилтод “Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох;” гэж тусгасан ба 5.3.2-т “төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг илүү хяналттай, өндөр бүтээмжтэй болгох зорилгоор гүйцэтгэлд тулгуурласан үнэлгээний мэдээллийн системийг нэвтрүүлэх;”, 5.3.3-т “эрэлт ихтэй, иргэдэд чирэгдэл учруулан ачааллыг үүсгэдэг төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх;” арга хэмжээг тусгажээ.

Монгол улсын Засгийн газрын 2005 онд батлагдсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрт “Төрийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо (Integrated system), мэдээллийн нэгдсэн санг байгуулж “Төрийн ой” (Government institutional memory)-г бий болгох” бий болгохоор тусгасан байжээ.

Мөн шүүхийн шинэчлэлийн хүрээнд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.11-д “...шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх...” гэж, 74 дүгээр зүйлийн 74.1.6-д “...шүүхийг дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах нэгдсэн бодлого батлах,

⁵⁴ 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д ЦХХХ-ны дэд сайд Ж.Эрхэмбаатарын хэлэлцүүлсэн “Монгол Улсын шүүхийн болон хуулийн байгууллагуудыг цахимжуулах мэдээлэл технологийн үүрэг” сэдэвт илтгэлээс.

https://docs.google.com/presentation/d/13pM_ibCxZi40sK3fBfIKzffalucrgXh1X/edit#slide=id.p25

хэрэгжүүлэх...” гэж тус тус заасан бөгөөд дээрх зохицуулалтуудтай уялдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 332 дугаар тогтоолоор “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого”-ыг баталсан.

Түүнчлэн Улсын ерөнхий прокурорын газраас Прокурорын байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулсан бөгөөд энэхүү стратеги төлөвлөгөөнд дараах 5 зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байна. Үүнд:

- Олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх;
- Прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах;
- Прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох;
- Хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг сайжруулах;
- Цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх.

Энэхүү зорилтуудыг хэрэгжүүлэх тулд прокурорын байгууллага үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшил, инноваци нэвтрүүлэх, ажлын үр нөлөө, бүтээмжийг нэмэгдүүлэх, их өгөгдлийг бодлогын шийдвэр гаргахад ашиглах, зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, статистикийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зэрэг арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллаж байна⁵⁵.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн хэрэг, цагдан хорих гэх мэт асуудлыг цахимжуулах боломжтой. Гадаад орнуудын туршлагаас харахад процессын хуулиудад ерөнхий зохицуулалтыг тусгаж, нарийвчилсан зохицуулалтыг журам батлан хэрэгжүүлдэг туршлага нийтлэг байна. Манай улс хуульдаа цахимаар мэдүүлэх, цахим хавтаст хэрэгтэй холбоотой ерөнхий зохицуулалтыг тусгах нь цаашдын шүүх болон бусад хуулийн байгууллагын цахимжилтад эергээр нөлөөлөх боломжтой⁵⁶.


2023 оны 3 сарын 23-24-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монгол Улсын шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д хэлэлцүүлсэн зарим илтгэлүүдээс онцлох зүйлийг дурдвал:

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах ажлыг эхлүүлээд байна. Тухайлбал, 2023 оны 3 сарын 20-ны өдрөөс эхлээд ЧД-ийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Замын цагдаагийн хэлтэстэй хамтраад 100 орчим эрх бүхий албан тушаалтанд эрх олгож шинэ программыг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж эхлээд байна.

ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик мэдээллийн хэлтсийн дарга, Цагдаагийн дэд хурандаа Д.Жанчивдорж

⁵⁵ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2022, УБ, 2023, 86 дахь тал.

⁵⁶ Г.Даваадорж: Шүүхийн цахимжилтад хууль эрх зүйн орчин ус агаар мэт хэрэгтэй байна, https://www.judcouncil.mn/site/news_full/13818



Мөн ЧД-ийн ЭХАШШ-ийн шүүгч Л.Галбадар “Эрүүгийн шүүхийн цахимжилт, тулгамдсан асуудал” сэдэвт илтгэлдээ “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ цахимжих боломжгүй. Зарим цахимжих боломжгүй ажиллагаа байгаа харин шүүхийн зөвшөөрөл, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэрэг, зөрчлийн хэргийн хүрээнд цахимжилт хийгдэх бүрэн боломжтой. Үүний тулд Цагдаагийн байгууллага зөрчил, гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл ирэхэд тухайн гомдол, мэдээллийн дагуу хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа сонголттойгоор буюу цахимаар эсвэл уламжлалт цаасан суурьтайгаар нотлох баримт бүрдүүлэх боломжийг хуульд тусгаж өгөх нь зүйтэй. Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоо цахимаар хохирлынхоо үнэлгээг гаргаад тоон гарын үсгээр баталгаажуулан явуулж болдог болсон гэсэн ч одоогийн байдлаар үүнийг шууд хэвлээд хавтаст хэрэгт хийх боломжгүй. Хэрэв цахим хавтаст хэрэгтээ байсан бол шууд татаад хавтаст хэрэгт хавсаргах боломжтой. Иймээс хэдийгээр нэг талдаа цахимаар нотлох баримт цуглуулах боломж байгаа боловч одоогийн практикт заавал цаасан хэлбэрт буулгаж, нотлох баримтаа бүрдүүлж байна.” гэжээ.

Иймд тус хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулж байгаа нь үр дүнтэй, зорилгод нийцэхээр байна.

Мөн түүнчлэн зөрчлийн бүртгэл, мэдээллийн сан нь Монгол Улсын хувьд өмнө нь хэрэгжиж байсан төсөл арга хэмжээ учраас тус үйл ажиллагааг хуульчлах нь одоо байгаа практикт ч нийцэх юм.

2022 онд хамгийн анх “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг танилцуулсан ба энэ тухай илтгэлийг тухайн үеийн Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар хэлэлцүүлсэн.

“Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийн үйл ажиллагааг 2023 оны нэгдүгээр сарын 01-нээс эхлүүлнэ. Үүнтэй холбогдуулан туршилтын журмаар 2022 оны арваннэгдүгээр сард ашиглах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт Засгийн газрын өнөөдрийн хуралдаанаас даалгалаа.

“Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж дууссан, 2023 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан” гэж ХЗДХ-ийн сайд танилцууллаа. Тус системийг нэвтрүүлснээр зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан үүсэх ба зөрчлийн хэргийг шалгах, шийдвэрлэх эрх бүхий байгууллага, түүний албан хаагчид тус системд хандан хэрэг бүртгэх, шалгах үйл ажиллагааг цахимаар хийх, ялангуяа прокурорын байгууллага мэдээллийн санд нэвтрэн зөрчлийн хэрэг бүртгэлд хяналт тавьж, шаардлагатай асуудлыг цахимаар шийдвэрлэх бүрэн боломжтой болох юм. Өөрөөр хэлбэл, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нэг цонхны хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдэнэ.

Эдгээр үйл ажиллагааг цахимжуулснаар цаасны хэрэглээ эрс багасах, зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болон шалган шийдвэрлэх

*ажиллагаанд оролцогч этгээдэд учруулдаг цаг хугацаа, хөрөнгө зардал, бусад хүндрэл чирэгдлийг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.*⁵⁷

Ийнхүү “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг 2023 оноос ашиглалтад оруулсан ба энэ талаар хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг сургалтад хамруулсан, хэрэгжилт нь сайн байна.

Тухайлбал, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу боловсруулсан “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн цахим сан”-г 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр ашиглах болсонтой холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Зөрчлийн хэрэг бүртгэх газар нь “Ай Ти Зон” ХХК-тай хамтран “Зөрчлийн бүртгэл мэдээллийн цахим сан”-г ашиглах сургагч багш бэлтгэх сургалтыг 2022 оны 12 дугаар сарын 28, 30-ны өдрүүдэд Дотоод хэргийн их сургууль дээр зохион байгуулсан. Сургалтад Тээврийн цагдаагийн алба, Экологийн цагдаагийн алба, Зөрчлийн хэрэг бүртгэх газар, Мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын албаны статистикийн хэлтэс болон дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн 82 алба хаагчид танхимаар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас 746 алба хаагчид цахим хэлбэрээр хамрагдсан. Хөтөлбөрийн дагуу Цагдаагийн байгууллагын удирдах болон зөрчил шалган шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх эрх бүхий албан тушаалтнуудаас цахим санд нэвтрэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан мэдээллүүдийг газар дээр нь туршин ашиглах байдлаар дадлага ажил хийлгэн, гарч буй хүндрэл бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар сургагч багшаас зөвлөгөө авч, санал солилцсон⁵⁸.

Сүүлийн мэдээгээр буюу 2023 оны 4 дүгээр сарын байдлаар “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг хөгжүүлэх үйл ажиллагаа дараах шатанд явж байсан.

Зөрчлийн талаарх гомдол мэдээлэл, зөрчлийн хэргийн хяналт, шийдвэрлэлт, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээллийг төвлөрүүлэх “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-гийн туршилт, судалгааны ажлыг хийж гүйцэтгэх ажлын хэсэг прокурорын байгууллагын дэргэд байгуулагдаж, 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Чингэлтэй дүүргийн прокурорын газар, тус дүүрэг дэх Цагдаагийн газрын 1, 2 дугаар хэлтэс, Замын цагдаагийн хэлтсийн хэмжээнд туршилтын ажлыг эхлүүлээд байна.


Прокурорын байгууллага, Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Цагдаагийн байгууллага, “Ай Ти Зоне” ХХК-ийн бүрэлдэхүүнтэй тус ажлын хэсэг туршилтын явцад нэгдсэн санг бусад бүртгэлийн системүүдтэй холбох, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, зөрчлийн хэргийн хөдөлгөөнийг бүртгэх, үүнтэй холбоотойгоор системийн алдааг засаж, сайжруулах зэрэг хөгжүүлэлтийн ажлыг хийх юм. “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 60 гаруй байгууллага, албан тушаалтан холбогдох ажээ⁵⁹.

Цахим бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрддэг.

⁵⁷ Х.Нямбаатар: Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем ирэх оноос ажиллаж эхэлнэ, <https://montsame.mn/mn/read/307709>

⁵⁸ “Зөрчлийн бүртгэл мэдээллийн цахим сан”-г ашиглах сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулагдлаа, <https://police.gov.mn/a/6327>

⁵⁹ “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-гийн туршилтын ажил чингэлтэй дүүргийн хэмжээнд хийгдэж байна, <https://prokuror.mn/post/111143>

- 
- Хэрэглэгчийн бүртгэл ба баталгаажуулалтын модуль
 - Гомдлын удирдлагын модуль
 - Гэрчийн мэдүүлгийн модуль
 - Сураггүй алга болсон хүмүүсийн модуль
 - Хүссэн жагсаалтын удирдлагын модуль
 - Анхны мэдээллийн тайлан (FIR) модуль

Мөн цахим бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь дараах сул талуудыг бий болгож болно.

- Гар аргын процессууд: Одоо байгаа системийн гол сул тал нь гар аргын процессоос ихээхэн хамааралтай байсан явдал юм. Цаасан дээр суурилсан баримт бичиг, биет бүртгэлтэй ажиллах нь цаг хугацаа их зарцуулж, өгөгдөл оруулах, сэргээх явцад хүний алдаа гаргахад хүргэдэг.

- Хязгаарлагдмал хүртээмж: Системийн уламжлалт шинж чанар нь зөвхөн эрх бүхий ажилтнуудад нэвтрэх боломжийг олгодог. Энэхүү хязгаарлагдмал хандалт нь янз бүрийн хууль сахиулах байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоход саад болж, мөрдөн байцаалтын ажиллагааг удаашруулж, гэмт хэрэгтэй тэмцэх хүчин чармайлтыг саатуулж болзошгүй юм.

- Өгөгдлийн давхардал: Олон байршилд хадгалагдсан бичлэгүүд нь одоо байгаа системд өгөгдлийн давхардал үүсгэдэг.

- Үр ашиггүй мэдээлэл авах: Гараар бөглөх систем нь ялангуяа яаралтай нөхцөл байдлын үед мэдээлэл авах ажлыг төвөгтэй болгодог. Цаасан файлаас тодорхой мэдээллийг олох нь цаг хугацаа их зарцуулж, хууль сахиулах байгууллагын хариу үйлдэлд сөргөөр нөлөөлж болзошгүй.


- Хязгаарлагдмал аналитик: Одоо байгаа системд автоматжуулсан тайлагнах, аналитик чадвар дутмаг байгаа нь гэмт хэргийн өгөгдлөөс утга учиртай ойлголт олж авахад хүндрэл учруулна. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагааны хэв маяг, чиг хандлагыг тодорхойлоход хүндрэлтэй байсан тул гэмт хэргийн эсрэг идэвхтэй тэмцэх боломжийг хязгаарлаж байна.

- Аюулгүй байдлын алдаа: Биет баримт бичиг нь алдагдах, хулгайд алдагдах, гэмтэх эрсдэлтэй байсан тул нууц мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг алдагдуулдаг.

- Олон нийтийн оролцоо бага: Одоо байгаа системд гэмт хэргийн талаар мэдээлэхдээ гар ажиллагаатай, нарийн төвөгтэй үйл явц нь зарим хүмүүсийг гэмт хэргийн талаар хууль сахиулах байгууллагад мэдээлэхээс татгалзуулж магадгүй юм. Олон нийтийн оролцоо дутмаг байгаа нь гэмт хэргийн талаар дутуу мэдээлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

- Хадгалалт: Биет бүртгэлийг удирдахад ихээхэн хэмжээний хадгалах зай, захиргааны хүчин чармайлт шаардагдана. Цаг хугацаа өнгөрөх тусам гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр систем нь илүү их нөөцийг шаарддаг болсон нь хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны зардал нэмэгдэхэд хүргэсэн.

- Сураггүй алга болсон хүмүүсийг хайхад үр ашиггүй: Сураггүй алга болсон хүмүүсийн мэдээллийн төвлөрсөн, хялбар хандах боломжтой мэдээллийн сан байхгүй



байгаа нь эрэн хайх, аврах ажиллагааг үр ашиггүй болгосон. Мэдээллийг удаашруулан түгээх нь сураггүй алга болсон хүмүүсийг яаралтай олох боломжид нөлөөлж болзошгүй.

- Хязгаарлагдмал хамтын ажиллагаа: Одоо байгаа системийн шинж чанар нь янз бүрийн хууль сахиулах байгууллага, хэлтэс хоорондын тасралтгүй хамтын ажиллагаанд саад учруулж байна. Бодит цагийн мэдээлэл солилцох чадваргүй байх нь олон улсын харьяалалд үйл ажиллагаа явуулж буй гэмт хэрэгтнүүдийг баривчлах боломжийг алдахад хүргэж болзошгүй юм.

Түүнчлэн дээрх системд хөгжүүлэлт хийснээр дараах давуу талууд бий болохоор байна.

- Сайжруулсан байдал: Систем нь янз бүрийн үйл явцыг автоматжуулах замаар гэмт хэргийн файлын менежментийн үр ашгийг эрс сайжруулдаг. Гомдлын бүртгэл, гэрчийн мэдүүлэг, сураггүй алга болсон хүний мэдүүлгийг оновчтой болгож, мэдээлэл оруулах, сэргээхэд шаардагдах хугацааг багасгасан.

- Бодит цагийн өгөгдөлд нэвтрэх: Санал болгож буй системийн төвлөрсөн мэдээллийн сангийн тусламжтайгаар эрх бүхий хэрэглэгчид, тэр дундаа хууль сахиулах байгууллагын ажилтнууд хаанаас ч, хэзээ ч гэмт хэргийн бодит цагийн мэдээлэлд хандах боломжтой. Энэ нь хариу арга хэмжээ авах хугацааг хурдасгаж, мөрдөн байцаалтын явцад илүү сайн зохицуулалт хийх боломжийг олгодог.

- Гэмт хэргийн иж бүрэн баримтжуулалт: Энэхүү систем нь гомдол, гэрч, сураггүй алга болсон болон эрэн сурвалжлагдаж буй гэмт хэрэгтнүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулснаар гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийн иж бүрэн баримтжуулалтыг баталгаажуулдаг. Энэ нь илүү хүчтэй хэргүүдийг бий болгож, үр дүнтэй шийдвэр гаргахад тусалдаг.

- Олон нийтийн оролцоо нэмэгдсэн: Системийн хэрэглэгчдэд ээлтэй интерфэйс нь гэмт хэргийн талаар мэдээлэх, бусад холбогдох мэдээллээр хангахад илүү олон хүнийг оролцуулдаг. Ийнхүү олон нийтийн оролцоо нэмэгдсэн нь илүү олон зөрчлийг илрүүлэхэд тусалж, хууль сахиулах байгууллагад гэмт хэргийн эсрэг идэвхтэй арга хэмжээ авах боломжийг олгодог.

- Өгөгдлийн аюулгүй байдал ба нууцлал: Систем нь нууц мэдээллийг хамгаалахын тулд найдвартай хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлдэг. Өгөгдлийн шифрлэлт болон хандалтын хяналтын механизмууд нь зөвхөн эрх бүхий ажилтнууд нууц мэдээлэлд нэвтрэх боломжийг баталгаажуулж, зөвшөөрөлгүй мэдээлэл алдагдах эрсдэлийг бууруулдаг.

- Сураггүй алга болсон хүмүүсийг эрэн хайх ажиллагааг хялбаршуулах: Сураггүй алга болсон хүмүүсийн талаарх мэдээллийг төвлөрүүлснээр систем нь хууль сахиулах байгууллагуудад эрэн хайх, аврах ажиллагааг үр дүнтэй явуулахад тусалдаг. Энэ функц нь сураггүй алга болсон хүмүүсийг цаг алдалгүй олох боломжийг нэмэгдүүлдэг.

- Хамгийн их эрэн сурвалжлагдаж буй гэмт хэрэгтнүүдийг мөшгөхөд тусалдаг: Систем дэх тусгай зориулалтын “Эрэн сурвалжлагдаж буй хүмүүсийн жагсаалт” модуль нь эрэн сурвалжлагдаж буй гэмт хэрэгтнүүдийн талаарх мэдээллийн нэгдсэн санг бий болгодог. Энэ онцлог нь хууль сахиулах байгууллагуудын аюултай гэмт хэрэгтнүүдийг мөрдөх, баривчлах чадварыг сайжруулдаг.

- Зардлын хэмнэлттэй байдал: Санал болгож буй системд шилжсэнээр гар аргын үйл явц болон биет баримт бичигт найдах явдлыг бууруулж, цаасны хэрэглээ, хадгалалт, захиргааны хүчин чармайлтын зардлыг хэмнэхэд хүргэдэг.

- Өргөтгөх чадвар, уян хатан байдал: Санал болгож буй систем нь өргөтгөх боломжтой байхаар бүтээгдсэн бөгөөд энэ нь цаг хугацааны явцад гэмт хэрэгтэй холбоотой өсөн нэмэгдэж буй мэдээллийг багтаах боломжийг олгодог. Нэмж дурдахад түүний модульчлагдсан загвар нь одоо байгаа бусад системүүд болон ирээдүйн сайжруулалтуудтай хялбархан нэгтгэх боломжийг олгодог.

- Нөөцийг илүү сайн хуваарилах: Гэмт хэргийн статистик мэдээлэл, чиг хандлагын талаар үнэ цэнтэй мэдээлэл өгснөөр уг систем нь хууль сахиулах байгууллагуудад нөөцийг илүү үр дүнтэй хуваарилж, хүн хүч, техник хэрэгслийн байршуулалтыг оновчтой болгох боломжийг олгодог⁶⁰.

Дээрхээс дүгнэвэл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулах талаар нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нь зорилгодоо нийцэж байгаа буюу одоо бий болоод буй асуудлыг шийдвэрлэсэн ач холбогдол бүхий зохицуулалт байна. Гэхдээ одоо байгаа систем, сангийн сул талыг засварлан зорьж буй давуу талд хүрэх нь зүйтэй.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяаллын талаар өөрчлөлтүүдийг тусгасан байна. Тус хэсгээр тус нэмэлт, өөрчлөлт нь харилцан уялдаатай эсэхэд дүн шинжилгээ хийх болно.

Эрх бүхийн албан тушаалтан	Зөрчил шалган шийдвэрлэх харьяалал /Хуулийн төслөөр нэмсэн, өөрчилсөн зохицуулалт/	Дүн шинжилгээ
Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч	Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Ийнхүү зохицуулсан нь хуулийн хийдлийг нөхөж үр дүнтэй зохицуулсан байна.
Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	Өмгөөллийн тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Ийнхүү зохицуулсан нь хуулийн хийдлийг нөхөж үр дүнтэй зохицуулсан байна.
Гаалийн улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 6.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг буюу давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлийг хассан.	Энэ нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.11 дүгээр зүйлд зааснаар гаалийн улсын байцаагчийн харьяалалд хамаарч байгаа. Ийм учраас

⁶⁰ Online Crime File Management System Posted by JPINFOTECHPROJECTS, <https://jpinfotech.org/online-crime-file-management-system/>

		давхардуулж зохицуулсныг засварласан байна.
Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 16.3 дугаар зүйл буюу Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль зөрчих зөрчлийг хассан. Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Хассан зохицуулалтын тухайд Зөрчлийн тухай хуулиас хассан учраас хассан байна. Харин нэмсэн зохицуулалтын тухайд хийдлийг нөхсөн зохицуулалт байхаар харагдаж байна.
Оюуны өмчийн улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Нэмсэн зохицуулалтын тухайд хийдлийг нөхсөн зохицуулалт байхаар харагдаж байна.
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Нэмсэн зохицуулалтын тухайд хийдлийг нөхсөн зохицуулалт байхаар харагдаж байна.
Гал түймрийн улсын хяналтын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Нэмсэн зохицуулалтын тухайд хийдлийг нөхсөн зохицуулалт байхаар харагдаж байна.
Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч	Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Нэмсэн зохицуулалтын тухайд хийдлийг нөхсөн зохицуулалт байхаар харагдаж байна.
Монголбанкны хянан шалгагч	Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Нэмсэн зохицуулалтын тухайд хийдлийг нөхсөн зохицуулалт байхаар харагдаж байна.
Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Нэмсэн зохицуулалтын тухайд хийдлийг нөхсөн зохицуулалт байхаар харагдаж байна.
Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Нэмсэн зохицуулалтын тухайд хийдлийг нөхсөн зохицуулалт байхаар харагдаж байна.
Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Нэмсэн зохицуулалтын тухайд хийдлийг нөхсөн зохицуулалт байхаар харагдаж байна.
Төмөр замын тээврийн улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Нэмсэн зохицуулалтын тухайд хийдлийг нөхсөн зохицуулалт байхаар харагдаж байна.
Хүүхдийн эрхийн улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Нэмсэн зохицуулалтын тухайд хийдлийг нөхсөн зохицуулалт байхаар харагдаж байна.

Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч	Зөрчлийн тухай хуулийн 7.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг буюу Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих зөрчлийг хассан.	Хассан зохицуулалтын тухайд Зөрчлийн тухай хуулиас хассан учраас хассан байна.
Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Ямар нэг өөрчлөлт ороогүй байна.	Хуулийн төслөөр нэмэлт, өөрчлөлт оруулаагүй байгаа нь алдаатай зохицуулалт болсон.
Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний хяналтын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 13.4 дүгээр зүйлийн 3, 5 дахь хэсгийг хассан байна.	Хассан зохицуулалтын тухайд Зөрчлийн тухай хуулиас хассан учраас хассан байна.
Ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйл буюу Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих, 6.14 дүгээр зүйл буюу Хүнсний тухай хууль зөрчих, 6.15 дугаар зүйл буюу Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих, 6.16 дугаар зүйл буюу Органик хүнсний тухай хууль зөрчих, 7.8 дугаар зүйл буюу Ургамал хамгааллын тухай хууль зөрчих зөрчлийн холбогдох хэсгүүдийг нэмсэн.	Нэмсэн зарим харьяаллын зохицуулалтын тухайд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөр эрх бүхий албан тушаалтны чиг үүрэгт хамаарч байх тул давхардлыг арилгах нь зүйтэй.
Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 14.15 дугаар зүйл буюу Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зөрчих зөрчлийг нэмж тусгасан.	Нэмсэн харьяаллын тухайд Зөрчлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор өөрчлөгдөж буй тул харилцан уялдаатай байна.
Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйл буюу Бэлгийн дарамт учруулах зөрчил, 9.1 дүгээр зүйл буюу Боловсролын тухай хууль зөрчих зөрчил, 10.14 дүгээр зүйл буюу Аялал жуулчлалын тухай хууль зөрчих зөрчил, 10.15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг буюу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зөрчих зөрчлийг хассан. Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг болон 11.2 дугаар зүйл буюу Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн.	Хассан зөрчлийн харьяаллын тухайд тус харьяаллыг өөр эрх бүхий албан тушаалтанд хамааруулж харьяаллын хооронд хийдэл үүсгэхгүй байх шаардлагатай.
Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйлийн 3 дахь хэсэг буюу Хөдөлмөрийн аюулгүй	Энэ нь өмнө нь зохицуулсан Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн харьяалалтай давхардаж зөрчил үүсгэж байна.

	байдал, эрүүл ахуйн тухай хууль зөрчих зөрчлийг хассан.	
Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг буюу Ашигт малтмалын тухай хууль зөрчих зөрчлийг нэмсэн. Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйл буюу Аялал жуулчлалын тухай хууль зөрчих зөрчил, 10.29 дүгээр зүйл буюу Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих зөрчлийг хассан.	Нэмсэн зохицуулалтын тухайд тус зөрчлийн харьяаллыг урьд хариуцаж байсан эрх бүхий албан тушаалтны зохицуулалтаас хасах нь зүйтэй. Хассан зохицуулалтын тухайд мөн өөр хариуцах эрх бүхий албан тушаалтны харьяалалд оруулан зохицуулах хэрэгтэй.
Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйл буюу Аялал жуулчлалын тухай хууль зөрчих зөрчил, 10.25 дугаар зүйл буюу Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль зөрчих зөрчлийг хассан байна.	Хассан зөрчлийн харьяаллыг өөр хариуцах эрх бүхий албан тушаалтны харьяалалд оруулан зохицуулах хэрэгтэй.
Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч	Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйл буюу Аялал жуулчлалын тухай хууль зөрчих зөрчил, 10.29 дүгээр зүйл буюу Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих зөрчлийг хассан.	Хассан зохицуулалтын тухайд өөр хариуцах эрх бүхий албан тушаалтны харьяалалд оруулан зохицуулах хэрэгтэй.
Эрүүгийн хэргийн шүүх	Зөрчлийн тухай хуулийн 7.18 дугаар зүйл буюу Генетик нөөцийн тухай хууль зөрчих зөрчлийг Эрүүгийн шүүхийн харьяалалд оруулж зохицуулжээ. Зөрчлийн тухай хуулийн 6.13 дугаар зүйл буюу Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль зөрчих зөрчлийг Эрүүгийн шүүхийн харьяаллаас хассан.	Хассан зохицуулалтын тухайд өөр хариуцах эрх бүхий албан тушаалтны харьяалалд оруулан зохицуулах хэрэгтэй.

Дээрхээс дүгнэвэл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн өөрчлөгдсөн зохицуулалтууд нь ихэвчлэн бусад хуулийн шинэчилсэн найруулга болон нэмэлт, өөрчлөлттэй холбоотой нь тодорхойлогдож байна. Эрх бүхий албан тушаалтан, хэрэгжүүлэгч этгээдүүдийн тухайд харьяаллын зарим зөрчлүүд нь нэмэгдэж, хасагдаж зохицуулагдаж байгаа ч давхардал, хийдэл, зөрчлийг үүсгэх магадлалтай байна. Ялангуяа хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн харьяаллын хооронд зөрчил үүсэхээр байна. Түүнчлэн хуулийн төсөлд эрх бүхий албан тушаалтан, хэрэгжүүлэгч этгээдүүдийн харьяаллыг өөрчилж зохицуулахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн одоо үйлчилж буй заалтыг бүхлээр нь бичиж байгаа нь ойлгомжгүй байдлыг бий

болгож байна. Иймд оруулах гэж буй нэмэлт эсвэл өөрчлөлтийг зөвхөн хуулийн төслөөр тухайлан зохицуулах нь зүйтэй.

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ


“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан, эсхүл торгох шийтгэлийг баривчлах шийтгэлээр сольсон тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, 0-3 насны хүүхэдтэй эх, арван зургаа хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, хүнд өвчтэй хүнийг асран хамгаалж байгаа хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй.” гэх зохицуулалтыг нэмсэн байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчлийн тухай хуулийн 3.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй.” гэж зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл одоогийн нэмэлт, өөрчлөлтөөр дараах байдлаар баривчлах шийтгэл оногдуулахгүй хүнийг өөрчилж зохицуулсан.

Зөрчлийн тухай хууль	Хуулийн төсөл	Өөрчлөлт
жирэмсэн эмэгтэй	жирэмсэн эмэгтэй	Өөрчлөлт оруулаагүй
арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх	0-3 насны хүүхэдтэй эх, арван зургаа хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх	0-3 насны хүүхэдтэй эх гэж тусгайлан оруулснаас гадна 16 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх гэж хүрээг өргөжүүлсэн
	хүнд өвчтэй хүнийг асран хамгаалж байгаа хүн	Тус зохицуулалтыг нэмж өргөжүүлсэн
хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүн	баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүн	баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүн гэж өргөн хүрээнд зохицуулсан ба “баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчин” гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 157 дугаар зүйлийн 157.2-т заасныг ойлгохоор өргөжүүлж зохицуулсан.

Дүгнэвэл, зөрчлийн баривчлах шийтгэл оногдуулахгүй хүний хүрээг өргөжүүлсэн байна.



Тус хуулийн төслийн танилцуулгад тус өөрчлөлтийн агуулгыг дараах байдлаар тодорхойлжээ.

“...НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн 2022 онд Монгол Улсад хийсэн айлчлалын дүгнэлтдээ 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байгаа үйл ажиллагаанд санаа зовниж байгаа болон хүний эрх чөлөөг хасах нь хамгийн эцсийн шатанд авах арга хэмжээ байх ёстой гэдгийг сануулсан байдаг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд заасны дагуу хүний эрх чөлөөг хангах үүднээс баривчлах шийтгэл оногдуулж буй үйлдлүүдийн цар хүрээг Засгийн газар дахин нэг нягталж үзэх нь зүйтэй талаар зөвлөснийг мөн харгалзан үзлээ.

Баривчлах шийтгэлийг оногдуулахгүй байх этгээдийн хүрээ хязгаарыг иргэдийн зүй ёсны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн харьцангуй өргөжүүлэн тусгалаа. Ийнхүү шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, 0-3 насны хүүхэдтэй эх, арван зургаа хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, хүнд өвчтэй хүнийг асран хамгаалж байгаа хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй байхаар тусгалаа.”

2022 оны Аравдугаар сарын 3-14 өдрүүдэд НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг Монголд хийсэн айлчлалын урьдчилсан дүгнэлтээр дараах зөвлөмжийг өгсөн.

“2022 оны Зөрчлийн тухай хуульд зааснаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гэх мэт хөнгөн хэрэг үйлдсэн хүнд 7-оос 30 хоног хүртэл хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах боломжтой байна. Эдгээр саатуулагдсан хүмүүсийг баривчлагдсан этгээд хэмээн нэрлэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харъяа зориулалтын баривчлах байруудад шийтгэлийг эдлүүлдэг. Ажлын хэсэг хэд хэдэн саатуулах байруудаар орж танилцахад харьцангуй дэглэм султай болох нь ажиглагдсан хэдий ч ихэнх саатуулах байранд Монгол Улсын хорих ангиудад хэрэглэдэг улаан шугамыг баривчлагдсан этгээдэд хэрэглэж байна. Энэхүү улаан шугамыг Монгол Улсын бүх саатуулах байруудаар ашиглахыг хориглох нь зүйтэй гэж Ажлын хэсэг дахин давтан хэлье.

Мөн түүнчлэн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байхгүйн улмаас зөрчлийн хэрэгт холбогдогч нь эрүүгийн шүүхээр хэргээ шийдвэрлүүлж байна. Практикт эрүүгийн шүүх нь эрүүгийн хэргийг түрүүнд нь шийдвэрлэж байгаа учраас зөрчилд холбогдогч нь шүүх хурал болох хүртэл дунджаар 4 цаг орчим хүлээх шаардлагатай болж байна. Хүмүүсийг өглөө шүүх хуралдаантай гэж дуудчихаад, хүлээж суух газар ч гаргаж өгөхгүйгээр үдээс хойш хүртэл шүүх хуралдаан нь болохгүй хүлээлгэх нь бараг хэвийн үзэгдэл болсон байна. Гэтэл зөрчлийн хэрэг шийдвэрлэх шүүх хуралдаан нь маш богино буюу 15-20 минутын хугацаанд л үргэлжилдэг. Холбогдогч хууль зүйн туслалцаа авах эрхтэй хэдий ч энэ нь үнэ төлбөргүй биш учраас шүүх хуралдаанд ихэвчлэн хууль зүйн туслалцаа авалгүйгээр оролцож байна. Анхан шатны шүүхийн шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор тухайн шийдвэрт гомдол гаргах боломжтой боловч баривчлах хугацаа нь богино бөгөөд анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу баривчлах шийтгэл оногдуулмагц баривчлагдсан этгээдийг шууд баривчлах байранд аваачиж байгаа учраас шүүхийн шийдвэрт гомдол гаргах тохиолдол практикт ховор байна. Эцэст нь дурдахад баривчлагдсан этгээд

эдгээр баривчлах байранд саатуулагдах хугацаандаа өдрийн 3800 төгрөгийн төлбөр төлөх үүрэг хүлээж байна. Зарим баривчлагдсан этгээд баривчлах байранд засвар үйлчилгээний ажил хийгээд, ажил хийсэн хугацаандаа баривчлах байрны төлбөрөөс чөлөөлөгдөж байна.

Ажлын хэсэг нь хүний эрх чөлөөг хасах нь хамгийн эцсийн шатанд авах арга хэмжээ байх ёстой гэдгийг сануулаад, Зөрчлийн хуулийн дагуу шийтгэл оногдуулж буй үйлдлүүдийн цар хүрээний хувьд санаа зовниж буйгаа илэрхийлж байна. Пактын 9 дүгээр зүйлд заасны дагуу хүний эрх чөлөөг хангах үүднээс баривчлах шийтгэл оногдуулж буй үйлдлүүдийн цар хүрээг Засгийн газар дахин нэг нягталж үзэх нь зүйтэй. Мөн баривчлагдсан этгээд нь баривчлах байранд саатуулагдсанаа төлөө ямар нэгэн төлбөр төлөх үүрэг хүлээхгүй байх нь зүйтэй. Эцэст нь дурдахад хэдий саатуулах хугацаа нь богино байсан ч хүнийг дур мэдэн саатуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд хэрэгжих ёстойг сануулж, зайлшгүй хийгдэх процессын баталгааг, ялангуяа хууль зүйн туслалцаа авах эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэхийг Ажлын хэсэг зөвлөж байна.”⁶¹

Монгол Улсын шүүхийн тайланд зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд 2018 онд 11813, 2019 онд 16235⁶², 2020 онд 17644⁶³, 2021 онд, 16865, 2022 онд 20164⁶⁴ хүнд баривчлах шийтгэл оногдуулсан байна. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүхээс 2018 онд зөрчлийн 12981 хэрэг хүлээн авсан бөгөөд үүний 91% хувьд, 2019 онд зөрчлийн 17656 хэрэг хүлээн авсан бөгөөд үүний 92% хувьд, 2020 онд зөрчлийн 20922 хэрэг хүлээн авсан бөгөөд үүний 84% хувьд, 2021 онд зөрчлийн 21162 хэрэг хүлээн авсан бөгөөд үүний 80% хувьд, 2022 онд 24162 хэргийг хүлээн авсан бөгөөд үүний 83% хувьд тус тус баривчлах шийтгэлийг оногдуулсан байна.

Дээрхээс дүгнэн үзвэл баривчлах шийтгэл оногдуулсан тоо жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд уг 2022 онд 2018 оноос даруй 1.7 дахин их баривчлах шийтгэл оногдуулсан байна. Мөн сүүлийн 5 жилийн хугацаанд анхан шатны шүүхээр шийдэгдэж буй зөрчлийн хэргийн 86 хувьд баривчлах шийтгэл оногдуулж байна.

Тус хуулийн төслөөр зохицуулсан нь ийнхүү хавтгайруулан авч буй зөрчлийн баривчлах шийтгэлийн тоог багасгах ач холбогдолтой ба нөгөө талаар хүний эрх, эрх чөлөөг хангах, хүмүүнлэг, энэрэнгүй байх зарчимд тулгуурласан байна.

Хүний эрх, эрх чөлөөг хангах талаас:

“Хэний ч ... орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нь нууц, эсвэл нэр төр, алдар хүндэд нь дураар халдах ёсгүй. Тийм оролцоо, халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.” (Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 12 дугаар зүйл)

“Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний

⁶¹ НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг: Монголд хийсэн айлчлалын урьдчилсан дүгнэлт (2022 оны Аравдугаар сарын 3-14 өдрүүд), 12 дахь тал.

⁶² Шүүхийн Ерөнхий Зөвлөл, “Монгол Улсын шүүхийн тайлан 2019”, https://docs.google.com/file/d/1KLjeW_olc35vsSPmhSTnas0z80UqsUc8/view

⁶³ Шүүхийн Ерөнхий Зөвлөл, “Монгол Улсын шүүхийн тайлан 2021”, <https://drive.google.com/file/d/1idrOGcvKAIUwiu0FN-StVBBQOOTeWRpH/view>

⁶⁴ Шүүхийн Ерөнхий Зөвлөл, “Монгол Улсын шүүхийн тайлан 2022”, https://drive.google.com/file/d/18oxr2jarQc1JslTkXo_lIXOvAHcRx_Od/view

ч эрх чөлөөг хасч болохгүй.” (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 1 дэх заалт)

“.....Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. “ (Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт)

НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар (№16, 17,2019): Хувийн халдашгүй байх эрх.

17 дугаар зүйл нь бүх хүний хувийн болон гэр бүл, орон байр, захидал харилцааны халдашгүй байдлыг дур мэдэн, хууль бусаар хөндөх, алдар хүндэд хууль бусаар халдахаас ангид байх эрхийг баталгаажуулсан. Энэхүү эрхийг төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч төдийгүй, хувь хүн, хуулийн этгээдийн хөндлөнгийн бүх оролцоо, халдлагаас хамгаалах шаардлагатай гэж Хороо үзэж байна. Энэ заалтын дагуу Оролцогч улс энэхүү эрхийг хамгаалах, хөндлөнгийн оролцоо, халдлагыг хориглох талаар хууль тогтоомжийн болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

Пактад нийцсэн оролцооны хувьд ч холбогдох хууль тогтоомжид тийм оролцоог зөвшөөрсөн нөхцөл байдлын талаар нарийвчлан тайлбарлана. Хуулийн дагуу хүний хувийн халдашгүй байдалд оролцох шийдвэрийг хуулиар тийм эрх олгогдсон байгууллага тохиолдол бүрийг нэг бүрчлэн хянаж гаргана. 17 дугаар зүйлд тогтоосон шаардлагыг хангахын тулд захидал харилцааны нууц, халдашгүй байдлыг хуулиар болон бодит байдал дээр хамгаална. Захидал, харилцаа тасалдахгүй, задрахгүй, бусад хүн уншихгүйгээр хүлээн авагчид очих ёстой. Цахилгаан болон бусад арга хэрэгслийг ашиглан хүнийг тагнах, утсан харилцаа, цахилгаан, бусад харилцааг тасалдуулах, харилцаа холбоог нууцаар чагнах, Дууны бичлэг хийхийг хориглоно. Хүний орон байрыг гагцхүү шаардлагатай эд мөрийн баримтыг олж авах зорилгоор нэгжих бөгөөд ийм үйл ажиллагаа хүнийг айлган сүрдүүлж, дарамтлах шинжгүй байна. Хүний биед хийх үзлэг, нэгжлэг нь түүний нэр төрийг хөндөхгүй байх ёстой. Төрийн алба хаагч, төрөөс эрх олгосон эмнэлгийн ажилтны шийдвэрээр хүний биед үзлэг, нэгжлэг хийх тохиолдолд тухайн хүнтэй адил хүйстэй этгээдээр гүйцэтгүүлнэ.

Төрийн байгууллага, хувь хүн, хувийн хэвшлийн байгууллагаас компьютер, мэдээллийн сан болон төхөөрөмжийн тусламжтай хувийн мэдээллийг цуглуулах, хадлага, ажиллагааг хуулиар зохицуулна. Хүний хувийн амьдралын мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах эрх хуулиар олгогдоогүй этгээд нь уул мэдээллийг олж авах, Пактад үл нийцэх байдлаар ашиглахгүй байх баталгааг бүрдүүлэх талаар ур дүнтэй арга хэмжээг улс орнууд авна. Хувийн амьдралаа ур дүнтэй хамгаалахын тулд өөрт холбоотой мэдээлэл автомат санд байршиж байгаа эсэх, байршиж байгаа бол ямар зорилгоор ямар мэдээлэл хадгалагдан эсэхийг өөрт ойлгомжтой хэлбэрээр мэдэх эрхтэй. Мөн ямар төрийн байгууллага, хувь хүн, нийгмийн хамтлаг өөрийн хувийн мэдээллийг хадгалж байгаа эсэхийг мэдэх, нягтлах эрхтэй. Санд авагдсан хувийн мэдээлэл алдаатай, түүнийг хууль бус аргаар цуглуулсан буюу боловсруулсан тохиолдолд хүн бүр уг мэдээлэлд засвар хийх, устгуулах хүсэлт гаргах эрхтэй байна.

17 дугаар зүйл нь хувь хүний алдар хүндийг хамгаалсан бөгөөд Оролцогч улс нь энэ нөхцөлийг хангах хууль тогтоомжийг батлах үүрэгтэй. Эрх зүйн ийм зохицуулалт нь хувь хүн алдар хүндээ аливаа хууль бус халдлагаас үр дүнтэй хамгаалах, гэм буруутай этгээдэд хариуцлага тооцуулж зөрчигдсэн эрхээ үр дүнтэй сэргээх боломжийг бүрдүүлнэ. Оролцогч улс нь хувь хүний нэр алдар эсхүл нэр хүндийг хуулиар хэрхэн

хамгаалагдсан, тухайн улсын эрх зүйн тогтолцоонд энэхүү хамгаалалт хэрхэн хэрэгжиж байгаа талаар илтгэнэ⁶⁵.

НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар(№35, 9, 2014): Чөлөөтэй, аюулгүй байх эрх.

9 дүгээр зүйлийн 2-оос 5 дахь хэсэгт хүний чөлөөт, аюулгүй байдлыг сахин хамгаалах тодорхой баталгаануудыг заасан. 9 дүгээр зүйлийн зарим заалтууд (2 дахь хэсгийн зарим заалт, 3 дахь хэсэг бүхэлдээ) зөвхөн эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой бол зарим нь, ялангуяа 4 дэх хэсгээр тогтоосон хамгаалалтууд, тодруулбал, баривчлан саатуулсан арга хэмжээний хууль ёсны эсэхийг шүүхээр хянуулах эрх нь эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнд хамаарна.

Оролцогч улс аливаа хувь хүн, аж ахуйн нэгжид бусдыг баривчлан саатуулах, цагдан хорих бүрэн эрх олгосон тохиолдолд 9 дүгээр зүйлийг дагаж мөрдөх үүргээс чөлөөлөгдөхгүй. Олгосон бүрэн эрхийг буруугаар ашиглах, хүнийг дур зоргоор саатуулах, хууль бус баривчлах үйлдэл гаргуулахгүй байх үүднээс эрх мэдлийг хатуу хязгаарлаж, үр нөлөөтэй, тогтвортой хяналт тавина. Дур зоргоор саатуулах, хууль бус баривчлах болон цагдан хорих үйлдлээс хохирсон хүмүүсийн зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээ авна.


Аюулгүй байх эрх нь хохирогч цагдан хоригдсон эсэхээс үл хамаарч хүний бие махбод, сэтгэл санаанд санаатай гэмтэл учрахаас хамгаалах зорилготой. Тухайлбал, Оролцогч улсын төрийн албан хаагч хүний биед үндэслэлгүйгээр гэмтэл учруулсан тохиолдолд аюулгүй байх эрхийг зөрчнө. Аюулгүй байх эрх нь хүмүүс нийтийн орон зайд амь насаа алдах эрсдэлээс хамгаалуулах, тодруулбал аливаа төрийн байгууллага, хувь этгээдээс амь нас, бие махбодын халдашгүй бүхэл байдалд чиглэсэн урьдчилан таамаглаж болохуйц аюулаас хувь хүнийг хамгаалах үүргийг Оролцогч улсад оногдуулсан. Оролцогч улс ирээдүйд учирч болох ийм хохирлоос урьдчилан сэргийлэх, эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх замаар учирсан хохирлыг арилгах арга хэмжээний аль алийг авах үүрэгтэй. Тухайлбал, хүний эрхийг хамгаалагч, сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх, гэрчүүдээс өшөө авах, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, зэвсэгт хүчний байгууллагад шинэ цэргүүдийг дэглэх, хүүхдийг хүчирхийлэх, бэлгийн чиг баримжаа, жендэрийн байдлын улмаас [үзэн ядаж] хүчирхийлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хүчирхийлэх зэрэг хүчирхийллийн олон хэлбэрийн эсрэг зохих хариу арга хэмжээ авна. Оролцогч улс хууль сахиулах ажиллагаанд үндэслэлгүйгээр хүч хэрэглэхээс урьдчилан сэргийлж, хүн амаа хувийн хамгаалалтын албаны зүй бус үйлдэл, галт зэвсгийн түгээмэл хэрэглээнээс үүдэлтэй аливаа эрсдэлээс хамгаална. Аюулгүй байх эрхийн хүрээнд хүний бие махбод, сэтгэцэд учирч болзошгүй бүх эрсдэл хамаарахгүй бөгөөд иргэн, эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас хүний эрүүл мэндэд учирсан шууд бус нөлөөллийг хамруулахгүй⁶⁶.

Тус хуулийн төсөлд дурдсанаар Зөрчлийн тухай хуулийн баривчлах шийтгэлээс чөлөөлөх хүмүүсийг өргөжүүлж байгаа нь хувийн халдашгүй байх эрх, эрх чөлөөг хамгаалах зохицуулалт болжээ.

Хүмүүнлэг, энэрэнгүй байх зарчмын агуулгад нийцэх талаас:

⁶⁵ Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Үндсэн хууль манай сургуульд, 2022, 69, 70 дахь тал.

⁶⁶ Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Үндсэн хууль манай сургуульд, 2022, 74 дэх тал.



Монгол Улсын Үндсэн хуулийн удиртгал хэсэгт "...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгох..."-оор тусгажээ. "Хүмүүнлэг" нийгмийн тухай ойлголт нь энэрэн нигүүлсдэг, өрөвч нинжин үзэл санаатай нийгмийн тухай гэхээс илүүтэй харин бүхний төвд хүнийг тавьсан, улс төр, эдийн засаг, хууль, эрх зүй, соёлын тогтолцоо нь хүн төвтэй байх нийгмийн дүр зургийг илэрхийлнэ. Тодруулбал, хүн төвтэй эдийн засаг нь ашиг орлого, амин хувиа хичээх явдлыг нийгмийн шударга ёс, ёс суртахуунт чанар, баялгийн шударга хуваарилалт, нийгмийн сайн сайхны төлөөх үзлээр хязгаарлан зохицуулсан байхыг шаарддаг бол хүн төвтэй хуулийн тогтолцоо нь хууль нь хууль тогтоогчийн хүсэл зориг, дур зоргоос чөлөөлөгдөж, хүний эрх, эрх чөлөөнөөс эх сурвалжтай, түүнд үндэслэн тулгуурласан байх тухай юм. Өөрөөр хэлбэл, хууль хүний эрх, эрх чөлөөний үндэс бус, харин хүний эрх, эрх чөлөө хуулийн үндэс байх тухай юм⁶⁷.

Энэхүү зарчим нь органик хуульд тусгагдсан байдаг. Тодруулбал, Эрүүгийн хуульд энэрэнгүй ёсны зарчмын агуулгыг тусгасан байдаг ба 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна. Мөн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно." гэж заасан байна.

Иймд Зөрчлийн тухай хуулийн тус нэмэлт, өөрчлөлтөөр баривчлах шийтгэлээс чөлөөлөх хүмүүсийн зохицуулалтыг өргөжүүлж зохицуулсан нь тус зарчимд нийцэхээр байна.

Олон улсын эрх зүйн зохицуулалт:

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан "Ямар ч хэлбэрийн баривчлагдсан болон хорих ялд байгаа бүх хүнийг хамгаалах зарчмууд"-ын 5 дугаар зарчимд дараах байдлаар авч үзсэн.

1. Эдгээр зарчмыг тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа бүх хүнд арьс, өнгө, арьсны өнгө, өмч хөрөнгө, төрсөн болон бусад байдал, хүйс, хэл, шашин шүтлэг, шашны итгэл үнэмшил, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний, угсаатны болон нийгмийн гарал үүсэл зэрэг ямар ч ялгаагүйгээр хэрэглэнэ.

2. Хуульд зааснаар эмэгтэй, ялангуяа жирэмсэн болон хөхүүл эх, хүүхэд, өсвөр насны хүүхэд, өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, онцгой байдлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг ялгаварлан гадуурхсан гэж үзэхгүй. Ийм арга хэмжээ авах хэрэгцээ, хэрэглэгдэхүүнийг шүүх болон бусад эрх бүхий байгууллага үргэлж хянаж байх ёстой⁶⁸.

Зөрчлийн тухай хуулийн тус нэмэлт, өөрчлөлтөөр баривчлах шийтгэлээс чөлөөлөх хүмүүсийн хүрээг өргөжүүлсэн нь нийтлэг жишигт тохирч байна.

⁶⁷ Н.Лүндэндорж, "Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар", УБ, 2022, 31-32 дахь тал.

⁶⁸ Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment ADOPTED 09 December 1988 BY General Assembly resolution 43/173, <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/body-principles-protection-all-persons-under-any-form-detention>

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл буюу Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил, 10.13 дугаар зүйл буюу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль зөрчих зөрчил, 10.16 дугаар зүйл буюу Хөдөлмөрийн тухай хууль зөрчих зөрчлийг тус хуулийн төслөөр өөрчлөн найруулсан байна. Эдгээрийг тус бүрээр нь авч үзье.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил

Зөрчлийн тухай хуулийн 5.4 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	Хуулийн төслийн зохицуулалт
<p>1.Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>2.Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>3.Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:</p> <p>4.1.зодсон;</p> <p>4.2.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;</p> <p>4.3.бусадтай харилцахыг хязгаарласан;</p> <p>4.4.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.</p>	<p>1.Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх, хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>2.Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн журам зөрчиж нэвтэрсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>3.Түр хамгаалах байрыг хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, эсхүл бусадтай харилцахыг хязгаарласан, эсхүл хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>5.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний биед халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.</p>
<p>Өөрчлөлт: Шинэ хуулийн төслөөр хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүргийг зөрчихийг шинээр зохицуулсан байна. Мөн нэг цэгийн үйлчилгээний журам зөрчих, гэр бүлийн хамааралтай хүний биед халдахаас бусад гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд торгох шийтгэл оногдуулахаар зохицуулжээ.</p>	

Хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүрэг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан үүрэг тул харилцан уялдаатай үр дүнтэй зохицуулалт байна. Нэг цэгийн үйлчилгээний журам нь мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлд тусгагдсан учир харилцан уялдаатай байна. Гэр бүлийн хамааралтай хүний биед халдахаас бусад гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд торгох шийтгэл оногдуулахаар зохицуулсан нь бусад хууль тогтоомжтой зөрчилдсэн зүйлгүй тул харилцан уялдаатай байна.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль зөрчих зөрчил

Зөрчлийн тухай хуулийн 10.13 дугаар зүйл буюу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль зөрчих зөрчил	Хуулийн төслийн зохицуулалт
<p>1.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зохих зөвшөөрөлгүйгээр ажиллах хүч, мэргэжилтэн гадаадаас авч ажиллуулсан, эсхүл ажиллах хүч гадаадад гаргасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>2.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө ажлын байрны төлбөрийг хуульд заасан хэмжээгээр төлөөгүй бол төлбөрийг нөхөн төлүүлж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>3.Байгууллага нь:</p> <p>3.1.гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээний биелэлт, гадаадад хөдөлмөр эрхлүүлж байгаа иргэд, гадаадаас авч ажиллуулж байгаа ажиллах хүч, мэргэжилтний талаархи тайлан, мэдээг хуульд заасан журмын дагуу гаргаагүй;</p> <p>3.2.цуцлагдсан, эсхүл сунгасан гэрээний тухай мэдээллийг тухай бүр гаргаагүй;</p> <p>3.3.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүний эрх олгосон байгууллагад цуцлагдсан, эсхүл сунгасан гэрээний тухай мэдээллийг албан ёсоор ирүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн</p>	<p>1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хууль бус хөдөлмөр эрхлүүлсэн бол гадаадын иргэн, харьяалалгүй хүний хөдөлмөр эрхэлсэн хугацааны ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг төлөөгүй бол гадаадын иргэн, харьяалалгүй хүний тухайн ажил олгогчид хөдөлмөр эрхэлсэн хугацааны төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>3.Гадаад ажилтныг хөдөлмөрийн чиг баримжаа олгох сургалтад хамруулаагүй, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах үүргээ биелүүлээгүй хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>4.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан гадаадын ажилтныг нутаг буцаах үүргээ биелүүлээгүй бол гадаадын ажилтны ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучилсан иргэний бүртгэл хөтлөөгүй, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд өгөөгүй, худал тайлан өгсөн бол</p>

<p>этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>4.Байгууллага нь гадаадад хөдөлмөр эрхлүүлж байгаа монгол иргэд, гадаадаас авч ажиллуулж байгаа ажиллах хүч, мэргэжилтнийг хөдөлмөрийн гэрээ дуусмагц эх оронд нь буцаах арга хэмжээ авах үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>5.Хуульд заасныг зөрчиж:</p> <p>5.1.гадаадын иргэн, харьяалалгүй хүн, арван найман насанд хүрээгүй хүнийг хөдөлмөр эрхлүүлэхээр зуучилсан;</p> <p>5.2.химийн хортой, тэсрэх, эсхүл цацраг, биологийн идэвхт бодистой харьцах, хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, борлуулах зэрэг олон улсын хэмжээнд хориглосон ажилд зуучилсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>	<p>хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч зуучлуулагчтай зуучлалын гэрээ байгуулаагүй, зуучлуулагчаас хууль бусаар төлбөр хураамж, барьцаа, бэлэн мөнгө авсан бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>7.Зөвшөөрөлгүйгээр иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучилсан, хөдөлмөр эрхлүүлнэ гэж ухуулан сурталчилсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>Тайлбар: “хууль бус хөдөлмөр эрхлүүлсэн” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлд тодорхойлсон хөдөлмөрийн харилцаанд оролцож, ашиг, орлого олох зорилготой эсэхээс үл хамааран, зөвшөөрөлгүйгээр гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр ажил гүйцэтгүүлсэн, хөлсөөр ажиллуулсан, туслан гүйцэтгүүлсэн бүх төрлийн хөдөлмөр эрхлэлт, тэдгээрийг хөдөлмөр эрхлүүлнэ гэж ухуулан сурталчилсан, элсүүлсэн, зуучилсан, тээвэрлэсэн үйлдлийг ойлгоно.”</p>
<p>Өөрчлөлт: Тус хуулийн төслөөр өмнөх Зөрчлийн тухай хуулийн зохицуулалтын 60 орчим хувьд нь өөрчлөлт оруулж найруулсан байна.</p>	

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль нь 2021 онд батлагдсан ба тус хуульд цөөн тооны нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Одоогийн хуулийн төслөөр тус хуулийг зөрчих зөрчлийн 60 орчим хувьд өөрчлөлт оруулж байгаа нь өмнө нь хэвийн үйлчилж байсан тус хоёр хуулийн үйлчлэлд өөрчлөлт оруулах магадлалтай. Иймд хууль, хуулийн төслийн харилцан уялдааг дахин харах шаардлагатай.

Хөдөлмөрийн тухай хууль зөрчих зөрчил

Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйл буюу Хөдөлмөрийн тухай хууль зөрчих зөрчил	Хуулийн төслийн зохицуулалт
<p>1.Хуульд заасны дагуу ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл одой хүнийг ажиллуулах үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага сар бүр төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>	<p>1.Ажил олгогч, ажил олгогчийн төлөөлөгч хуульд заасныг зөрчиж:</p> <p>1.1.ажилтны эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, эсхүл ажилтны төлөөллийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон, эсхүл уг зорилгоор санхүүгийн болон бусад дэмжлэг амалсан, үзүүлсэн;</p>

2.Насанд хүрээгүй хүнээр зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хүнд ачааг өргүүлсэн, зөөлгөсөн, насанд хүрээгүй хүнийг шөнө, амралтын өдөр, эсхүл илүү цагаар ажиллуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Ажилтныг хуульд заасан илүү цагаар ажиллуулах хязгаарлалтыг зөрчиж илүү цагаар ажиллуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Ажил олгогч:

4.1.хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хийх хэлэлцээнд оролцохоос зайлсхийсэн, эсхүл хугацаанд нь эхлүүлээгүй;

4.2.хамтын маргааныг зуучлагч, эсхүл хөдөлмөрийн арбитраар шийдвэрлүүлэхээс үндэслэлгүй татгалзсан;

4.3.хүнийг ажилд авахдаа түүнтэй хөдөлмөрийн гэрээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр байгуулахгүйгээр ажил, үүрэг гүйцэтгүүлсэн;

4.4.хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэхэд оролцсон ажилтны ажлын байранд гаднаас ажилтан авч ажиллуулсан;

4.5.хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэх, хэлэлцээ хийхэд оролцсон ажилтны төлөөлөгчдөд Хөдөлмөрийн тухай хуульд заасныг зөрчиж сахилгын шийтгэл ногдуулсан, эсхүл ажлаас нь өөрчилсөн, эсхүл халсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, ажил хаялт зохион байгуулах, ажлын байрыг түр хаах, санал зөрүүтэй асуудлаар талууд санал солилцох, чөлөөтэй сонголт хийхэд нь хөндлөнгөөс оролцсон, эсхүл хуульд заасан хязгаарлалтыг зөрчиж, ажил хаяхыг хориглосон байгууллагад ажил хаялт зохион байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

1.2.ажил олгогчийн хяналт дор үйлдвэрчний эвлэл байгуулах, эвлэлдэн нэгдэхийг ажилтанд тулгасан;

1.3.ажилтныг үйлдвэрчний эвлэл байгуулсан, үйл ажиллагаанд нь оролцсон, гишүүнээр элссэнтэй нь холбогдуулан хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг нь дордуулсан;

1.4.ажилтны төлөөлөгчид хамтын хэлэлцээ хийхэд нь хөндлөнгөөс оролцсон, хязгаарласан, албадлага хэрэглэсэн;

1.5.хамтын хэлэлцээ хийх, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулахад шаардагдах мэдээлэл өгөхөөс татгалзсан;

1.6.ажилтны төлөөлөгчид санхүүгийн болон бусад дэмжлэг амлах, үзүүлэх замаар ажил олгогчийн хяналтад байлгахыг оролдсон бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Ажилтан, ажилтны төлөөлөгч хуульд заасныг зөрчиж:

2.1.бусад ажилтныг ялгаварлан гадуурхахад хүргэж болзошгүй шаардлагыг ажил олгогчид тулгасан, ятгасан;

2.2.хамтын хэлэлцээ хийх болон хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх нөхцөлтэйгээр ажил олгогчоос санхүүгийн болон бусад дэмжлэг шаардсан, авсан;

2.3.ажилтан, үйлдвэрчний эвлэлийн гишүүний эвлэлдэн нэгдэх, төлөөлөгчөө сонгох, хамтын үйл ажиллагаанд оролцох эрхээ эдлэх, үл эдлэхэд нь ажил олгогчоос санхүүгийн болон бусад дэмжлэг авах болзол тавьж хөндлөнгөөс оролцсон бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Ажил олгогч хамтын хэлэлцээнд оролцож байгаа, эсхүл оролцсон үйлдвэрчний эвлэлийн ажилтан, сонгуультаан, ажилтны төлөөлөгчид уг ажилтай нь холбогдуулж:

3.1.сахилгын шийтгэл ногдуулсан;

3.2.өөр ажилд шилжүүлсэн;

3.3.цалин хөлсийг бууруулсан;

3.4.хэлэлцээний явцад болон

хэлэлцээ дууссанаас хойш нэг жилийн дотор аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар татан буугдсан болон Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан бол хүнийг

6.Хөдөлмөрийн дотоод журам, ажил, албан тушаалын жагсаалт, ажлын байрны тодорхойлолт болон албан тушаалын лавлах, хөдөлмөрийн норм, норматив, үндсэн цалингийн сүлжээ, жишгийг баталж мөрдөөгүй, өөрийн буруугаас нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр нээгээгүй, зохих бичилтийг хийж баталгаажуулаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдаж байгаа ажилтны хөдөлмөрийн гэрээг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсанаас бусад тохиолдолд цуцалсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж ажил олгогчийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Хөдөлмөрийн гэрээ байгуулсан өдрөөс эхлэн:

8.1.иргэнийг ажилд авсан тушаал гаргаагүй;

~~8.2.нийгмийн даатгалын дэвтэр нээгээгүй;~~

8.3.эрүүл мэндийн даатгалын дэвтэр нээгээгүй;

~~8.4.нийгмийн даатгалын, эсхүл эрүүл мэндийн даатгалын дэвтэрт зохих бичилтийг хийж баталгаажуулаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.~~

9.Ажил олгогч:

9.1.ажилтныг хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллуулж байгаа тохиолдолд ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага үндсэн цалин, хөлс олгосон;

9.2.ажилтны цалин хөлсийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд нь олгоогүй, эсхүл саатуулсан;

9.3.ажилтны буруугүйгээс үүссэн сул зогсолтын олговрыг олгоогүй, эсхүл түүнийг хуулиар тогтоосон хэмжээнээс доогуур тогтоож олгосон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Ажил олгогч нь ажилтны ажил, мэргэжил, мэргэшил, албан тушаал, цалин хөлсний тухай тодорхойлолтыг гаргаж өгөх үүргээ

нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Ажил олгогч ажилтантай хөдөлмөрийн гэрээг байгуулаагүй, эсхүл ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээс хойш ажлын 10 өдрийн дотор хөдөлмөрийн гэрээг бичгээр нөхөн байгуулаагүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Ажил олгогч хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээний дагуу олговол зохих цалин хөлс, олговрыг олгоогүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд нь олгоогүй, эсхүл цалин хөлснөөс үндэслэлгүйгээр суутгал хийсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Ажил олгогч насанд хүрээгүй хүнийг:

6.1.ажилд авахдаа болон ажиллуулах хугацаандаа 18 нас хүртэл нь зургаан сар тутам эрүүл мэндийн үзлэгт хамруулаагүй;

6.2.шөнийн цагаар ажиллуулсан;

6.3.илүү цагаар ажиллуулсан;

6.4.хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулсан;

6.5.уртын ээлжээр ажиллуулсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд 15 нас хүрээгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Жирэмсэн эмэгтэй, гурван нас хүрээгүй хүүхэдтэй, эсхүл 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун тавин

<p>биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>11.Ажил хаялтад оролцох, түүнийг үргэлжлүүлэхийг, эсхүл хуульд зааснаас бусад тохиолдолд ажил хаялтыг зогсоох, түүнд оролцохоос татгалзахыг ажилтанд тулган шаардсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>	<p>нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>9.Жирэмсэн эмэгтэй, гурван нас хүрээгүй хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй, насанд хүрээгүй ажилтан, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр шөнийн цагаар ажиллуулахыг хориглосон ажилтныг шөнийн цагаар ажиллуулсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>10.Хуульд заасны дагуу нийт ажлын байрны дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах үүргээ биелүүлээгүй, эсхүл хуульд заасныг зөрчиж хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>11.Ажил хаялтад оролцсонтой нь холбогдуулан ажилтан, ажилтны төлөөлөгчид сахилгын шийтгэл ногдуулсан, өөр ажилд шилжүүлсэн, ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
<p>Өөрчлөлт: Хөдөлмөрийн тухай хууль зөрчих зөрчлийг тус хуулийн төслөөр 80-90 орчим хувьд нь агуулгын болон найруулгын өөрчлөлт оруулжээ.</p>	

Хуулийн төслөөр Хөдөлмөрийн тухай хууль зөрчих зөрчлийн 80-90 хувьд нь өөрчлөлт оруулж байгаа нь шинэ Хөдөлмөрийн тухай хууль 2022 онд батлагдсантай холбоотой байхаар байна. Гэвч хуулийн төсөлд өмнөх зөрчлийн зохицуулалтын ихэнх хэсэгт өөрчлөлт оруулж, бүтцийг өөрчилсөн байгаа нь өмнөх бий болоод байсан хууль хэрэглээг өөрчилж, харилцан уялдаагүй байдлыг бий болгож магадгүй юм. Иймд 2022 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуультай хуулийн төсөлд заасан зөрчлийг нийцүүлэхээс гадна өмнөх зөрчлийн бүтэц, найруулгыг хадгалах нь чухал байна.

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

ЭХХШТХ-ийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт эрүүгийн хариуцлагыг “ял, албадлагын арга хэмжээнээс” бүрдэнэ гэж хуульчилсан бөгөөд ялын төрлийг тус хуулийн 5.2 дугаар зүйлд хуульчилсан бол 7.2 дугаар зүйлд албадлагын арга хэмжээг дараах байдлаар хуульчилсан байна.

Эрүүгийн хууль дахь ял болон албадлагын хэм хэмжээний төрөл

5.2 дугаар зүйл. Ялын төрөл

1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулна:

- 1.1. торгох ял;
- 1.2. нийтэд тустай ажил хийлгэх ял;
- 1.3. зорчих эрхийг хязгаарлах ял;
- 1.4. хорих ял;
- 1.5. эрх хасах ял.

2. Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн, эрх хасах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ.

7.2 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээний төрөл

1. Шүүх энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно:

- 1.1. үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ;
- 1.2. эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;
- 1.3. хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.

МУ-ын Эрүүгийн хуулиас

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд МУИГХХЗЦТХ-ийн 5 дугаар зүйлийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэлүүдийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүгийн ял шийтгүүлсэн бол уг ялыг эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх хүртэл” гэж байх боловч эрүүгийн хуулийн 7.2-т заасан эрүүгийн хэрэгт шүүхээс хуульд заасан ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж хэрэглэж болох

- Үүрэг хүлээлгэх ;
- Эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг шүүхээс авсан тохиолдолд гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэлд багтаан хуульчлаагүй байна.

Иймд тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5.1.3 дахь Монгол улсын иргэнийг гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахыг түдгэлзүүлэх үндэслэлд “ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол уг хугацаа дуусах, эсхүл шүүхээс уг албадлагын арга хэмжээг хүчингүй болгох

хүртэл” гэсэн зохицуулалт нь МУ-ын ЭХ-ийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.” гэж заасан эрүүгийн хариуцлагын зорилго, 1.1 дүгээр зүйлд заасан 1 дэх хэсэг дэх “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.” Эрүүгийн хуулийн зорилго болон МУИГХХЗЦТХ-ийн 1 дүгээр зүйлд заасан “Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах, эх орондоо буцаж ирэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн хуулийн зорилтууд болон зохицуулалтуудтай нийцэж байх тул зорилгодоо нийцсэн байх шалгуурыг хангаж байна.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 18 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.” гэж заасан.

1994 онд баталсан Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх буюу хилийн хоригтой холбоотой асуудлыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа тус хуульд үндэслэл, хугацааг тусгасан боловч хилийн хоригийн талаарх мэдээллийг бүрдүүлэхэд эрх бүхий байгууллагуудын олон тусдаа шийдвэрээр баталсан журмууд хэрэгждэг, нэгдсэн бүртгэл байхгүй тул уг үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, харилцан мэдээлэл солилцох зохицуулалтыг бий болгох шаардлага байсаар байна. Иймээс хуульд тусгасан Монгол Улсын иргэний Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлдүүлэх үндэслэлийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөн найрууллаа⁶⁹ гэж ууг хуулийн төслийн танилцуулгад дурдсан байна. Иймд тус хуулийн төслийн 1 дүгээр зүйл дэх “Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийг өөрчлөн найруулсан” зохицуулалтын шинээр орсон болон агуулгын хувьд өөрчлөн найруулсан заалтыг уг хэсэгт сонгох авсан үнэлэх шалгуураар үнэллээ.

Одоо мөрдөгдөж байгаа МУИГХХЗЦТХ-ийн 5 дугаар зүйлийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэлүүдийн 1.1-т “гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол уг хэргийг шийдвэрлэх хүртэл” гэж заасан байх бөгөөд харин уг хуулийн төслийн 1 дүгээр зүйлд уг зохицуулалтыг “эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэн өдрөөс эхлэн уг тогтоолыг хүчингүй болгох, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох хүртэл” гэж өөрчлөн найруулахаар тусгасан байна.

Учир нь салбар эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр МУ-ын ЭХХШТХ-ийн шинэчилсэн найруулгыг батлан гаргаж, дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд уг хуулийн тус хуулийн төслийн 1 дүгээр зүйл дэх “эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэн өдрөөс эхлэн уг тогтоолыг хүчингүй болгох,

⁶⁹ ХЗДХЯ, Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга (2024)

эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох” гэсэн нэр томьёо, процесс ажиллагаа дараах байдлаар зохицуулагдсан байна.

7.1 дүгээр зүйл.Яллагдагч

1.Энэ хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг яллагдагч гэнэ.

19.3 дугаар зүйл.Хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа

4.Шүүх дараахь шийдвэр гаргана:

4.3.гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан шүүгдэгчийн сэтгэцийн байдал нь өөртөө, эсхүл бусдад аюул учруулахааргүй бол эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох;

5.Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй байдал тогтоогдвол түүний өвчилсөн эсэхийг үл харгалзан эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгоно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас

Мөн ЭХХШТХ-ийн гучин хоёрдугаар бүлгийн 32.5 дугаар зүйлд “Хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох” тухай журам, зохицуулалтыг дэлгэрэнгүй хуульчилсан байна.

Иймд уг хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5.1.1 дэх зохицуулалтын эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэн өдрөөс эхлэн уг тогтоолыг хүчингүй болгох, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох” гэсэн нь ЭХХШТХ-ийн нэр томьёо болон процесс ажиллагааны үе шаттай нийцүүлэн тодорхой найруулсан, ойлгомжтой буюу хууль хоорондын уялдаа холбоог хангасан байх тул ойлгомжтой байх байдлын шалгуурыг тус хуулийн төслийн зохицуулалт нь хангаж байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

МУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж насанд хүрээгүй хүүхдийн эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулан хамгаалсан байдаг. Энэхүү үзэл баримтлал, зарчмын хүрээнд 18 насанд хүрээгүй хүүхдийн⁷⁰ эрх, ашиг сонирхлын онцгойлон авч үзэж, хамгаалахаар зохицуулсан Хүүхдийн эрхийн тухай хууль (2016), Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966), Иргэний хууль (2002), Гэр бүлийн тухай хууль (1999), Хүүхэд хамгааллын тухай хууль (2016) гэх мэт хууль тогтоож, олон улсын гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна.

⁷⁰ Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989). **1 дүгээр зүйл.** Энэхүү Конвенцийн зорилгод тухайн хүүхдэд хэрэглэх хуулийн дагуу тэрээр 18наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ.

<https://legalinfo.mn/mn/detail/1276>

Хүүхдийн эрхийн тухай хууль (2016). **3.1.**Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11709>

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд тус хуралдаанаас Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хуулиар тусгайлан эрх олгосон заалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг даалгасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн салбарт хамаарах Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй 35 хуулиар 160 гаруй дүрэм, журам батлах эрхийг Засгийн газар, Засгийн газрын гишүүн болон агентлаг, байгууллагын даргад олгосон байгааг судалж үзээд тэдгээрийн 50 орчим хувь нь зайлшгүй хуулиар зохицуулах ёстой буюу хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, харилцаанд оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжтэй зохицуулалт агуулсан байгааг хуулийн төсөл болгон боловсруулж, холбогдох хуулиудад тусгах нь зүйтэй гэж үзсэн байна.⁷¹

Энэ хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон хүүхдийн эрхийг хамгаалах зорилгод нийцүүлэх, хүний эрхэд зөвхөн хуулиар хязгаарлалт тавих Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг баримтлан насанд хүрээгүй хүүхдийг улсын хилээр нэвтрүүлэх тухай зохицуулалтыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан журмаар зохицуулж байсныг хуулийн төсөлд тусгаж, эрх шилжүүлсэн заалтыг хүчингүй болгохоор тусгасан байна.⁷²

Энэ утгаараа дээр дурдсан хууль тогтоомж, олон улсын гэрээнд дурдсан насанд хүрээгүй хүүхдийн эрхийг хамгаалах, түүний хуульд заасан эрхэд хуулиар хязгаарлах МУ-ын Үндсэн хуулийн зарчмыг баримтлан тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг буюу насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүйд тооцогдсон иргэний гадаад зорчих журмыг хуульчлахаар боловсруулсан байна.

Харин уг хуулийн төслөөр боловсруулж буй насанд хүрээгүй иргэний хамтаар мөн иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон иргэний гадаадад зорчих эрхийг хамтатган хуульчилсан байх бөгөөд иргэний эрх зүйн чадамжийн талаар МУ-ын иргэний хуулийн 14-19 дүгээр зүйлд зохицуулсан байх бөгөөд иргэний эрх зүйн чадамжгүй иргэний тухай дараах байдлаар зохицуулсан байна.

18 дугаар зүйл. Иргэний эрх зүйн чадамжгүй иргэн

18.1. 7 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн чадамжгүй байна.

18.2. Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно.

18.3. Иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хэлцэл хийнэ.

18.4. Иргэний эрх зүйн чадамжгүйд тооцох үндэслэл болсон нөхцөл байдал үгүй болсон тохиолдолд шүүх тухайн этгээдийг иргэний эрх зүйн чадамжгүйд тооцсон шийдвэрийг хүчингүй болгоно.

МУ-ын Иргэний хуулиас

⁷¹ ХЗДХЯ, Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга (2024).

⁷² Мөн тэнд.

1. Хуулийн төслийн 7.2 дугаар зүйл

Тус хуулийн төслийн 7.2 дугаар зүйлд заасан журмын дагуу насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүйд тооцогдсон иргэн эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс өөр хүний хамт гадаадад зорчих тохиолдолд тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүйд тооцогдсон иргэний хамт гадаад улсад зорчих этгээдэд олгосон итгэмжлэлийг үндэслэн улсын хилээр нэвтрүүлнэ гэж зохицуулсан байна.

Гэр бүлийн тухай 25.3 – т зааснаар “*Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаална*” гэж заасан бөгөөд иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу 7 хүртэлх насны хүүхэд болон бусад иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ хэлцэл хийх эрх, үүргийг хүлээдэг. Иргэний хуулийн 18.3 дахь хэсэгт заасан уг эрх нь хуульд зааснаар үүсэх төлөөлөх бүрэн эрх юм.

Иймд насанд хүрээгүй хүүхэд болон эрх зүйн чадамжгүй этгээдийг хуульд зааснаар төлөөлөх бүрэн эрхийг хүлээсэн хүн өөрийн уг эрхээ бусдад шилжүүлэхдээ иргэний хуулийн 64 дүгээр зүйлд “*Төлөөлүүлэгч нь төлөөлөгч болон түүнтэй хэлцэл хийх гуравдагч этгээдэд төлөөлүүлэх тухайгаа болон төлөөлөгчийн бүрэн эрхийн талаар амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдсэнээр төлөөлөгчид бүрэн эрх олгож болно.*” Гэж заасан журмын дагуу өөрийн уг бүрэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлнэ.

Иймд тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “*Насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүйд тооцогдсон иргэн эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс өөр хүний хамт гадаадад зорчих тохиолдолд энэ хуулийн 7.1-д заасан этгээдээс насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүйд тооцогдсон иргэний хамт гадаад улсад зорчих этгээдэд олгосон итгэмжлэлийг үндэслэн улсын хилээр нэвтрүүлнэ.*” гэсэн журам нь дээр дурдсан бусад хууль тогтоомж болон иргэний хуульд заасан иргэний эрх зүйн чадамж, тэдгээрийг хуулийн дагуу төлөөлөх, уг эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх МУ-ын иргэний эрх зүйн зарчим, хууль тогтоомжид нийцэж байх тул уг хуулийн төслийн заалт нь хүлээн зөвшөөрөгдөх байдлын шалгуурыг хангаж байна.

2. Хуулийн төслийн 7.3, 7.4 дүгээр зүйл

МУ-ын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т “*Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.*” гэж заасан бол 16.11-т “*Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;*” Гэр бүлийн тухай хуулийн 4.4-т энэ зарчмыг баталгаажуулсан байдаг.

Дээрх хуулийн заалтуудаас үзэхэд насанд хүрээгүй хүүхэд, эрх зүйн чадамжгүйд тооцогдсон этгээдийн эрх, ашиг сонирхлын тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч буюу хуульд зааснаар төлөөлөх бүрэн эрх бүхий этгээдээс гадна төрийн зүгээс онцгойлон хамгаалахаар байна.

Тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн МУИГХХЗЦтХ-ийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “*...улсын хилээр хамт нэвтэрсэн насанд хүрээгүй иргэнийг гадаад улсад үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаарх мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө*” гэж заасан байна. Хил хамгаалах байгууллагын тухай хуулийн 3.1.11-т зааснаар

улсын хил хамгаалах байгууллага гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг хэлэх бөгөөд хил хамгаалах байгууллага нь улсын хилээр гарах хөдөлгөөний чиглэлд гаалийн, улсын хил хамгаалах байгууллага хяналт тавих⁷³, улсын хил хамгаалах байгууллага нь зорчигчийн улсын хил нэвтрэх эрхийн баримт бичигт тэмдэглэл хийж, улсын хил нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтөлж, нэгдсэн сан байгуулах⁷⁴ чиг үүргийг тус тус хуулиар хүлээдэг.

Иймд тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн МУИГХХЗЦТХ-ийн 7.3, 7.4 дүгээр зүйлийн өөрчлөн найруулгын агуулга болон хил хамгаалах байгууллагын хүлээх үүрэг нь дээр дурдсан МУ-ын Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хуулийн зарчим болон хил хамгаалах тухай хууль болон цагдаагийн албаны тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэж байх тул хүлээн зөвшөөрөгдөх байдлын шалгуурыг хангаж байна.

ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Өмгөөллийн тухай хууль”-ийн 8 дугаар зүйлд өмгөөлөгчийн шалгалтын талаар зохицуулсан байх байгаад уг зүйлийн 8.6-д өмгөөлөгчийн шалгалтад хуульчийг оруулахаас татгалзах долоон үндэслэлийг (8.6.1-8.6.7) зохицуулсан байна. Эдгээр үндэслэлийн 8.6.3-д *“энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа;”* этгээдийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзана гэж заасан байх бөгөөд уг хуулийн 15.1.12, 15.1.3-т :

- хууль зүйн чиглэлээр багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, өмгөөллийн хуулийн этгээд, мэргэжлийн холбоо, түүний хороодын чиг үүрэгт хамаарахаас бусад ажил, албан тушаал хавсран эрхлэх;
- улс төрийн нам, түүний харьяа, салбар, бүтцийн нэгжид орон тооны ажил, албан тушаал хавсран эрхлэх;

гэж заасан ажил, албан тушаалыг өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхлэхийг хориглосон байна.

Уг асуудлын хувьд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргаж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар тогтоолоор *“Өмгөөллийн тухай хуулийн дээрх заалт нь тухайн мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан тавьсан нийтлэг хязгаарлалт байх бөгөөд эрх зүйн байдлын хувьд адил тэгш этгээдүүдэд зүй бус ялгаварлал, алагчилсан байдал үүсгэсэн гэж үзэх үндэслэлгүй байна.”* гэж дүгнэсэн бөгөөд тус тогтоолд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч маргааныг шалгах явцад ирүүлсэн тайлбар болон Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт нь Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан байх магадлалтай гэж хүлээн зөвшөөрсөн байна.⁷⁵ Мөн тус тогтоолд *“...Өмгөөллийн тухай*

⁷³ Монгол Улсын Хилийн тухай хууль (2016), 17.1.3 дахь хэсэг.

<https://legalinfo.mn/mn/detail/12418>

⁷⁴ Монгол Улсын Хилийн тухай хууль (2016), 17.3 дахь хэсэг.

⁷⁵ МУ-ын Үндсэн Хуулийн Цэцийн “Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” дугаар 02 тогтоол.

хуулийн зохицуулалт хоорондын уялдааг зохистой хангах, хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх хууль зүйн баталгааг сайжруулах зорилгоор тус хуулийг боловсронгуй болгох нь зүйтэй гэж Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын бүрэлдэхүүн үзлээ...” гэсэн дүгнэлтийг өгсөн байна.

Иймд иргэний гаргасан мэдээлэл, Үндсэн хуулийн цэцийн тогтоол, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбарыг үндэслэн Өмгөөллийн тухай хуулийн дээрх заалтыг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзэж тус хуулийн төслийг боловсруулсан байна.⁷⁶

Тус хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан зохицуулалт хэрэгжвэл дээр дурдсан үйл ажиллагаа, албан тушаалыг эрхэлж буй хуульд заасан шаардлагыг хангасан хуульчид өмгөөллийн шалгалтад орох эрхтэй болох юм. Харин өмгөөлөгчийн шалгалтад тэнцэж өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй болсон тохиолдолд хуульчид тус хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан ажил, албан тушаалыг өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхлэхийг хориглосон зохицуулалт хэвээр үлдэх буюу эдгээр ажил, албан тушаалыг эрхлэхээ зогсоох ёстой гэж хуулийн агуулгаас ойлгогдохоор байна.

Иймд тус хуулийн төсөл нь хэрэгцээ шаардлагын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгөө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгөө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургаадугаар зүйлийн 4 дэх заалтад “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасан үндсэн хуулийн зохицуулалтыг өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж буй өмгөөлөгчийн хувьд адил үйлчлэх практик хэрэгцээ шаардлагын хангахын зэрэгцээ өмгөөллийн тухай хуулийн “...өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах...”⁷⁷ зорилгод нийцэж байна.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Өмгөөллийн тухай хууль”-ийн 14.1.15-д заасны дагуу өмгөөлөгч нь өмгөөлөгчдийн холбоонд гишүүнчлэлийн хураамж төлөх үүргийг хүлээж байна. 2019 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн “Өмгөөллийн тухай хууль” хуулийн хамтаар “Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийг⁷⁸ баталсан бөгөөд уг хуулийн 5 дугаар зүйлд “Өмгөөллийн тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох, Монголын Хуульчдын холбоо болон

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532143822611>

⁷⁶ Өмгөөллийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар танилцуулга (2024).

⁷⁷ Өмгөөллийн тухай хууль (2019), 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт, 1.1 дэх хэсэг.

⁷⁸ Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль (2019),

https://legalinfo.mn/mn/detail/14860?fbclid=IwZXh0bgNhZW0CMTAAAR3LPILpA8LEPNPC-8Fd64WJxU2vAUKuf4OpvsJLaGd6uh2ZSrGySYVHk0Q_aem_AXPPXbi7yZVE2DBPgYEZbCd1Hy-rN4sheP3ore9x_RYJ6JJ9Nlqg5Ns7-Tap87FEnXkogYS9NO2qWx6oylICq6wT

Өмгөөлөгчдийн Холбооны үйл ажиллагааг уялдуулах, чиг үүргийг оновчтой хуваарилах, өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байхаар холбогдох хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор өргөн мэдүүлнэ.” гэж зохицуулсан байна. Гэсэн хэдий ч уг хуулийн заалт хэрэгжилгүй өнөөдрийг хүрсэн бөгөөд өмгөөлөгчийн шалгалт өгч, өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрх авсан хуульч нь Хуульчидын холбоо болон Өмгөөлөгчдийн холбоонд давхар татвар, хураамж төлж байгаа юм.

Уг давхар татвар хураамжийн асуудалд өмгөөлөгчид шүүмжлэлтэй хандаж, Монголын өмгөөлөгчдийн холбоонд болон олон нийтийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлсээр ирсэн байна. Тухайлбал, 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн өмгөөлөгчид Монголын Хуульчдын холбооны гишүүний татвар төлөлтийн асуудлыг яаралтай шийдвэрлэх арга зам, өмгөөлөгчдийн эрх ашгийг хамгаалах ажлын хэсэг байгуулах зэрэг арга хэмжээ авч байсан⁷⁹ боловч уг асуудал эрх бүхий байгууллагын зүгээс холбогдох шийдвэрийг авахгүй явсаар өдийг хүрсэн байна.

Тиймээс уг хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан зохицуулалт хүчин төгөлдөр болсноор “Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийн 5 дугаар зүйлд заасан хуулийн заалт хэрэгжиж Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч /хуульч/ нь гишүүнчлэлийн хураамжийг сайн дурын үндсэн дээр Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны аль нэгд төлөх буюу гишүүнчлэлийн хураамж төлөх үүргийг давхар хүлээхгүй болох юм.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Уг хуулийн төслийн 1 дүгээр зүйлд өмгөөлөгч нь татвар, хураамж төлөхдөө сонгох байдлаар буюу “...гишүүнчлэлийн хураамжийг сайн дурын үндсэн дээр Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны аль нэгд төлнө.” Гэж заасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагын 29.1.5-д зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх гэсэн үндсэн шаардлагыг хангахгүй байна:

Учир нь Өмгөөллийн тухай хуулийн 48.1-д “Өмгөөлөгчдийн Холбооны хөрөнгө нь гишүүнчлэлийн хураамж, хандив, тусламж, шалгалт, үргэлжилсэн сургалтын хураамж, хэвлэн нийтлэлийн орлогоос бүрдэнэ.”, 14.1.15-д өмгөөлөгчид “гишүүнчлэлийн хураамж төлөх”-ийг заавал дагаж мөрдөх үүрэг болгон хуульчилж, ийнхүү төлөөгүй тохиолдолд өмгөөллийн үйл ажиллагааг хүчингүй болгох хүртэл хариуцлагын тогтолцоог⁸⁰ хуульчилсан байна. Гэтэл тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “гишүүнчлэлийн хураамжийг сайн дурын үндсэн дээр.. төлнө” гэж “сайн дурын” гэх үгийг

⁷⁹ Монголын хуульчдын холбооны гишүүний татварын асуудлыг шийдвэрлүүлэх талаар хуралдав, 2022.10.14. https://www.facebook.com/ama.org.mn/posts/8045024418900923/?paipv=0&eav=AfYCG3mBOU9YNzWMGUSrSDnYDzMg29iw7MGFiDs0XhTLP55mhHI0y5dTU6h4H2kk-q8&_rdi

сүүлд 2024.04.17-нд хандсан

⁸⁰ Өмгөөллийн тухай хууль (2019),

11 дүгээр зүйл. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгох

11.1. Дараах үндэслэлээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгоно:

11.1.2. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гишүүнчлэлийн хураамжийг нэг жил, түүнээс дээш хугацаагаар төлөөгүй.

сонгон хэрэглэсэн нь өмгөөлөгчийн хураамжийг өмгөөлөгчдийн холбоо эсхүл хуульчдын холбооны аль нэгэнд хураамжаа төлөх сонгох эрхийг баталгаажуулсан зохицуулалт мэт боловч хэл найруулгын хувьд “сайн дурын үндсэн дээр” гэдэг үг нь гишүүнчлэлийн хураамжийг төлөхгүй байх сонгох боломжийг олгож буй мэт байна.

Хэрэв уг утгаар хуульд нэмэлт өөрчлөлт орвол уг зүйл, заалт нь хэл найруулгын хувьд “Өмгөөллийн тухай хууль”-ийн 14.1.15-д заасан өмгөөлөгчийн гишүүнчлэлийн хураамж төлөх үүрэгтэй агуулгын хувьд зөрчилтэй байдлаар ойлгогдож болохоор байна. Иймд уг хуулийн төслийн 1 дүгээр зүйлд дэх “сайн дурын үндсэн дээр” гэсэн найруулгыг өөр үгээр орлуулан засах эсхүл хасах шаардлагатай байна.

СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

ХЗДХЯ-наас Хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ конвенцид нийцүүлэх зорилгоор боловсруулсан хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хуулийн төслийн үзэл баримтлалд хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслийн зорилго нь үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх болно гэж тусгажээ.

Иймд хуулийн төслийн 2 дугаар зүйлд Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн” гэснийг, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийг хасахаар заасан зохицуулалт дээрх хуулийн төслийн зорилгод хүрэх байдлыг шалган заажээ.

Төсөлд хасагдахаар тусгагдсан зүйл, заалт

Зүйл, заалт	Агуулга
32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалт	32.2.Дараах этгээдийг бусад сэжигтэн, яллагдагчаас тусгаарлан хорино: 32.2.3.онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн гэмт хэрэгт удаа дараа шийтгүүлсэн этгээд;
35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг	35.4.Хохирлыг хоригдсон этгээдийн садан төрөл, бусад хүмүүс барагдуулж болно.

1. Төслийн 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалт зорилгодоо хүрсэн эсэх

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “онц аюултай гэмт хэрэгтэн түүнчлэн” гэснийг хасах нь хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслийн үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх гэсэн зорилгод хүрч байгаа эсэхийг шалган үзвэл:

Төслийн 32 дугаар зүйлд 32.2-т дараахь этгээдийг бусад сэжигтэн, яллагдагчаас тусгаарлан хорихоор заасан бөгөөд тус зүйлийн 32.2.3-т онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн гэмт хэрэгт удаа дараа шийтгүүлсэн этгээд гэж заасан.

Онц аюултай гэмт хэрэгтэн гэх ойлголт нь 2002 оны Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлд тусгагдсан байсан.

Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйл. Онц аюултай гэмт хэрэгтэн

24.1. Дараахь этгээдийг шүүх онц аюултай гэмт хэрэгтэнд тооцно:

24.1.1. урьд нь хүнд гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ялаар хоёр удаа шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин хүнд гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээд;

24.1.2. урьд нь хүнд буюу онц хүнд гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ялаар шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин онц хүнд гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээд;

24.1.3. урьд нь хорих ял шийтгүүлж байгаагүй боловч онц хүнд гэмт хэрэг давтан санаатай үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээд;

24.1.4. гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн, энэ хуулийн 36.5-д заасан гэмт бүлэглэлийн гишүүн.

2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх болсон. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар онц аюултай гэмт хэрэгтэн, ялтай байдал гэж нэрлэн заасан, хууль зүйн үр дагавар үүсгэдэг ойлголтыг өөрчилж, тусгай ангийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон авч үзэхгүй⁸¹ гэж тусгасан бол Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд 2002 оны Эрүүгийн хуульд заасан баривчлах ял, ялтай байдал, онц аюултай гэмт хэрэгтэн, давтан гэх мэт гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулах хууль зүйн үр дагавар үүсгэдэг байсан зохицуулалтыг хүчингүй болгон, цаазаар авах ялыг халж, хорих ялын дээд хэмжээг багасгасан, зарим зохицуулалт, гэмт хэргийн шинжийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтээ нийцүүлсэн шинээр тусгасан нь дэвшилттэй алхам болсон⁸² гэжээ.

Дээрхээс үзвэл, онц аюултай гэмт хэрэгтэн гэх ойлголтыг Эрүүгийн хуулиас хассан нь хүний эрхийг хангах, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн чухал өөрчлөлт болсон. Гэтэл Эрүүгийн хуулиас хассан “онц аюултай гэмт хэрэгтэн” гэх ойлголтыг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өнөөдрийг хүртэл тусгагдсан хэвээр байгаа нь хууль хоорондын уялдаа холбоог алдагдуулж байна. Иймд хуулийн төсөлд тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн” гэснийг хасахаар тусгасан нь хууль хоорондын уялдаа холбоо хангах, хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход эерэг нөлөөтэй зохицуулалт болжээ. Иймд хуулийн төслийн тус зохицуулалт нь зорилгодоо хүрч байна гэж дүгнэж байна.

2. Төслийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэг зорилгодоо хүрсэн эсэх

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт “Хохирлыг хоригдсон этгээдийн садан төрөл, бусад хүмүүс барагдуулж болно” гэж заасныг хасахаар тусгасан нь хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслийн үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй

⁸¹ Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, 2014 он.

⁸² Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, 2016 он.

болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх гэсэн зорилгод хүрч байгаа эсэхийг шалган үзвэл:

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт *“Хохирлыг хоригдсон этгээдийн садан төрөл, бусад хүмүүс барагдуулж болно”* гэж заасан нь тухайн гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийг хамгаалах, хохирлоо нөхөн төлүүлэхэд чиглэсэн зохицуулалт мэт боловч нөгөө талдаа сэжигтэн, яллагдагчийн /хоригдсон этгээд/ садан төрөл, бусад ойр дотны хүнд хоригдсон этгээдийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдад учруулсан хохирлыг хамааруулан төлүүлэх, өөрөө гэмт хэрэг үйлдээгүй боловч бусдад учирсан хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт болж байсныг тус хуулиас хасахаар төсөлд тусгасан нь хүний эрхийг хамгаалахад эерэг нөлөө үзүүлэхүйц зохицуулалт байна. Тус хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт зохицуулалтаас харвал:

1/ хоригдсон этгээдийн садан төрөл

2/ бусад хүмүүс тухайн хохирлыг төлж барагдуулж болохоор байна.


Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу төрлийн хүнд гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхэд, садангийн хүнд гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхэд тус тус хамаарахаар хуульчилсан байдаг. Харин бусад хүмүүс гэдэгт садан төрлөөс бусад бүх хүн хамаарах бөгөөд тухайлбал, хоригдогчийн найз нөхөд, ажлын хамт олон гэх мэт маш өргөн хүрээг хамарч байгаа юм. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т *“... Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно...”* гэж, Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 3-т *“...Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй...”* гэх зохицуулалттай зөрчилдөж байсан. Иймд тус зохицуулалтыг хасахаар хуулийн төсөлд тусгасан нь зорилгодоо хүрсэн байна.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт *“Хоригдсон этгээдэд ирсэн болон тэднээс явуулсан захидал, цахилгааныг хорих байрны захиргаа заавал хянана. Гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход саад болохуйц утгатай нууц үг хэллэг, шифртэй, төрийн болон хуулиар хамгаалагдсан бусад нууцтай холбоотой захидал, цахилгааныг хорих шийдвэр гаргасан албан тушаалтанд шилжүүлнэ”* гэж хуульчилжээ.

Тус зохицуулалтын “заавал хянана” гэснийг “хянаж болно” гэж өөрчлөн найруулахаар хуулийн төсөлд тусгасан байна. Өөрөөр хэлбэл, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй дээрх хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт зааснаар хоригдсон этгээдэд ирсэн болон тэднээс явуулсан захидал, цахилгааныг хорих байрны захиргаа заавал хянадаг байдал нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан хувь хүний захидал харилцааны нууцад шууд халдаж байсан зохицуулалт юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т *“...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар*



хамгаална...” гэж, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “захидал харилцааны мэдээлэл” гэж захидал, илгээмж, цахим шуудан, харилцаа холбоо, мэдээллийн технологи ашиглан солилцож байгаа мэдээллийг, мөн зүйлийн 4.1.12-т заасан хүний эмзэг мэдээлэлд захидал харилцааны мэдээлэл хамаарахаар тодорхойлсон бөгөөд энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д захидал харилцааны мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарахаар тус тус хуульчилжээ.

ЭХХШТХ-ийн 1.11 дүгээр зүйлд заасны дагуу иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны мэдээллийг хуулиар хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болохоор зохицуулсан бол ШШГТХ-ийн 145 дугаар зүйлд заасан баривчлах байрны дотоод журамд уулзалт хийх, утсаар яриулах, илгээмж, захидал хүлээн авах, хуваарилах, гадаалах асуудлыг тусгахаар хуульчилсан бөгөөд тус хуулийн 146 дугаар зүйлийн 146.3 дахь хэсэгт “баривчлагдсан этгээд 7 хоногт нэг удаа 1 цаг хүртэл хугацаагаар бусадтай уулзалт хийж, нэг удаа илгээмж авч, нэг удаа захидал илгээж болно” гэж тус тус заажээ.


Нөгөөтээгүүр сэжигтэн, яллагдагч нь тухайн гэмт хэргийг үйлдсэн эсэх нь зарим тохиолдолд бүрэн нотлогдоогүй байдаг. ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлд зааснаар шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, мөн Эрүүгийн хэрэгт хамаарал бүхий нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч шүүгдэгчийг гэм буруутай эсэхэд эргэлзээ гарвал сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэхээр зохицуулсан зохицуулалтуудаас үзвэл сэжигтэн, яллагдагч нь тухайн гэмт хэргийг үйлдээгүй байж ч болох талтайг анхааран үзэх нь зүйтэй. Түүнчлэн, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан “Хоригдсон этгээдэд ирсэн болон тэднээс явуулсан захидал, цахилгааныг хорих байрны захиргаа заавал хянана...” гэх зохицуулалт нь сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорьсон үед хүний захидал харилцааны нууцад халдах, ШШГТХ-д заасан захидал илгээх эрхийг хэлбэрийн төдий байдлаар хангах нөхцөлийг бүрдүүлж байсан. Иймд хуулийн дээрх зохицуулалтыг “заавал хянана” гэснийг “хянаж болно” буюу сонгох боломжтой байдлаар хуульчилсан нь хүний эрхийг хангахад чиглэсэн эерэг өөрчлөлт болж байна Иймд төслийн энэхүү зохицуулалт практикт хэрэгжих бүрэн боломжтой зохицуулалт юм.

ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэг болон 14 дүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөлд албаны нууцыг тодорхойлох шалгуур үзүүлэлт буюу түүнд тавигдах зайлшгүй шаардлагыг тусгасан. Тухайлбал, тухайн мэдээллийг хамгаалах зорилго нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүний эрх, эрх чөлөө, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахад чиглэсэн байх, тухайн мэдээллийг задруулснаар учрах хохирлыг хохирлын үнэлгээгээр заавал тогтоосон байх, учрах хохирол нь олон нийтийн мэдээлэлтэй байх эрх ашгаас давахаар байх зэрэг шаардлагыг



тусгасан, төрийн байгууллага, бусад хуулийн этгээд, албан тушаалтны хууль бус үйлдлийг нуух зорилготой бол мэдээллийг албаны нууцад хамааруулахыг хориглосон зэрэг⁸³ нь хуулийн төслийн зорилгод нийцсэн, дэвшилтэт зохицуулалт болсон байгааг юун түрүүнд дурдах нь зүйтэй. Цаашлаад хязгаарлалттай мэдээллийг өгөхөөс татгалзсан бол татгалзсан үндэслэлээ тухайн байгууллага тайлбарлах үүрэгтэй байхаар тусгасан нь иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахад туйлын ач холбогдолтой байна.

Цаашлаад төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээлэл байгаа эсэхэд жил бүрийн эхний улиралд багтаан дүн шинжилгээ хийхээр тусгасан нь Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан цаг үеэ олсон байх зарчимд нийцэж байх бөгөөд нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас албаны нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон тохиолдолд уг мэдээллийг ил болгох нөхцөлийг бүрдүүлжээ.

Олон улсын жишгийг авч үзвэл,⁸⁴ иргэдээс мэдээллийг нууцлахдаа баримтлах жишиг зарчмыг хоёр жил гаруй хугацаанд улс орнуудын засгийн газрын төлөөлөл, аюулгүй хамгааллын салбар болон иргэний нийгмийн байгууллагууд (70 гаруй орны 500 гаруй шинжээч) зөвлөлдсөний үндсэн дээр нууцлалд тавих зохист хязгаар, мэдээлэгчийн үүрэг болон бусад асуудлаар нарийвчилсан журмыг баталсан нь “Үндэсний аюулгүй байдал ба мэдээлэл авах эрхийн тухай Тшванийн зарчим”⁸⁵ юм. Уг зарчмаар үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй аюулаас ард түмнийг хамгаалах хууль зүйн хүчин чармайлтад халдахгүйгээр засгийн газрын мэдээллийг олон нийтэд хэрхэн хүртээмжтэй байлгах вэ гэдэг асуудлыг хөнддөг.⁸⁶ Эдгээр зарчимд дараахь гол агуулгыг тусгасан. Үүнд:

⁸³ Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалт (Олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага) сэдэвт ХЗҮХ-ийн 2023 оны судалгааны тайланд дурдсанаар “Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнуудын Төрийн нууцын тухай загвар хуульд нууцалж болохгүй мэдээллүүдийн талаар тусгажээ. Үүнд:

- 1) Иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд заналхийлж буй онцгой нөхцөл байдал, аюул осол, тэдгээрийн үр дагавар болон байгалийн гамшиг, тэдгээрийн албан ёсны урьдчилсан мэдээ, үр дагавар;
- 2) Экологи, эрүүл мэнд, эрүүл ахуй, хүн ам зүй, боловсрол, соёл, хөдөө аж ахуй, гэмт хэргийн нөхцөл байдал;
- 3) Төрөөс иргэн, албан тушаалтан, байгууллагад олгосон дэмжлэг, нөхөн олговор, хөнгөлөлт;
- 4) Иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн баримт;
- 5) Үндэсний банкны алт, гадаад валютын хэмжээ, үнэт металл, үнэт чулууны засгийн газрын (төсвийн) нөөц;
- 6) Төрийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны хууль зөрчсөн талаарх мэдээлэл;
- 7) Төрийн нууцад хамаарах гадаад бодлого, гадаад эдийн засгийн хүрээнд заасан мэдээллээс бусад архивт хадгалагдаж байгаа болон улс төр, нийгмийн болон бусад шалтгаанаар олон нийтийг хэлмэгдүүлсэн талаарх мэдээлэл зэрэг оржээ.”

⁸⁴ ХЗҮХ, “Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалт (Олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага) сэдэвт судалгааны тайлан”, УБ, 2023.

⁸⁵ The Tshwane Principles on National Security and the Right to Information.

⁸⁶ The Tshwane Principles on National Security and the Right to Information: An Overview in 15 Points, <https://www.justiceinitiative.org/publications/tshwane-principles-national-security-and-right-information-overview-15-points>.

- Олон нийт төрийн мэдээлэл, тэр дундаа төрийн чиг үүргийг гүйцэтгэдэг, эсвэл төсвийн хөрөнгө хүлээн авдаг хувийн хэвшлийн байгууллагын мэдээлэлд хандах эрхтэй. (1-р зарчим)
- Мэдээллийг задруулснаар “Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах бодит бөгөөд тодорхойлж болохуйц эрсдэл бий болох” тохиолдолд зөвхөн нууцлах ёстой. (3-р зарчим)
- Мэдээлэл авах эрхийг хязгаарлах зайлшгүй шаардлагатай гэдгийг Засгийн газар нотлох ёстой. (4-р зарчим)
- Засгийн газар батлан хамгааллын төлөвлөгөө, зэвсгийн хөгжүүлэлт, тагнуулын албаны үйл ажиллагаа, эх сурвалж гэх мэт нарийвчлан тодорхойлогдсон салбарын мэдээллийг хуулиар хязгаарлаж болно. Түүнчлэн, үндэсний аюулгүй байдлын асуудалтай холбоотойгоор бусад улсын засгийн газраас өгсөн нууц мэдээллийг нууцад тооцож болно. (9-р зарчим)
- Ил болгох шаардлагатай мэдээллийг зөвхөн байгууллагаас нь хамаарч нууцад үлдээж болохгүй. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлын салбар болон тагнуулын байгууллагуудыг оролцуулан төрийн ямар ч байгууллага нууцлалыг ил болгох шаардлагаас чөлөөлөгдөхгүй. (5-р зарчим)
- Аюулгүй байдлын салбарт бие даасан хяналтын байгууллагууд байх ёстой бөгөөд эдгээр байгууллага үр дүнтэй хяналт тавихад шаардлагатай бүх мэдээллийг хүлээн авах боломжтой байна. (6, 31–33-р зарчим)
- Мэдээллийг зөвхөн шаардлагатай хугацаанд нууцлалд хамааруулж ангилах ёстой бөгөөд хэзээ ч тодорхойгүй хугацаа зааж болохгүй. Ангиллын зөвшөөрөгдөх дээд хугацааг хуульчлан зохицуулах ёстой. (16-р зарчим)
- Нууцлалаас гаргах хүсэлт тавих тодорхой журамтай байх ёстой. Нийтийн ашиг сонирхолд нийцсэн мэдээллийг нууцын зэрэглэлээс тэргүүн ээлжинд гаргана. (17-р зарчим)

Эндээс үзвэл хуулийн төсөлд тусгагдсан дээр дурдсан зохицуулалтууд нь олон улсын стандартад нийцэж байна. Гэвч хуулийн төсөлд “албаны нууц” гэх ойлголтын тодорхойлолтыг шинэчлэн томъёолохдоо практикт учирч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлээгүй байна.

Хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд заасан тодорхойлолтын дагуу албаны нууц гэдэгт задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно. Уг тодорхойлолттой холбоотойгоор практикт үүсэж буй хүндрэл бэрхшээлийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 онд гүйцэтгэсэн “Төрийн болон албан нууцын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийг үнэлэх нь” сэдэвт судалгаанд дараах байдлаар тодорхойлсныг дахин авч үзвэл:

... Энд дурдагдаж буй “Байгууллагын ашиг сонирхол” болон “салбарын ашиг сонирхол” зэрэг нэр томъёо, ойлголтын тодорхойгүй байдлаас үүдэн төрийн байгууллагын удирдлагаас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэт өргөнөөр албаны нууцад хамааруулах явдал нийтлэг байна. Учир нь “албаны нууц”-ыг тодорхойлох шалгуурыг хуульчлаагүйгээс төрийн байгууллага, агентлагийн дарга нар албаны нууц хэмээх ангилалд хэт өргөн хүрээний мэдээллийг хамруулж, иргэний мэдэх эрхийг зөрчих явдал их байна...⁸⁷

⁸⁷ “Төрийн болон албан нууцын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийг үнэлэх нь” судалгаа, Хууль зүйн үндэсний хүрээлэн, УБ, 2023.

... Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7.5-д “Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй” талаар тусгасан. Эндээс үзвэл, “албаны нууц” гэж төрийн нууцад хамаарах мэдээлэл болон нээлттэй байх мэдээллээс бусад мэдээллийг ойлгохоор байна. Өөрөөр хэлбэл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд “албаны нууц” ба “төрийн нууц” нь хоорондоо ялгамжтай байдлаар зохицуулагдсан. Гэвч энэхүү зохицуулалт нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16.2-т “Төрийн нууцад хамаарах мэдээлэл “онц чухал нууц”, “маш нууц”, албаны нууцад хамаарах мэдээлэл “нууц” зэрэглэлтэй байна” гэж заасантай нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, одоо байгаа хуульд дээрх 2 ойлголтыг тусад нь томъёолсон ч албаны нууц нь төрийн “нууц” зэрэглэлд хамаарахаар зөрчилтэй зохицуулжээ...


...Албан мэдээллийг тухайн байгууллагын дарга жагсаалтаар тодорхойлдог улс байхад нэг бүрчлэн тогтоодоггүй улс ч байна. Аль ч тохиолдолд нууцад хамааруулж үздэггүй. Гэхдээ албан мэдээлэлтэй танилцах эрхийг хязгаарлах тохиолдлууд байна. Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг бууруулахгүй байх, иргэн, хуулийн этгээдийн нууц мэдээллийг задруулж тэдгээрт хохирол учруулахаас сэргийлэх зорилгоор албан мэдээлэлтэй танилцах иргэний эрхийг хязгаарлах бололцоог үгүйсгээгүй. Ийнхүү хязгаарлах тохиолдлуудыг хуульд тухайлан заасан байгаагаас гадна хязгаарласан мэдээллийг “нууц” гэж томъёолоогүй байна...

Эндээс үзвэл, нэгдүгээрт, албаны нууцыг төрийн нууцаас салгаж зохицуулах, өөрөөр хэлбэл төрийн нууцын “нууц” зэрэглэлд хамааруулсныг засах, хоёрдугаарт, салбарын ашиг сонирхол, байгууллагын ашиг сонирхол зэрэг хэт ерөнхий ойлгомжгүй нэр томъёоноос зайлсхийх, гуравдугаарт, албаны нууц гэж бус албан мэдээлэл гэх ойлголтыг төлөвшүүлэх, албаны мэдээлэл гэдэгт хязгаарлалттай мэдээллийг ойлгох, албан мэдээлэлтэй танилцах эрхийг хязгаарлах тохиолдлыг оновчтой зохицуулах шаардлага байгаа юм.

Хуулийн төслөөр албаны нууц гэх ойлголтыг шинэчилж, “тухайн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул занал, хохирол учруулах, эсхүл салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг” ойлгохоор тусгажээ. Өөрөөр хэлбэл, албаны нууц гэх ойлголтыг тайлбарлахдаа “салбарын болон төрийн байгууллагын ашиг сонирхол” гэх хэт ерөнхий нэршлийг дахин ашигласнаас гадна “төрийн нууц”-ын нэг үндсэн шинж болох “үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул занал, хохирол учруулах” шалгуурыг “албаны нууц”-ын нэг шинж болгожээ.

Бусад улсын туршлагыг авч үзвэл,⁸⁸ Сингапур , Молдав , Их Британи , Малайз , Эстони, Герман, Япон, Солонгос зэрэг улсын төрийн нууцын хууль тогтоомжид “албаны нууц” гэх ойлголт тусгагдаагүй боловч Эстони, Герман, Солонгос, Швед улсын мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжид “албаны мэдээлэл” гэх ойлголт тусгагдсан. Харин Харин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудад “албаны нууц” (служебная тайна) гэсэн ойлголт төрийн нууцаас тусдаа ангилал болж хуульчлагдсан

⁸⁸ ХЗҮХ, “Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалт (Олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага) сэдэвт судалгааны тайлан”, УБ, 2023.



байдаг. Жишээлбэл, Литва улсын Төрийн болон албаны нууцын тухай хуульд “Албаны нууц гэж энэ хуульд заасан журмын дагуу нууцлагдсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд **төр, түүний институцийн ашиг сонирхолд хохирол учруулах**, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг задруулах болон хүний эрүүл мэндэд аюул учруулах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж болзошгүй улс төр, цэрэг, тагнуул, эдийн засаг, хууль сахиулах, боловсрол, шинжлэх ухаан, техникийн болон бусад мэдээллийг хэлнэ.”⁸⁹ гэж хуульчилжээ. Мөн Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнуудын Төрийн нууцын тухай загвар хуульд улсын нууцыг төрийн болон албаны нууц гэж ангилсан бөгөөд “албаны нууц” (служебная тайна) гэсэн ойлголтод албан хэрэгцээгээр хязгаарлагдсан, задруулж, үрэгдүүлснээр **төрийн байгууллага болон төрд хохирол учруулж болзошгүй** төрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээний мэдээллийг хамааруулж байна. Дүгнэвэл, албаны нууц гэх ойлголт нь ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудад ихэвчлэн хадгалагдан үлдсэн байх бөгөөд судалгаанд хамруулсан дээрх пост социалист орнуудын хувьд “албаны нууц” хэмээх ойлголтод хамаарах хохирлын шалгуур нь үндэсний ашиг сонирхол төрийн ашиг сонирхол байгаа нийтлэг тал ажиглагдлаа.

Гэвч мэдээллийн ил тод байдлын хувьд өндөр үнэлгээ бүхий Швед, Эстони, ХБНГУ зэрэг улсуудад албаны нууц, төрийн болон төрийн байгууллагын ашиг сонирхол зэрэг нэр томъёоноос татгалзаж, нийтэд ил тод байх мэдээлэл, төрийн нууцад хамаарах мэдээлэл болон хязгаарлалттай мэдээлэл зэргийг өөрөөр тодорхойлжээ. Монгол Улсын хувьд хэдийгээр пост социалист улс боловч Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай бие даасан хуулийг баталж, мэдээллийн эрх чөлөөг хангах чиглэлд томоохон дэвшилттэй алхам хийсэн тул дээрх пост социалист орнуудын жишгийг дагах нь тохиромжтой биш байна. Иймд “албаны нууц” гэдэгт хуульд заасан тодорхой шалгуурыг хангасан тул тухайн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад хамааруулсан, Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуульд заасан хязгаарлалттай мэдээллийн⁹⁰ **нэг төрлийг**⁹¹ ойлгохоор тусгахыг зөвлөж байна.

Дээрхээс үзвэл хуулийн төслөөр төрийн нууц, албаны нууц гэх ойлголтыг ялгахад тулгамдаж буй хүндрэлтэй байдлыг шийдвэрлээгүй байх тул албаны нууц гэх ойлголтын тодорхойлолтыг дахин сайжруулах нь зүйтэй байна. Ингэхдээ “албаны нууц” гэдэгт хуульд заасан тодорхой шалгуурыг хангасан тул тухайн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад хамааруулсан, Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуульд заасан хязгаарлалттай мэдээллийн нэг төрлийг ойлгохоор тусгахыг зөвлөж байна.

⁸⁹ Law on State Secrets and Official Secrets, Art 3, <https://e-seimas.lrs.lt/portal/legalAct/lt/TAD/TAIS.461671>

⁹⁰ Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хууль 7.3.Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж үзнэ.

⁹¹ Хязгаарлалттай мэдээлэлд албаны нууцаас гадна хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг ойлгоно.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Аргачлалын 4.10 дахь хэсэгт “Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгах хэрэгслийн хүрээнд дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтооно” гэж заасны дагуу дараах агуулгын хүрээнд харилцан уялдааг үнэлэв.

1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Нийцэж буй талаар өмнөх хэсэгт дурдсан.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуулийн төслөөр энэ хэсэгт өөрчлөлт оруулаагүй.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Албаны нууц гэх нэр томъёо нь тус хууль дахь төрийн нууц гэх нэр томъёоноос төдийлөн ялгарахгүй байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хязгаарлалттай мэдээлэл болон Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан албан нууц гэх ойлголтууд хоорондоо төдийлөн уялдахгүй байгааг анхаарах нь зүйтэй. Цаашлаад хуулийн төслийн 14.5 дахь хэсэгт “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна” гэж заасан байх боловч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Албаны нууцад хамаарах мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан үндэслэл, журамд заасны дагуу ашиглана.” Гэж заасан байгаа юм. Өөрөөр хэлбэл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл албаны нууцад хамаарах мэдээллийн хүрээнд хэрэглэгдэх эсэх нь тодорхойгүй бөгөөд зөрчилдөөн үүсжээ. Хуулийн төслийн 5.1.2-т албаны нууцыг “тухайн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул занал, хохирол учруулах, эсхүл салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг” ойлгохоор заасан ч мөн төслийн 14.1.1 дэх зүйлд Албаны нууцад дараах шаардлагыг хангасан мэдээллийг хамааруулна гээд “тухайн мэдээлэл нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүний эрх, эрх чөлөө, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах хууль ёсны ашиг сонирхолд

		<p>нийсэн байх” гэжээ. Эндээс үзвэл салбарын болон төрийн байгууллагын ашиг сонирхлын үүднээс мэдээллийг нууцалж болох эсэх нь тодорхойгүй буюу хоорондоо зөрчилдсөн шинжтэй байна.</p> <p>Дээрх зөрчлийг арилгахын тулд нэгдүгээрт албаны нууцыг тагнуулын байгууллагын саналд үндэслэн засгийн газрын гишүүн эсхүл төрийн байгууллагын даргын тушаалаар хамгаалалтад авсан, төрийн нууц болон нээлттэй байх мэдээлэлд хамаарахгүй нэг төрлийн хязгаарлалттай мэдээллийг ойлгохоор томъёолж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9.1. дэх хэсгийг хасах нь зүйтэй гэж үзэж байна.</p>
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардал байхгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Төсөлд хязгаарлалттай мэдээллийг өгөхөөс татгалзсан бол татгалзсан үндэслэлээ тухайн байгууллага тайлбарлах үүрэгтэй байхаар тусгасан нь энэ талаарх чиг үүргийг тодорхой болгожээ.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Төрийн байгууллага, албан хаагч нь иргэний мэдээлэл авах хүсэлтэд татгалзсан хариу өгөх тохиолдолд тухайн мэдээллийг нууцалсан үндэслэлээ тайлбарлах үүргийг зохицуулсан ч шийдвэрийг бичгээр эсхүл цахимаар гаргах, уг татгалзсан шийдвэрт гомдол гаргах боломж бүрдүүлэх нь иргэдийн төрийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Давхардал байхгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Боломжгүй.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт байхгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Албаны нууцын тодорхойлолтыг хэт өргөн хүрээнд тодорхойлсон нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16.17 дахь хэсэгт “Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасантай зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд тусгасан

		зарчмын дагуу салбарын эсхүл төрийн байгууллагын эрх ашгийг хамгаалах зорилгоор аливаа мэдээллийг нууцалж болохгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Жендэрийн эрх тэгш байдлыг зөрчсөн зохицуулалт байхгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт байхгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Төсөлд хязгаарлалттай мэдээллийг өгөхөөс татгалзсан бол татгалзсан үндэслэлээ тухайн байгууллага тайлбарлах үүрэгтэй байхаар тусгасан нь энэ талаарх чиг үүргийг тодорхой болгосон ч энэхүү үүргээ зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг зохицуулаагүй.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:


Харилцаа холбооны зохицуулах хороо нь өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй байгууллага юм.

Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт “Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилно” гэж заасан. Тус зүйлийг хуулийн төслөөр “Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилох бөгөөд гишүүнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус бүр 2, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, иргэний нийгмийн төлөөллөөс тус бүр 1 нэр дэвшигчийг санал болгоно” гэж өөрчлөхөөр байгаа юм.

Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6. дахь хэсэгт “Харилцаа холбооны салбарт мэргэжлээрээ 10-аас доошгүй жил, түүнээс 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан, дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг Зохицуулах хорооны даргаар, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг Зохицуулах хорооны гишүүнээр томилно:

8.6.1.эдийн засаг, мэдээлэл холбоо, техник, хууль зүй, удирдлагын дээд боловсролтой, өндөр мэргэжил, ажлын туршлагатай, удирдан зохион байгуулах чадвартай;

8.6.2.Зохицуулах хорооны дарга, гишүүн нь үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй” гэж заасан.



Харин төслөөр Зохицуулах хорооны дарга, гишүүнд тавигдах шаардлагыг тусад нь томъёолж харилцан ялгаатай шаардлага тавихаар зохицуулсан. Тухайлбал харилцаа холбоо, мэдээллийн технологи, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тус салбарт 8-аас доошгүй жил ажилласан иргэнийг гишүүнээр, мөн дээрх чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, салбартаа 12-оос доошгүй ажил, үүнээс 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан иргэнийг тус хорооны даргад нэр дэвшүүлэхээр тусгажээ.

Харин Зохицуулах хорооны дарга, гишүүн нь үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй гэх шаардлагыг хэвээр үлдээсэн байна.

Хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар Зохицуулах хороо харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- харилцаа холбооны талаар төрөөс баримталж буй бодлогын талаар санал боловсруулах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;
- хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;
- харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, холбогдох техникийн нөхцөл, шаардлага, норматив баримт бичиг, журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг батлах, зах зээлд зүй ёсны монополь болон давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах, батлах;
- харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг хангуулах;
- харилцаа холбооны стандарт боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;
- радио, телевизийн болон тэдгээрийг дамжуулах үйлчилгээний нөхцөл, шаардлагыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- хуулийн 6.1.4-д заасан журмын дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлсний хувь хэмжээг тогтоох;
- тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх;
- дугаартайгаа шилжих үйлчилгээг нэвтрүүлэх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, уг үйлчилгээтэй холбоотой зохицуулалтын журам батлах;
- домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам батлах;
- Зохицуулах хорооны төсөв, ажлын албаны жилийн төлөвлөгөөг батлах.

Дээрх чиг үүргийг дараах бүтэц бүрэлдэхүүнтэйгээр хэрэгжүүлж байна.⁹²




Эндээс дүгнэвэл, Харилцаа холбооны зохицуулах хороо нь мэдээлэл, харилцаа холбооны салбарт төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хүрээнд шинэ дэвшилтэт техник, технологийг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт нэвтрүүлэх, эрх зүй, эдийн засгийн оновчтой зохицуулалтаар хангаж иргэдэд төрийн болон мэдээлэл харилцаа холбооны төрөл бүрийн хэрэглээ, үйлчилгээг чанарын өндөр түвшинд хүргэх, тэдгээрийн хүртээмжийг сайжруулах, шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх мэргэжлийн хараат бус байгууллага байх ёстой.

Тухайлбал, хуулийн 9 дүгээр зүйлд заасан чиг үүргүүд нь харьцангуй нарийн мэргэжлийн шинжтэй байх тул харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарт ажилласан туршлага этгээдийг тус хорооны дарга, гишүүнээр сонгох шийдэл нь зүйтэй байна. Иймд хуулийн төсөл дэх харилцаа холбоо, мэдээллийн технологи, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тус салбарт 8-аас доошгүй жил ажилласан иргэнийг гишүүнээр, мөн дээрх чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, салбартаа 12-оос доошгүй ажил, үүнээс 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан иргэнийг тус хорооны даргад нэр дэвшүүлэх зохицуулалт нь зорилгодоо нийцэж байна.

Харин хараат бус байдлын хүрээнд авч үзвэл, гагцхүү Зохицуулах хорооны дарга, гишүүн нь үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй гэх шаардлага тавигдаж байна. Өөрөөр хэлбэл, салбарт үйлчилгээ үзүүлж буй аж ахуй нэгжээс хараат бус байлгах зохицуулалт тусгагдсан байна. Дээр дурдсанаар өөрөөр Зохицуулах хорооны дарга, гишүүнд тавигдах хараат бус байх шаардлага нарийн тодорхойлогдоогүй.

⁹² Харилцаа холбооны зохицуулах хорооны албан ёсны вэб сайт, <https://crc.gov.mn/about-us/show/organizational-structure/mn>



Тус хорооны дарга, гишүүд нь нам, эсвэл, улс төрийн нөлөө бүхий этгээдээс хараат бус байх хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодруулбал:

Зохицуулах хороо нь хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна тусгайлан баталсан журмын дагуу зарим бүрэн эрхийг эдэлж байна. Тухайлбал,

- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос 2020 онд Монгол улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 47.9-т “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмыг цагдаагийн төв байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн Сонгуулийн Ерөнхий хороо хамтран баталж, мөрдүүлнэ” гэж заасныг үндэслэн батлагдсан 2020 оны “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа, явуулах түүнд хяналт тавих журам”-ыг 2024 оны 3 сарын 06-ны өдөр шинэчлэн баталсан байна.⁹³
- Түүнчлэн Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.13 дахь хэсэгт заасныг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нарын 2020 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн А/200, А/169 дүгээр хамтарсан тушаалаар “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам”-г баталсан бөгөөд одоогоор хүчин төгөлдөр байна.⁹⁴

“Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа, явуулах түүнд хяналт тавих журам”-д зааснаар цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт гаргана. Дурдсан эрх бүхий байгууллага нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан үзээд журамд заасан шаардлага хангасан шийдвэрийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлнэ. Харилцаа холбооны зохицуулах хороо нь дээрх шийдвэр бүхий албан бичгийн дагуу дараах арга хэмжээг авах талаар цахим орчны үйлчилгээ эрхлэгчид нэн даруй мэдэгдэнэ:


- 1.Шийдвэрт дурдсан контентыг устгах, эсхүл хандалтыг хаах, эсхүл түр хязгаарлах;
- 2.Шийдвэрт дурдсан цахим хаяг, цахим хуудасны хандалтыг сонгуулийн сурталчилгааны хугацаа дуустал хугацаанд хаах, эсхүл түр хязгаарлах.

Цахим орчны үйлчилгээ эрхлэгчийг олж тогтоох боломжгүй эсхүл дээр заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол Харилцаа холбооны зохицуулах хороо дараах мэдэгдлийг цахим орчны үйлчилгээ эрхлэгч, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчид хүргүүлнэ:

⁹³2020 оны “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа, явуулах түүнд хяналт тавих журам” <https://legalinfo.mn/mn/detail/15297>,

2024 оны “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа, явуулах түүнд хяналт тавих журам”, <https://www.crc.gov.mn/pages/show/cahim-orchin-ashiglan-songuulijn-surtalchilгаа-yavuulah-t-nd-hyanalt-taviih-zhурам>

⁹⁴“Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам”, <https://legalinfo.mn/mn/detail/15610>

- 
1. тухайн цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг сонгуулийн сурталчилгааны дүн гарч дуусах хүртэлх хугацаанд, эсхүл зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд түр хязгаарлах;
 2. шийдвэрт дурдсан хууль зөрчсөн контентыг устгах, эсхүл хандалтыг хаах, эсхүл түр хязгаарлах;
 3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан технологийн арга хэмжээ авах (цахим орчин дахь олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах).⁹⁵

Эндээс үзвэл Зохицуулах хороо хууль зөрчсөн эсэх шийдвэр гаргахгүй ч ямар арга хэмжээ авахыг тодорхойлох бүрэн эрхтэй байна. Дээр дурдсан арга хэмжээнүүдийг ямар тохиолдолд хэрэглэх болон зөрчлийн онцлог, шинжээс хамааран дангаар нь эсхүл хамтад нь хэрэглэх эсэх талаар зохицуулалгүй үлдээсэн. Уг тодорхой байдлын улмаас эрх бүхий байгууллагууд нь хүний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх өргөнөөр хязгаарлагдах эрсдэлийг үүсгэдэг талаар судлаачид дурдаж байна.⁹⁶

Цаашлаад, Монгол Улсад “илт худал мэдээлэл”, “худал мэдээлэл тараах” гэх хууль зүйн ойлголт нэг мөр болоогүй байгаа нь эрх бүхий этгээдээс хуулийн заалтыг дур зоргоороо тайлбарлах, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах эрсдэл үүсгэж байгаа талаар мэргэжлийн байгууллагууд шүүмжлэлтэй хандаж байна.⁹⁷

Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзвэл, цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалахад Зохицуулах хороо чухал үүрэг гүйцэтгэхээр байх тул Зохицуулах хорооны дарга, гишүүд нь салбарт үйлчилгээ үзүүлж буй аж ахуй нэгжээс гадна аливаа нам, эсвэл, улс төрийн нөлөө бүхий этгээдээс хараат бус ажилладаг байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлага байсаар байна.

Тухайлбал нам, эвслийн гишүүнчлэлгүй байх, улс төрийн нөлөө бүхий этгээдтэй харилцан хамааралтай биш байх зэрэг шаардлагуудыг тавих нь тохиромжтой байна. Цаашлаад ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх ерөнхий зохицуулалт үгүйлэгдэж байна. Тухайлбал, өөрийн болон өөрт хамааралтай этгээдийн ашиг сонирхолд холбогдох аливаа асуудалд саналын эрхтэй оролцохгүй байх зэрэг шаардлагыг тавих, тус шаардлагыг зөрчвөл тус хорооны дарга, гишүүдэд хариуцлага тооцох үндэслэл болохоор зохицуулах нь хорооны дарга, гишүүдийн гадны нөлөөллөөс ангид, хараат бус ажиллах боломжийг хангахад чухал нөлөө үзүүлнэ.

Иймд дээрх нэмэлт хөшүүргүүдийг оновчтой тодорхойлох нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хараат бус байдлыг хангах” зорилгод нийцнэ.

⁹⁵ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, 47.11.Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл авч болно.

⁹⁶ Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2022.

⁹⁷ Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик: Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал (УБ,2021).

https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Misinformation%20Crime_Web%20version.pdf

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Өнгөрсөн онд буюу 2023 онд Цахим хөгжил, харилцааны холбооны яамны захиалгаар Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн байна.⁹⁸ Тус судалгааны тайланд дурдсанаар олон улсын харилцаа холбооны салбарын чиг хандлагаар зохицуулах байгууллага нь бие даасан, хараат бусаар үйл ажиллагаа явуулж чадаж байгаа эсэхээр нь тухайн орны зах зээлийг либералчлагдсан гэж үздэг байна. Цаашлаад, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилж буй нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4, 19 дэх хэсгүүдтэй зөрчилдөөгүй буюу Ерөнхий сайдын эрх хэмжээнд шууд хамаарна гэж дүгнэсэн. Гэвч тус дүгнэлт нь учир дутагдалтай бөгөөд улс орны сайн жишгийг үзвэл Харилцаа холбооны зохицуулах хорооны хараат бус байдлыг хангах үүднээс төрийн эрх барих байгууллагуудаас тодорхой квоттойгоор гишүүнд нэр дэвшүүлдэг байна.

Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт “Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилох” гэж заасныг хуулийн төслөөр “Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилох бөгөөд гишүүнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус бүр 2, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, иргэний нийгмийн төлөөллөөс тус бүр 1 нэр дэвшигчийг санал болгоно” гэж өөрчлөхөөр байгаа юм. Хэдийгээр иргэний нийгмийн төлөөлөл заавал тус хорооны гишүүнээр сонгогдон ажиллах зохицуулалтыг тусгаж буй нь дэвшилтэт боловч тус гишүүний дуу хоолой хэр хүчтэй байх нь тодорхойгүй.

Бусад улсын туршлагыг судлан үзэхэд, Солонгосын Харилцаа холбооны хороо (КСС) нь нь 5 гишүүнээс бүрдэх бөгөөд 2 гишүүнийг Ерөнхийлөгч, 3 гишүүнийг Үндэсний Ассемблейгээс нэр дэвшүүлдэг.⁹⁹ Гишүүдийг 3 жилийн хугацаатайгаар томилох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно. Гишүүд дундаасаа даргаа сонгоно.¹⁰⁰ Гишүүд гадны нөлөөллөөс ангид чиг үүргээ хэрэгжүүлэх үүрэгтэй.¹⁰¹ Гагцхүү эрүүл мэндийн шалтгаанаар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, 10 дугаар зүйлд тусгасан чөлөөлөх үндэслэл бүрдсэн¹⁰², хууль бус үйл ажиллагаанаас ашиг хонжоо олсон,

⁹⁸ MJL Attorneys, “Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан”, УБ, 2023, 28 дахь тал.

⁹⁹ Act on the establishment and operation of Korea Communications Commission.

¹⁰⁰ Мөн тэнд.

¹⁰¹ Мөн тэнд

¹⁰² 10 дугаар зүйл.

(1) Дараах тохиолдолд гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

1. Улс төрийн намын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан аль нэг улс төрийн нам, эвслийн гишүүн бол;
2. Гишүүнээр томилогдохоос өмнөх 3 жилийн хугацаанд харилцаа холбооны салбарт бизнесийн үйл ажиллагаа эрхэлж (оролцож) байсан бол;
3. Төрийн албан хаагчийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн бол;
4. Сонсох ажиллагаагаар (Impeachment) үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн бол;
5. Нийтийн албан тушаалтны сонгуулийн тухай хуулийн 2 дугаар зүйлд (Үндэсний Ассемблейн гишүүн, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүн, эсхүл түүний дарга) заасан албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш 3 жил өнгөрөөгүй;

хуулиар хүлээсэн үүргээ зөрчсөн гэх үндэслэлээр гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгоно.¹⁰³

Цаашлаад тус хорооны гишүүн нь ашиг олох үйл ажиллагаа болон улс төрийн аливаа үйл ажиллагаа эрхэлдэггүй байх шаардлагыг 9 дүгээр зүйлээр тогтоожээ.

Тус улсын Харилцаа холбооны хороог байгуулах тухай хуульд хорооны гишүүдэд томилогдож болох этгээдийн жагсаалтыг тогтоосон. Үүнд:

1. Харилцаа холбоо, сэтгүүл зүй, электроник инженерчлэл, харилцаа холбооны инженерчлэл, эрх зүй, эдийн засаг, бизнесийн удирдлага, төрийн удирдлагаар мэргэшсэн их сургуулийн профессор эсхүл түүнтэй адил төстэй чиг үүргийг хамгийн багадаа 15 жилийн хугацаанд гүйцэтгэсэн аливаа хүн;

2. 15 жилээс багагүй хугацаанд шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр ажиллаж байсан туршлагатай аливаа хүн;

3. Харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологийн салбарт ажилласан туршлагатай, 2 эсхүл түүнээс дээш түшмэлийн зэрэгт хамаарах удирдах түвшний албан хаагчийн чиг үүргийг гүйцэтгэж байсан эсхүл гүйцэтгэж буй аливаа хүн;

4. Харилцаа холбоо, сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг институт, байгууллагын ажилтан, гүйцэтгэх удирдлага, төлөөлөгчийн чиг үүргийг хамгийн багадаа 15 жилийн хугацаанд гүйцэтгэж байсан аливаа хүн;

5. Харилцаа холбоо, сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологийн салбарт 15 жилээс багагүй хугацаанд ажилласан туршлагатай аливаа хүн;

6. 1, 2, 4, 5 дахь хэсэгт заасан хүний нийт ажилласан жил нь хамгийн багадаа 15 жил байна.

Дээрх улсын жишигтэй харьцуулан үзвэл, Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хараат бус байдал төдийлөн хангагдаагүй байна. Иймд мэргэжлийн хараат бус Зохицуулах хороог бүрдүүлэхэд гишүүдэд тавигдахаас шаардлагаас гадна Ерөнхий сайдаас бусад төрийн эрх бүхий байгууллагад, тухайлбал УИХ, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг байгууллагаас Зохицуулах хорооны гишүүнд нэр дэвшүүлэх хувилбарыг хэрэгжүүлж болохоор байх бөгөөд цаашлаад гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх үндэслэлийг тухайлан зохицуулах нь хараат бус байдлыг практикт хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байна.


БНСУ-ын жишигт үндэслэвэл, Зохицуулах хорооны гишүүнд тавигдаж буй “үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй” гэх шаардлагыг чангатгаж гишүүнээр томилогдохоос өмнөх тодорхой хугацаанд энэ төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхлээгүй байх, удирдах албан тушаалтнаар ажиллаагүй байх зэргээр зохицуулах хараат бус байдлыг практикт хэрэгжүүлэхэд нөлөөтэй.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тус хуулийн төслөөр 2022 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн нийт 14 орчим зүйлд нэмэлт, өөрчлөлт

¹⁰³ Мөн тэнд.



оруулахаар байна. Энэ нь тус хуулийн төслийн танилцуулгад дурдагдсанаар дараах ач холбогдолтой байхаар байна.

1.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтантай гүйцэтгэх удирдлагын түвшний ажил үүрэг гүйцэтгүүлэхээр тохирч байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн хугацаатай гэрээний төрөлд хамруулж, хугацааг 5 жил хүртэл байхаар тусгалаа.

2.Аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг 1-10 жил хүртэл хугацаагаар харилцан адилгүй хэрэгжүүлдэг. Үүнтэй холбоотойгоор санхүүжилт, хийгдэх ажлын цар хүрээтэй холбоотой цаг хугацаагаар хязгаарлагдсан ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны хөдөлмөрийн гэрээний хугацааны үргэлжлэл 2 жилээр хязгаарлахгүй байхаар хуулийн 50.4-т өөрчлөлт оруулахаар боловсрууллаа.

3.Ажил олгогчоос хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон тухай гаргасан шийдвэрийг ажилтан хүлээн авахаас татгалзсан бол шийдвэрийг ажилтанд (утасны дугаар, цахим шуудангийн хаяг, оршин суугаа хаягт шуудангаар хүргүүлснээр) мэдэгдсэнээр ажилтан тухайн шийдвэртэй танилцсанд тооцно.

4.Цалин хөлсийг тооцох аргачлалыг боловсронгуй болгож, илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс, шагнал урамшууллыг оруулахгүй. Ингэснээр илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны цалин хөлсийг бодох аргачлал тодорхой болно.

5.Аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцөөс “албан тушаал бууруулах” гэсэн хөдөлмөрийн сахилгын шийтгэл нь аж ахуйн нэгж, байгууллагад хэрэглэхэд хүний нөөцийн хувьд ажилтнуудыг шилжүүлэх, ажлын байрны хувьд шинэ ажлын байр нэмэх зэрэг хүндрэл учруулж байгаа талаар санал ирүүлсэн. Үүнтэй холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т заасан “албан тушаал бууруулах” гэсэн хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг хасахаар төсөл боловсрууллаа.

6.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаас удаа дараа гаргаж байгаа санал, хүсэлтийн дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.4 дэх хэсэгт өөрчлөлт оруулах санал боловсрууллаа. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүн гэснийг өөрчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүний байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагын, нийт ажилтны дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр худалдан авч байгаа ажил олгогчийг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй төлбөрөөс зохих журмын дагуу хөнгөлж, эсхүл чөлөөлнө.

7.Ажилтан хөдөлмөрийн маргаан таслах комиссоор шийдвэрлэсэн хөдөлмөрийн эрхийн маргааныг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шууд шүүхэд хандаж шийдвэрлүүлэх боломжтой байхаар заасан.

8.Ажилтны шүүхэд хандах эрхийн хангах зорилгоор хуулийн 157.2-т Хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлэх байгууллагад хандан хуульд заасан хугацаанд багтаж гомдол гаргасан тохиолдолд шүүхэд гомдол гаргах хугацаа зогсоно.

9.Төрийн албаны тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль зэрэг хуулиудаар ажил хаялт санаачлах, зохион байгуулах, түүнд оролцохыг хориглосон байгууллагын ажилтныг тодорхойлсон учир Хөдөлмөрийн тухай хуулийн 28 дугаар

зүйлийн 28.1 дэх хэсгийн “Нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг Үндэсний хорооны саналыг харгалзаж Засгийн газар батална.” гэснийг хүчингүй болсонд тооцохоор хуулийн төсөлд тусгасан¹⁰⁴.

Тус хуулийн төслийн танилцуулгын 4, 5 дахь хэсэгт тусгагдсан зохицуулалтыг хуулийн төсөлд оруулж зохицуулаагүй байна. Тодруулбал, Цалин хөлсийг тооцох аргачлалыг боловсронгуй болгож, илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс, шагнал урамшууллыг оруулахгүй байх зохицуулалт болон “албан тушаал бууруулах” хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг хасах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаагүй байна. Иймд хуулийн төсөлд тухайн зохицуулалтуудыг тусгах нь хуулийн төслийн зорилгод нийцэхээр байна.

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаас хуулиар тусгайлан эрх олгосон заалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг даалгасны дагуу хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, харилцаа оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжтэй зохицуулалт агуулсан, журмаар зохицуулсан харилцааг тухайн хуульд тусган боловсруулах шаардлага бий болсон. Тус ажлын хүрээнд холбогдох журмаар зохицуулсан харилцааг Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулиар зохицуулахын тулд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар тусгажээ.

Хуулийн төсөл батлагдах тохиолдолд дараах өөрчлөлт гарахаар байх бөгөөд өөрчлөлт бүрийн хэрэгцээ, шаардлагыг хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад тусгаагүй байна. Үүнд.

1. **Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн төлбөрийн чадваргүй бол хүүхдийн тэтгэмж гаргуулах болон үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрхтэй холбоотой захиргааны маргааны хүрээнд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй авах боломжтой байсныг¹⁰⁵ **Хөдөлмөрийн чадвараа 70 бас түүнээс дээш хувиар алдсан хүн** гэж өөрчлөхөөр зохицуулжээ. Хүчин төгөлдөр мөрдөж буй бусад хууль тогтоомжийн дагуу “Хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдсан бол бүрэн алдсан” гэж үздэг тул агуулгын өөрчлөлт гараагүй байна.**
2. Гадаадын иргэн, харъяалалгүй иргэн хуульд заасан 6 тохиолдлоос гагцхүү 2 тохиолдолд хууль зүйн туслалцаа авах боломжтой байсныг **5 тохиолдолд¹⁰⁶ туслалцаа авах боломжтой болгож** өөрчлөхөөр

¹⁰⁴ Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга.

¹⁰⁵ 6.4.Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх энэ хуулийн 6.1.4, 6.1.5-д заасан хэрэг, маргаанд хууль зүйн туслалцаа авч болно.

6.1.4.хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй бол;

6.1.5.үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн захиргааны хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй бол;

¹⁰⁶ 6.1.1.Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэг /Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг/, Арван дөрөвдүгээр бүлгийн 14.1 дүгээр зүйл /Ялгаварлан гадуурхах/, Арван зургадугаар бүлэг /Хүүхдийн эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл

зохицуулсан. Гэвч энэ нь гагцхүү “тухайн улстай байгуулсан олон улсын гэрээнд заасан” тохиолдолд хэрэгжинэ. Харьяалалгүй хүний эрх зүйн байдал хэрхэн дээшилсэн эсэх нь тодорхойгүй. Иймд 6.6 дахь хэсгийг “Монгол Улсын олон улсын гэрээ эсхүл тухайн улстай байгуулсан олон улсын гэрээнд заасан бол” гэж өргөжүүлэх нь зорилготой нийцнэ.

3. Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад **хуульд зааснаас бусад мэдээ, мэдээлэл шаардахыг хориглохоор тусгасан нь хуулийн 8.1.6.дахь хэсэгт “хууль тогтоомж болон хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын дүрэмд заасан бусад”** гэж заасантай зөрчилдөж байна. Цаашлаад хуулийн 8 дугаар зүйлд гагцхүү өмгөөллийн үйлчилгээ авахад бүрдүүлэх баримт бичгийг тусгасан. Өөрөөр хэлбэл бус ад төрлийн хууль зүйн үйлчилгээг авахдаа ямар бичиг баримт бүрдүүлэх нь хуулиар зохицуулагдаагүй зэрэг асуудлыг анхаарах нь зүйтэй.
4. Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй бол хүсэлт гаргах боломжтой байсныг өөрчилж, тус 2 төрлийн гэмт хэргийн хохирогчид **төлбөрийн чадвартай эсэхийг харгалзахгүйгээр** туслалцаа үзүүлэхээр өөрчлөх нь Хүн худалдаалах гэмт хэрэг болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг хамгаалах зорилгодоо нийцнэ.
5. 7.8. дахь хэсэгт “Үйлчлүүлэгч төлбөрийн чадвартай болох нь нотлогдвол улсын өмгөөлөгч хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэрийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргаж, хувийг үйлчлүүлэгчид өгнө” гэснийг “Үйлчлүүлэгч **хуульд заасан шаардлага хангаагүй нь** нотлогдвол улсын өмгөөлөгч хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэрийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргаж, хувийг үйлчлүүлэгчид өгнө” гэж өөрчлөхөөр тусгасан нь төлбөрийн чадвараас гадна өөр бусад нөхцөл байдлыг тодорхойлж эсхүл нотолж чадаагүй тохиолдолд татгалзах үндэслэл болсон байна. Энэ нь хууль хэрэглээний хувьд тохиромжтой.
6. Дараах заалтуудыг хасах.
 - a. 5.3.Энэ хуулийн 5.1.3-т заасан хууль зүйн туслалцааг хуульд харшлахгүй арга, хэлбэрээр явуулах бөгөөд хууль зүйн туслалцаа үзүүлэх **журмыг** хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
 - b. 6.3.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хүсэлтийн дагуу хууль зүйн туслалцаа үзүүлж болно.
 - c. 6.5.Энэ хуулийн 6.4-т заасан хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэх **журмыг** хууль зүй, санхүү, төсвийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан;

6.1.2.Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хохирогч нь 18 насанд хүрээгүй бол түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан;

6.1.3.төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан;

6.1.4.хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй бол;

6.1.6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд.

- 
- d. 6.6.Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнд энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3-т заасан хүрээнд хууль зүйн туслалцаа үзүүлж болно.
 - e. 6.7.Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх **журмыг** хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
 - f. 7.9.Энэ хуулийн 7.8-д заасан хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан шийдвэр гаргахтай холбогдох харилцааг хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын **дүрмээр** зохицуулна.
 - g. 19.2.Энэ хуулийн 19.1.5-д заасан зардлыг төр хариуцна. /19.1.5.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасан гишүүний татвар, өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын хураамж, хуульчийн үргэлжилсэн сургалтын төлбөрөөс улсын өмгөөлөгчөөр ажиллах хугацаанд чөлөөлөгдөх./
 - h. 14.1.6.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын дүрэм, улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах **журам** болон хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад **дүрэм, журмыг** батлах;

Дээр дурдсан эрх олгосон заалтуудыг хасахаар хуулийн төсөлд тусгасан хэдий ч журмаар зохицуулж байсан харилцааг цаашид хэрхэх эсэх нь тодорхойгүй байна. Эрх олгосны дагуу олон тооны журмаар хүний эрх, эрх чөлөөнд халдаж байгааг бууруулах үүднээс тус журмууд дахь хүний эрхийг хөндөж буй зохицуулалтыг хуулиар зохицуулах чиглэлийг Засгийн газраас өгсөн. Гагцхүү хүчин төгөлдөр үйлчилж буй журмыг хүчингүй болгох нь холбогдох харилцааг зохицуулалтгүй үлдээх сөрөг үр дагавартай байна. Иймд холбогдох журам дахь хүний эрх, эрх чөлөө, процессын эрхийг хөндсөн зохицуулалтыг журмаас хасаж, түүний оронд хуулиар зохицуулж, иргэний эрхийн баталгааг хангах ёстой.

Гэтэл Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд дээрх хийдлийг нөхөх зохицуулалтыг тусгаагүй байгаа нь нэмэлт, өөрчлөлтийн зорилгод нийцэхгүй байна.

Цаашлаад эрх олгосон зохицуулалтыг хассанаараа эрх бүхий төрийн байгууллагаас энэ төрлийн харилцааг зохицуулахаар батлах дүрэм, заавар зэргийг эрх зүйн үндэслэлгүй болгож байгааг анхаарах нь зүйтэй. Иймд юун түрүүнд холбогдох журамд дүн шинжилгээ хийж, уг журам дахь хүний эрхийг хөндсөн зохицуулалтыг түүж, гагцхүү тус зохицуулалтыг хуульд нэмэх, журмын бусад зохицуулалтыг хэвээр үлдээх эсэх дээр дахин дүн шинжилгээ хийх зэргээр системтэй ажиллахыг зөвлөж байна.

Хуулиар эрх олгосны дагуу олон тооны журмаар хүний эрх, эрх чөлөөнд халдаж байгааг бууруулах үүднээс холбогдох журмууд дахь хүний эрхийг хөндөж буй зохицуулалтыг хуулиар зохицуулах чиглэлийг Засгийн газраас өгсөн.

Гагцхүү журам батлах эрх зүйн үндэслэлийг хуулиас хасах нь холбогдох харилцааг зохицуулалтгүй үлдээх сөрөг үр дагавартай. Иймд Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн дагуу батлагдсан журмуудад юун түрүүнд дүн шинжилгээ хийж, уг журам дахь хүний эрхийг хөндсөн голлох зохицуулалтыг тодорхойлж, тэдгээрийг хуульд нэмэх дарааллаар ажиллахыг зөвлөж байна.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Аргачлалын 4.10 дахь хэсэгт “Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгах хэрэгслийн хүрээнд дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтооно” гэж заасны дагуу дараах агуулгын хүрээнд харилцан уялдааг үнэлэв.

1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Өмнөх хэсэгт өгүүлсэн.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуулийн төслийн 6.4 дэх хэсэгт заасан ахмад настан, хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан хүн, өрх толгойлсон эцэг, эх, гадаадын иргэн, харъяалалгүй хүн гэх нэр томъёо нь холбогдох хууль тогтоомжид заасантай нийцсэн ч 6.4 дэх хэсэгт нэр томъёоны тодорхойлолтыг тусгах нь оновчгүйг анхаарах нь зүйтэй.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн хүүхдийн тэтгэмж гаргуулах болон үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрхтэй холбоотой захиргааны маргааны хүрээнд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй авах боломжтой байсныг ¹⁰⁷ Хөдөлмөрийн чадвараа 70 бас түүнээс дээш хувиар алдсан иргэн гэж өөрчилсөн. Хуулийн төслөөр 6.4 дэх хэсэгт тодорхойлолтуудыг нэмэхээр тусгасан гэвч ингэхдээ хуулийн 6.4 дэх хэсгийг бүхэлд нь шинэчилсэн эсэх эсхүл 6.4 дэх хэсэгт нэмэлт заалт оруулж байгаа эсэхийг тодорхойгүй боловсруулжээ. Өөрөөр хэлбэл, дээрх иргэн өмнөх хуулийн дагуу гагцхүү дээр дурдсан 2 маргааны хүрээнд эсхүл бүх төрлийн маргааны хүрээнд хууль зүйн туслалцаа авах боломжтой эсэх нь тодорхой биш байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардаагүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуулийн төслөөр гагцхүү хүчин төгөлдөр үйлчилж буй журмыг хүчингүй болгох нь холбогдох харилцааг зохицуулалтгүй үлдээх сөрөг үр дагавартай байна. Иймд холбогдох журам дахь хүний эрх, эрх чөлөө, процессын эрхийг хөндсөн зохицуулалтыг журмаас хасаж, түүний оронд хуулиар зохицуулж, иргэний эрхийн баталгааг хангах ёстой.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн	Үгүй.

¹⁰⁷ 6.4.Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх энэ хуулийн 6.1.4, 6.1.5-д заасан хэрэг, маргаанд хууль зүйн туслалцаа авч болно.

6.1.4.хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй бол;

6.1.5.үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсэн захиргааны хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй бол;

	холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Үгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Энэ талаар нэмэлт, өөрчлөлт байхгүй.

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ХЭЗБТХ-ийн хоёрдугаар бүлэгт хуульчийн шалгалттай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд уг бүлгийн 11 дүгээр зүйлд хуульчийн шалгалтад орох эрх үүсэхтэй холбоотой буюу хуульчийн шалгалт өгөхөд тавигдах мэргэжлийн дадлагын талаах зохицуулсан байдаг. Уг зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар прокурор, нотариатч, өмгөөлөгчийн туслах гэсэн ажлыг хуульчийн мэргэжлийн дадлагад тооцохоор хуульчилсан бөгөөд хэрэв ХЭЗБТХ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан өөрчлөлт орвол нэмэлтээр шүүгч болон шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гэсэн хоёр ажил, албан тушаалыг эрхэлж байгааг хуульчийн мэргэжлийн дадлагад тооцохоор байна.

“Шүүгч” гэж нэмсэн тухайд, 2012 онд батлагдсан ХЭЗБТХ-иар “шүүгч” албан тушаалыг хуульчийн мэргэжлийн дадлагад тооцдог байсан боловч 2021 оны 1-р сарын 15-ны өдөр батлагдсан “Шүүхийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын шүүгчид тавигдах болзол, шаардлагын тухай зохицуулсан 31 дүгээр зүйлийн 31.1.4-т **“хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх”** гэсэн тусгай шаардлагыг хуульчилсантай холбогдуулан тус өдрийн “ХЭЗБТХ-д Нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”¹⁰⁸-иар “шүүгч” гэснийг хассан байна.

¹⁰⁸ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2021), 3 дугаар зүйл.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381560317621&showType=1>

Иймд хэрэв тус хуулийн төсөлд зааснаар ХЭЗБТХ-ийн 11 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт өөрчлөлт орж “шүүгч” албан тушаалтыг хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох зохицуулалтыг хийснээр дараах хуулийн заалтуудтай хуулийн төслийн уг заалт нь зөрчилдөх юм. Эдгээрт:

- ШТХ-ийн 31.1.Шүүгч Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон дараах шаардлагыг хангасан байна:
31.1.4.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;
- ХЭЗБТХ-ийн 3.1.1.."хуульч" гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээдийг;
3.1.2."хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл" гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг энэ хуулиар тогтоосон зарчим, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг баталгаажуулсан албан ёсны баримт бичгийг;

Өөрөөр хэлбэл, шүүгчээр томилоход тавигдах “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх” гэсэн шаардлага байхад шүүгчээр ажиллах гэсэн шаардлагыг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах буюу хуульчийн шалгалтад орох эрхэд тавигдах “хуульчийн мэргэжлийн дадлагад” тооцон зохицуулах нь логик алдаатай буюу одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүхийн тухай хууль болон ХЭЗБТХ-ийн зарим зүйл заалттай нийцэхгүй байна. Иймд уг хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/ -т “шүүгч” гэсэн заалт нь практикт хэрэгжих боломжгүй зохицуулалт байна.

“Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга” гэж нэмсэн тухайд, ШХНБД-ын тухайд 2013 оны 2 дугаар сарын 8-ны өдрөөс өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 2002 оны Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийг тайлбарласан УДШ-ийн 08 дугаар тогтоолын 1а-д дараах байдлаар тайлбарласан байна.

Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай

1. Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн “хуульч мэргэжлээрээ ажилласан хугацаа” гэдэгт эрх зүйч мэргэжлээр хууль зүйн дунд болон дээд боловсрол эзэмшсэн хүн зайлшгүй ажиллавал зохих дараах ажил, албан тушаалд ажилласан хугацааг тооцно. Үүнд:

а. Бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шийдвэр гүйцэтгэгч, өмгөөлөгч, нотариатч, арбитрч, тэдгээрийн туслах ажилтан, нарийн бичгийн дарга;

УДШ-ийн 08 дугаар тогтоолын хэсгээс¹⁰⁹

Мөн ХЭЗБТХ, ХЭЗБТХ-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зарим зүйл заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 2014 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн дугаар 06 тогтоолд дараах дүгнэлтийн ҮХЦ өгсөн байна.

¹⁰⁹ УДШ-ийн 2006 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дугаар 08 тогтоол. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468097048401>

“Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.” Гэж заасан... “...шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар ажилласан этгээдэд Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “мэргэжлээрээ ажилласан” гэдэгт хамаарна гэж үзэхээр байна...”

*ҮХЦ-ийн 2014 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн дугаар
06 тогтоолын хэсгээс¹¹⁰*

Дээрхээс үзэхэд шүүгч болоход “шүүх хуралдааны нарийн бичгийн дарга”-аар ажилласан хугацааг Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “мэргэжлээрээ ажилласан” гэдэгт хамаарч байгаа боловч ХЭЗБТХ-д заасан “хуульчийн мэргэжлийн дадлага” гэдэгт хамаарахгүй байгаа нь хууль эрх зүйн зөрчил, хийдэл болон тодорхойгүй байдлыг үүсгэж байна.

Эрх зүйн цахим мэдээллийн сангаас Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуультай холбоо Монгол Улсын ҮХЦ-ийн шийдвэрлэсэн 11 маргаан байх та үүний 3 маргаан нь ХЭЗБТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгтэй хамааралтай заалт байна. Жишээ нь, иргэн Э.Мөнхдаваа тэргүүтэй бусад “хууль зүйн их, дээд сургууль төгссөн хүн хоёр жил мэргэжлээрээ ажилласан тохиолдолд хуульчийн сонгон шалгаруулалтад орж хуульчийн гэрчилгээ авах, улмаар хуульч, шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр ажиллах боломжийг дээрх хуульд тодорхой тооны этгээдэд олгохоор хуульд заасан. Энэ нь тэдгээртэй адилтган үзэж болох ажил, албан тушаал эрхэлж буй бусад иргэдийг ялгаварлан гадуурхаж, тэгш бус байдал үүсгэж байна” гэж үзэн 2019 онд ҮХЦ-д ханджээ.

ХЭЗБТХ-ийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээс гадна Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын 13 дугаар тогтоолын хавсралтаар “Хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох журам”-ыг¹¹¹ баталсан. Уг журмын 3 дугаар зүйлд заасны дагуу “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө дараах ажил, албан тушаалд хоёроос доошгүй жил ажилласан бол Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийг үндэслэн мэргэжлийн дадлагад “...нарийн бичгийн дарга;”-ыг хамруулахаар заасан байна.

Иймд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/-т заасны дагуу ХЭЗБТХ-ийн 11.1.1 дэх заалтад “шүүх хуралдааны нарийн бичгийн дарга” гэж нэмж, уг ажлыг нь хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох зохицуулалт хийх нь дээр дурдсан Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хуулийн дээр дурдсан холбогдох зохицуулалт, УДШ болон ҮХЦ-ийн тогтоол, шийдвэрүүдтэй нийцэж байх тул уг хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой байна.

¹¹⁰ ҮХЦ-ийн 2014 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн дугаар 06 тогтоол.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=10727>

¹¹¹ МХХ-ны зөвлөлийн хурлын тогтоол дугаар 13 “журам батлах” тухай.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=12634>

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ХЭЗБТХ-ийн 26 дугаар зүйлийн дагуу хуульч нь хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, тодорхой багц цаг хангах¹¹² нийтлэг үүргийг хүлээдэг бөгөөд хуульчийн үргэлжилсэн сургалтыг зохион байгуулах ажлыг 53 дугаар зүйлд заасан “хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо” хариуцдаг. Мөн хуулийн 54 дүгээр зүйлд хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хорооны тухай зохицуулалтыг 1 дэх хэсэгт уг хорооны “хуульчийн ёс зүйн сургалтыг зохион байгуулах” чиг үүргийг тус тус зохицуулсан байдаг.

Эндээс дүгнэн үзэхэд хуульч буюу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь ХЭЗБТХ-ийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “хуульч өөрийгөө мэргэжилтний хувьд тасралтгүй хөгжүүлэх” зарчмын хүрээнд хуульчийн үргэлжилсэн болон ёс зүйн гэсэн 2 төрлийн сургалтад хамрагдахаар байна. Иймд тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу ХЭЗБТХ-ийн 55.1 дэх хуульчийн үргэлжилсэн сургалтын хугацаатай холбоотой зохицуулалтыг өөрчлөн найруулж хуульчидын үргэлжилсэн болон ёс зүйн сургалтын агуулгыг тогтоон хуульчлахаар боловсруулсан нь одоо мөрдөгдөж буй дээр дурдсан хуулийн зохицуулалтуудтай нийцэж байна.

Мөн ХЭЗБТХ-ийн зорилго хуульчийн эрх зүйн байдал, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, мэргэжлийн нэр хүнд, хариуцлагын тогтолцоо, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх¹¹³ бөгөөд үргэлжилсэн сургалтын зорилго нь хуульчдын мэдлэг, мэргэшлийн түвшин, ур чадварыг эрх зүйн онолын орчин үеийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэл, шүүх мэдлийн байгууллагын хөгжлийн шаардлагад нийцүүлэн тогтмол дээшлүүлэх, мэргэжлийн ёс зүйг чанд мөрдөж, шударга, хараат бус ажиллах чадварыг төлөвшүүлэхэд чиглэнэ.¹¹⁴

Дээрхээс үзэхэд тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хуульчийн үргэлжилсэн сургалтын агуулга нь Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, шинээр батлагдсан хууль тогтоомжийг таниулах, хуульчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, ёс зүйг нэмэгдүүлэх, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх дадал төлөвшүүлэхэд чиглэгдэнэ” гэсэн нь ХЭЗБТХ-ийн зорилго, дээр дурдсан тус хуулийн зарим зүйл заалт болон практикт одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд нийцүүлэн гаргасан “Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тогтоох журам”-ын агуулга зэрэгтэй нийцэж байх тул тус хуулийн төслийн зохицуулалт нь хүлээн зөвшөөрөгдөх байдлын шалгуурыг хангаж байна.

¹¹² Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012).

26 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах нийтлэг үүрэг 26.1.4.хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, тодорхой багц цаг хангах;

¹¹³ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012). 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1 дэх хэсэг.

¹¹⁴ Монголын Хуульчдын Холбооны зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хурлын 06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тогтоох журмын 1.1 дэх зүйлийн 2 дахь хэсэг.

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Хуулийн төслийн танилцуулгад тусгагдсанаар дараах үндсэн асуудлыг шийдвэрлэх үүднээс Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулсан байна. Үүнд:

1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд “хохирогч”-ийг харилцан адилгүй зохицуулсныг уялдуулж нийцүүлэх;
2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хохирогчийг хамгаалах байрны зохицуулалтын зөрчилдөөнийг арилгах, хохирогчийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэх зохицуулалтыг тусгах.
3. Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах ажиллагааны хүрээнд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасны дагуу хохирогчийн хувийн мэдээллийг нууцлах үүргийг тодорхой тусгах;
4. Нэн тэргүүнд хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах эрэмбийг тогтоох;
5. Гадаадын иргэн, харъяалалгүй хүн, хөгжлийн бэрхшээлтэй хохирогчийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах;


Хохирогчоор тогтоох асуудлын хүрээнд

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3.1.2 дахь хэсэгт "хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг, харин Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4.1.1 дэх хэсэгт "гэрч, хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг ойлгохоор тус тус тусгасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт

“Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ” гэжээ.

Өөрөөр хэлбэл, холбогдох хуульд тусгагдсан нэр томъёо хоорондоо зөрчилдөж байна гэж үзэхэд хүндрэлтэй, учир нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд “хохирогчоор тогтоосон эсэхээс үл хамааран” хохирогч гэж үзэхээр тусгайлан тусгасан байна. Гэвч практикт дээр ЭХХШТХ-ийн 8.1.2 дахь хэсгийн дагуу шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох тухай шийдвэр гаргах шаардлага үүсдэг бөгөөд энэ нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3.1.2 дахь хэсгийн зорилготой төдийлөн нийцэхгүй байгаа юм. Тухайлбал, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хамгаалалтын арга хэмжээг авахын тулд зайлшгүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчоор тогтоогдсон байхаар заасан нь хохирогч хуулийн байгууллагад хандаж тусламж, дэмжлэг авч чадахгүйд хүргэдэг байна.¹¹⁵ Практикт ЦЕГ-

¹¹⁵ Монгол Улс дахь ХХГХ-ийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа, 2022, <https://mongolia.iom.int/sites/g/files/tmzbd11611/files/documents/mongol-uls-dakh-khun-khudaldaalakh-gemt-khergiyn-suur-sudalгаа.pdf>



ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь ЭЦГ-ын Хүн худалдаалахтай тэмцэх хэлтсээс хохирогчоор илрүүлсэн иргэний эрсдэлийн үнэлгээг хэрэг бүртгэлтийн болон эрүүгийн хэрэг үүссэн эсэхээс үл хамааран хийх бөгөөд хамгаалах байранд байрлуулах, хамгаалалтад авах бол хэрэг бүртгэлтийн хэрэг нээж хяналтын прокурорын тогтоолоор хэрэгждэг.

Гэвч Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд тусгасан тохиолдолд тодорхойлолт нь тусгай хэм хэмжээ тул Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас давуу үйлчлэх учиртай. Иймд хохирогчийг тодорхойлсон байдалд бус түүнийг хэрэгжүүлж буй албан хаагчдын энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдлэг, мэдээлэл хангалттай бус байгаатай холбоотой юм.

Бусад улс орны туршлагыг харж үзвэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох, хамгаалах, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хэм хэмжээг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар нарийвчилсан заавар, зөвлөмжийг боловсруулан, албан хаагчдыг мэдээллээр хангах нь нийтлэг байна. Тухайлбал, Тайланд улсын 2013 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах заавар (Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking)¹¹⁶-ийг дурдаж болно.

Хуулийн төслийн 10¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй талаарх мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллага хүлээн авсан даруйд хохирогчийг тогтоох арга хэмжээ авна” гэж тодорхойлсон нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг тогтооход чиглэгдсэн байна. Практикт энэ төрлийн гэмт хэргийн хохирогч эрх бүхий хууль хяналтын байгууллагад хандсан тохиолдолд хохирогчоор тогтоох боломжтой. Өөрөөр хэлбэл, төрийн эрх бүхий байгууллага өөрийн санаачилгаар хохирогчоор тогтоодоггүй. Бусад улсын туршлагыг авч үзвэл, хохирогчоор тогтоох нь хохирогчийг хамгаалах, нөхөн төлбөр олгох, зохих үйлчилгээг үзүүлэх асуудалтай салшгүй холбоотой гэж үзэх бөгөөд хохирогчийг тогтоох үр дүнтэй механизмыг сайжруулах зохицуулалт 2013 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах заавар (Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking)¹¹⁷-т тусгагдсан. Тус зааврын дагуу хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээллийг авсан даруй холбогдох байгууллагууд Хамтарсан баг (‘MDT’)-ийг байгуулж, гэмт хэргийн ул мөрийг бэхжүүлэх чиглэлээр (initial fact finding) ажиллаж эхлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд хохирогчийг аврах ажиллагааг (rescue operation) зохион байгуулдаг байна. MDT-с аливаа этгээдийг хохирогч гэж үзсэн бол Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамнаас орон байраар хангаж, хуульд заасан туслалцааг үзүүлнэ.

Дээрх үзэхэд, хуулийн төслийн 10¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй талаарх мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллага хүлээн авсан даруйд хохирогчийг тогтоох арга хэмжээ авна” гэж

¹¹⁶ Bureau of Anti-Trafficking in Women and Children and Japan International Cooperation Agency, MDT Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking. https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf

¹¹⁷ Bureau of Anti-Trafficking in Women and Children and Japan International Cooperation Agency, MDT Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking. https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf

тодорхойлсон нь хохирогчоор тогтоохтой холбоотой үүсдэг асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой бөгөөд зорилгодоо нийцсэн байна.


Хохирогч хамгаалал, хохирогчдод үзүүлэх тусламж, үйлчилгээ

IRIM судалгааны хүрээлэнгээс 2020 оны 4-р сараас 2021 оны 10-р сарын хооронд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ)-ын 2020-2022 оны хугацаанд хэрэгжүүлж буй “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа”-г 2022 онд гүйцэтгэсэн. Тус судалгааны тайланд тусгаснаар хохирогчийг хамгаалах, тусламж, үйлчилгээ үзүүлэх харилцаанд дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:¹¹⁸

1. Уг судалгааны хүрээнд 14 хохирогчтой долоон хэргийн материалтай танилцахад хохирогчдын ихэнх нь (n=11) ямар нэгэн үйлчилгээ, тусламж, дэмжлэг аваагүй байсан...Төрөөс хохирогч хамгааллын үйлчилгээг үзүүлж буй туршлага одоогоор байхгүйн зэрэгцээ энэ төрлийн үйлчилгээнд тусгайлсан төсөв тавигдсан, зарцуулагдсан туршлага өмнө байгаагүй.
2. Үйлчилгээ үзүүлэгч ТББ-ын төлөөлөлтэй ярилцах явцад ХХГХ-ийн хохирогч нарт анхан шатны туслалцаа нэн тэргүүнд шаардлагатай байдаг бөгөөд тус туслалцаанд сэтгэл зүйн зөвлөгөө, хууль эрх зүйн туслалцаа, эрүүл мэндийн үзлэг, хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнүүд багтдаг. Гэвч Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зөвхөн хохирогчид нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхээр тусгасан ба анхан шатны үйлчилгээг хэн үзүүлэх, хаана хандах талаар зохицуулалт орхигдсон байна. Уг орон зайг ТББ-ууд нөхөж ОУБ-ын дэмжлэгтэйгээр өнөөг хүртэл хохирогчдод нэн шаардлагатай анхан шатны үйлчилгээг үзүүлж байна.
3. Тус судалгааны хүрээнд хохирогчид үзүүлж буй тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилладаг Иргэдэд туслах хүний эрх төв, ХТЭТ, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Талита Ази, ЭКПАТ Үндэсний сүлжээ, Unbound ТББ-уудын төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулсан байна. Тус төрийн бус байгууллагаас тусламж, үйлчилгээ авсан цөөн хохирогчийн тухайд хамгаалах байранд цөөн хоногоор байрласан, хууль зүйн туслалцаа авсан, сэтгэл зүйн зөвлөгөө, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан хэдий ч санхүүгийн асуудлаас шалтгаалан үргэлжлүүлэн авч чадаагүй.
4. ХХГХ-ийн хохирогчдод тусламж үйлчилгээг хүргэж болох өөр нэг хувилбар нь төрийн байгууллагуудын харьяа нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ)-д юм. Эдгээр төвүүд нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод олон талт үйлчилгээ үзүүлдэг бөгөөд Монгол Улсын бараг бүх аймагт салбартай, хүний нөөцийн хувьд зорилтот бүлгийн иргэдтэй харилцах, ажиллах чиглэлээр сургалтуудад хамрагддаг, санхүүжилтийн хувьд тогтвортой байдаг тул ХХГХ-ийн хохирогчдод анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагааг нь өргөжүүлэх боломжтой гэж үзжээ.

¹¹⁸ Монгол Улс дахь ХХГХ-ийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа, 2022, <https://mongolia.iom.int/sites/g/files/tmzbd11611/files/documents/mongol-uls-dakh-khun-khudaldaalakh-gemt-khergiyn-suur-sudalгаа.pdf>

2021 оны судалгаагаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид ТББ-уудад хандаж заавал шийдүүлж өгөх дараах санал, хүсэлтийг гаргасан байна. Үүнд: ¹¹⁹



Хуулийн төсөлд хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хохирогчийг хамгаалах байрны зохицуулалтын зөрчилдөөнийг арилгах, хохирогчийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэх зохицуулалтыг тусгах зорилгоор ХХТХ-ын 9.4 дэх хэсэгт хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар зохицуулна гэж нэмсэн байх бөгөөд энэ нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хохирогчийг хамгаалах байрны зохицуулалтын зөрчилдөөнийг арилгахад чиглэжээ. Мөн хуулийн төслийн 10¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй нөхцөл байдал, шинж тэмдэг илэрвэл эрсдэлийн үнэлгээ хийж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Хохирогчийн аюулгүй байдлыг хангахдаа амь нас, эрүүл мэнд болон сэтгэл зүйн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангана” гэж тусгасан.

Хохирогчийг хамгаалах, түүнд тусламж, үйлчилгээ үзүүлэх харилцааг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар зохицуулах нь хийдэл, зөрчлөөс сэргийлэх сайн талтай байна. Тухайлбал, тус хуульд заасан бүх төрлийн аюулгүй байдлын болон сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг авах боломжтой болно.

Гэвч дээрх 2 хуулийн харилцан уялдаагүй байдлаас гадна энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид шаардлагатай байдаг сэтгэл зүйн зөвлөгөө, хууль эрх зүйн

¹¹⁹ Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал, 2021, <https://asiafoundation.org/wp-content/uploads/2021/11/Mapping-the-National-Mechanism-of-Service-Provision-to-Victims-of-Trafficking.pdf>

туслалцаа, эрүүл мэндийн үзлэг, хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд төрөөс үзүүлэх санхүүжилт, механизмыг дээшлүүлэх шаардлага байна. Цаашлаад, ХХГХ-тэй тэмцэх тухай хуульд байгууллагуудын үүрэг, оролцоог зааж өгсөн ч бусад гэмт хэргээс онцлог, ялгаатай ХХГХ-ийн хохирогчийн эрхийг хамгаалах хуульгүйгээс Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар хамгаалагдах боломж нь хязгаарлагдаж байгааг зарим судлаачид тэмдэглэжээ.¹²⁰

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх харилцаанд төрийн бус байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч жил ирэх тутам ХХГХ-ийн хохирогчийн тоо буурахгүй, насанд хүрээгүй хүүхдүүд хохирогч болох нь нэмэгдэж байгаа боловч тэдэнд үйлчилгээ үзүүлэх ТББ-ын тоо нэмэгдэхгүй байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллээр 2020 оны эцэст 25,388 төрийн бус байгууллага бүртгэгдсэн байгаа нь 1998 оноос 23.6 дахин нэмэгдсэн ч үйлчилгээний чиглэлээр ажилладаг ТББ-ын тоо нэмэгдээгүй байгаад анхаарал хандуулах шаардлагатай. Төрөөс хохирогчид үзүүлэх үйлчилгээний санхүүжилтийг бусад бизнесийн, худалдан авалтын тендерүүдтэй адилтгаж зарладаг, зарлагдаж буй санхүүжилтэд ажилтны цалин, хамгаалах байрны татвар, урсгал зардал багтдаггүй тул байгууллага тогтвортой ажиллаж, үйлчилгээ үзүүлж чадахгүйгээс энэ чиглэлийн ТББ-ын тоо нэмэгдэхгүй хэвээр байна.¹²¹

Бусад улсын сайн туршлагыг үзвэл, АНУ-ын Холбооны улсын хэмжээнд 1984 батлагдсан Гэмт хэргийн хохирогчийн тухай хууль (Victims of Crime Act (VOCA)) нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Энэхүү хуульд зааснаар Холбооны хэмжээнд АНУ-ын Хууль зүйн яамны Гэмт хэргийн хохирогчийн алба нь тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, сангийн мөнгөн хөрөнгийг хуваарилах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг хариуцан ажилладаг ажээ. 1984 оны Гэмт хэргийн хохирогчийн тухай хуулиар (VOCA) Гэмт хэргийн хохирогчдын сан¹²² (Сан) байгуулагдсан. Сан нь татварын мөнгөөр бус, холбооны хэргүүдийн торгох ял, шийтгэлээс санхүүждэг.¹²³ Холбооны улсын тус сангийн хөрөнгөөр гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зарчмаар ажилладаг. Гэвч муж улс бүр нөхөн олговрын сантай гэдгийг мөн дурдах нь зүйтэй.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах хүрээнд Гэмт хэргийн хохирогчдын сан¹²⁴ -гаас санхүүжүүлдэг хөтөлбөр, үйл ажиллагаанаас дурдвал:¹²⁵

2. Бүх төрлийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх цогц үйлчилгээний хөтөлбөр:
3. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагааг сайжруулах хөтөлбөр:

¹²⁰ “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал”, УБ, 2021 <https://asiafoundation.org/wp-content/uploads/2021/11/Mapping-the-National-Mechanism-of-Service-Provision-to-Victims-of-Trafficking.pdf>, 76 дахь тал.


¹²¹ “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал”, УБ, 2021 <https://asiafoundation.org/wp-content/uploads/2021/11/Mapping-the-National-Mechanism-of-Service-Provision-to-Victims-of-Trafficking.pdf>

¹²² 18 U.S. Code § 3525 - Victims Compensation Fund, <https://www.law.cornell.edu/uscode/text/18/3525>

¹²³ Мөн тэнд.

¹²⁴ 18 U.S. Code § 3525 - Victims Compensation Fund, <https://www.law.cornell.edu/uscode/text/18/3525>

¹²⁵ Office for Victims of Crime, Current Funding Opportunities, <https://ovc.ojp.gov/funding/current-funding-opportunities>

- 
4. Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг насанд хүрээгүй хүүхэд, гэр бүлийн шүүхийн хариу арга хэмжээг сайжруулах;
 5. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслах инноваци хөтөлбөр;
 6. Бэлгийн мөлжлөгийн зорилготой хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчдын чиглэлээр боловсруулсан стратеги;
 7. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод олгох орон сууцны тусламж;
 8. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх сургалт, техникийн туслалцааны хөтөлбөр;
 9. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэд, залуучуудад үзүүлэх үр дүнг сайжруулах хөтөлбөр
 10. Гэмт хэргийн хохирогчдод хандах эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх хөтөлбөр
 11. Хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчдод зориулсан нэгдсэн үйлчилгээ
 12. Охидыг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
 13. Бэлгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон Америкийн хотын индианчууд болон Аляскийн уугуул иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх хөтөлбөр;
 14. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ хөтөлбөр.

Эндээс үзвэл, төрөөс энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх төсөл хөтөлбөрийг хохирогчийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн олон хувилбар, төрлөөр зарлаж, сонгогдсон байгууллагад хангалттай хэмжээний санхүүжилт олгож ажиллах нь үр дүнтэй байна.

Мөн хуулийн төслийн 10¹ дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт цагдаа, тагнуулын байгууллагын албан хаагчийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах хүрээнд авч хэрэгжүүлэх тусгай арга хэмжээ¹²⁶г тодорхойлсон. Үүнд:

1. Хохирогчид хуульд заасан эрх, үүрэг, төрийн болон төрийн бус байгууллагаас түүнд үзүүлж болох тусламж, үйлчилгээний талаар болон шаардлагатай бусад мэдээллийг өгөх;
2. Хохирогчийн эрсдэлийн үнэлгээний түвшингээс хамаарч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнд прокурорын тогтоол, шүүгчийн захирамжийг үндэслэн хамруулах;
3. Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд халдах талаар үндэслэлтэй мэдээлэл авагдсан тохиолдолд хамгаалалтад авах арга хэмжээг хохирогчийн зөвшөөрөл шаардахгүйгээр зохион байгуулах;
4. Хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамрагдахаас сайн дураар татгалзсан бол энэ талаар баримтжуулах;
5. Оршин суугаа газраа соливол мэдэгдэхийг хохирогчид даалгах;
6. Гэмт хэрэгт холбогдсон этгээдийг сэжигтнээр баривчлан сулласан болон яллагдагчаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, сулласан тухай мэдээллийг цаг алдалгүй өгөх.

Харин хуулийн төслийн 10¹ дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт шүүх, прокуророос авч хэрэгжүүлэх дараах тусгай арга хэмжээг тусгасан байна.

1. Хохирогчийн мэдээллийг нууцлах;
2. Хамгаалах байранд байгаа хохирогчтой аль болох уулзахгүй байх, уулзах бол нууц байдалд уулзах;

¹²⁶ ЭХХШтХ-д заагаагүй.

3. Шүүх хуралдаан болох байрны аюулгүй байдлын зураглалыг гаргах, шаардлагатай тохиолдолд шүүх хуралдааныг өөр байранд хийх саналыг гаргах.

Дээр заасан арга хэмжээнүүд нь хохирогчийн эрхийг хамгаалахад ач холбогдолтой байна.


Гэвч 10¹.7.2 дахь хэсгийг дахин нягтлах шаардлагатай байна. Тус заалтын дагуу гагцхүү прокурор, шүүгчийн тогтоол, захирамжаар Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг авах үндэслэл бүрдэхээр байна. Гэвч хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан эсхүл учирч болзошгүй гэж үзсэн тохиолдолд прокурор, шүүгчийн шийдвэргүйгээр яаралтай нүүлгэн шилжүүлэх, хамгаалалтад авах боломж хязгаарлагдсан байгааг анхаарах нь зүйтэй.

Цаашлаад бусад улс орны сайн туршлагыг авч үзвэл, Тайланд улсад 2008 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хуулийн 35 дугаар зүйлд зааснаар хохирогч нөхөн төлбөр нэхэмжлэх хүсэлтэй байгаа бол прокурор түүний өмнөөс нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг нотлох үүрэгтэй байдлаар зохицуулсан байна. Цаашлаад ийнхүү нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар хохирол нөхөн төлүүлэхээр шийдвэрлэх эрхтэй байдгаараа онцлогтой байгаа нь Монгол Улсын эрх орчноос ялгаатай байна. Нидерланд, АНУ зэрэг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо сайтай улсуудад прокурор иргэний нэхэмжлэл гаргах харилцаанд мөн адил чухал үүрэг гүйцэтгэж байна. Иймд дээр дурдсан сайн жишигтэй нийцүүлэн холбогдох зохицуулалтыг тусгах боломжтой гэж үзлээ.

Хохирогчийн хэрэгцээ, шаардлагад тохирсон үйлчилгээ үзүүлэх талаар

Төслийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт гадаадын иргэн, харъяалалгүй хүн хохирогч болсон тохиолдолд өөрийн эх хэл, эсхүл мэдэх хэлээрээ орчуулагч оролцуулан мэдээлэл авах эрхтэй байхаар, 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт хохирогч хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан хэлмэрчийн тусламжтайгаар хохирогчид үзүүлэх халамж үйлчилгээний талаарх мэдээллийг авах эрхтэй байхаар, мөн төслийн 10¹ дүгээр зүйлийн мөн зүйлийн 3 дахь хэсэгт 'Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь хүүхэд бол хүүхэд гэр бүл хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу яаралтай тусламж үйлчилгээнд хамруулж болно' гэж, 13.5 дахь хэсэгт хохирогч хүүхдийн гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч түүний эсрэг ашиг сонирхолтой бол хүүхдийг нэн даруй тэдгээрээс тусгаарлана гэж, 13.6 дахь хэсэгт хохирогчийг насанд хүрснийг тодорхойлох боломжгүй үед насыг тогтоох хүртэл насанд хүрээгүйд тооцож хамгаалалтын арга хэмжээнд хамруулна гэж тус тус заасан.

Дээрх зохицуулалтууд нь гадаадын иргэн, харъяалалгүй хүн, насанд хүрээгүй хохирогч, хөгжлийн бэрхшээлтэй хохирогчийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн байна. 2019-2022 оны статистикийг авч үзвэл 14 хүртэлх насны хохирогч бүртгэгдээгүй байх боловч 14-17 насны хохирогчийн тоо 17 байгаа нь нийт 25 хохирогчийн 68 хувьтай тэнцэж байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт байна.



2021 оны судалгаагаар насанд хүрээгүй хохирогчийг хамгаалах практикт дараах асуудал тулгамдсаар байна. Үүнд:¹²⁷

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг даган гарсан Аюулгүй газарт түр байрлуулах журмаар хохирогчийн эрсдэлийн түвшнээс хамаарч гэрч, хохирогчид төрийн болон ТББ хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэхээр журамласан бөгөөд хууль 2020 онд шинэчлэгдсэнээр тус журам 2021 онд мөн шинэчлэгдэн батлагдсан. Журамд насанд хүрээгүй гэрч, хохирогчид хамгаалалтын арга хэмжээний туслалцаа үзүүлэх тусгайлсан бүлэг оруулсан боловч одоогоор Монгол Улсад насанд хүрээгүй хүн худалдаалах гэмт хохирогчийг байрлуулах тусгайлсан хамгаалах байр байхгүй.
- Одоогоор ХХГХ-ийн хохирогчдод урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, эргэн хэвийн амьдралдаа ороход зайлшгүй шаардлагатай амьдрах орон байр, тогтвортой орлоготой болох ажлын байраар хангах, насанд хүрээгүй хохирогчдын суурь боловсролыг эзэмшүүлэх талаарх үйлчилгээг зохицуулсан хууль тогтоомж, стандарт байхгүй.
- Насанд хүрээгүй хохирогчдод онцгойлон анхаарал хандуулан, дагнасан үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байна. Хохирогч хүүхэд нь насанд хүрсэн хохирогчтой харьцуулахад бие махбод, сэтгэлзүйн хувьд бүрэн хөгжөөгүй, шийдвэр гаргах чадваргүй, насанд хүрэгчдээс хараат зэргээс шалтгаалан түүнд үзүүлэх үйлчилгээ нь ялгаатай гэдгийн хүлээн зөвшөөрч ажиллах, тусгайлан үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байна. Хохирогч эргэн хэвийн амьдралдаа ортол нэгээс гурван жилийн хугацаа шаардлагатай ба ар гэрийн нөхцөл байдлаас шалтгаалан хэвийн амьдралдаа орох хугацаа харилцан адилгүй. Олонх хохирогч бүх шатны шүүхээр хэрэг эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл гэмт хэрэгтнүүдтэй огт харьцахгүй байх боломжтой тусгай байранд

¹²⁷ “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал”, УБ, 2021 <https://asiafoundation.org/wp-content/uploads/2021/11/Mapping-the-National-Mechanism-of-Service-Provision-to-Victims-of-Trafficking.pdf>

байрлуулж, нууцлалыг хангаж өгөхийг хүсдэг ч хэрэгжих боломжгүй байна гэжээ.

Цаашлаад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйл “Насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна. Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана” гэж заасан. Гэвч насанд хүрээгүй хохирогчийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэрхэх талаар нарийн зохицуулалт байхгүй байна. Бусад улсын сайн туршлагыг авч үзвэл, Тайваний Хохирогчийн эрхийг хамгаалах тухай хуульд¹²⁸ асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй насанд хүрээгүй этгээд гэмт хэргийн хохирогч болсон эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь гэмт хэрэгтэн байх тохиолдолд тусгай чиг үүрэг бүхий байгууллага эсхүл төрөөс хүүхдийг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжтой байхаас гадна асран хамгаалагч эсхүл харгалзан дэмжигчгүй хүүхдэд олгох нөхөн төлбөрийг хохирогч хүүхдийг насанд хүрэх хүртэлх хугацаанд тусгайлан итгэмжлэн хадгалж, хуваарьтайгаар эсхүл хэсэгчлэн олгох чиг үүргийн тусгай байгууллагад хүлээлгэж болохоор зохицуулжээ.

Дээрхээс үзвэл насанд хүрээгүй хохирогчийг тусгайлан хамгаалах байр нэн тэргүүний асуудал бөгөөд насанд хүрсэн хохирогчтой харьцуулан үзвэл урт хугацааны тусламж, үйлчилгээ шаардлагатай байх бөгөөд хохирогчийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэмт хэрэг үйлдсэн эсхүл хохирогчийг хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээг аваагүй, түүнийг төлөөлөх үүрэгтээ хойрго хандсан тохиолдолд төрийн болон төрийн бус байгууллага идэвхтэй оролцох шаардлагатай байна. Хуулийн төсөлд энэ талаарх нарийн зохицуулалтыг тусгаагүй байгаа нь учир дутагдалтай байна.

Хохирогчийн хувийн мэдээллийг хамгаалах

Хуулийн төслийн 10.5 дахь хэсэгт тагнуул, цагдаа, шүүх, прокурорын байгууллагаас бусад төрийн албан нууцтай танилцах эрх бүхий байгууллагууд хохирогчоос зөвшөөрөл авсны үндсэн дээр хувийн мэдээллийг дамжуулж ашиглахаар тусгаснаас гадна 10.1 дэх хэсэгт оруулах өөрчлөлтөөр хохирогчийн “хувийн мэдээлэл”-ийг нууцлахаар өөрчилсөн, мөн төслийн 10¹ дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд тухайн хэргийг шалгаж байгаа мөрдөгч, хяналт тавьж буй прокурорыг солихгүй гэж тусгасан.

Дээрх зохицуулалтууд нь хохирогчийн хувийн мэдээллийг нууцлах, хамгаалахад чиглэгдсэн.

Хохирогчид үзүүлэх хууль зүйн туслалцаа

2022 оны судалгаагаар, тус судалгаанд хамрагдсан шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн нийт 14 хохирогчдоос зөвхөн нэг л хохирогч өмгөөлөгч авсан бол

¹²⁸ Crime Victims Rights Protection act, Taiwan
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=I0050005>

үлдсэн 13 хохирогч нь төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөллийн үйлчилгээ авч чадаагүй байв.¹²⁹

Хэдийгээр Монголын Хуульчдын холбооноос төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг ч иргэдээс төлбөрийн чадваргүй байдлаа нотолсон баримт шаарддаг. Үүнд: Харьяа дүүрэг, хорооны нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсээс амьжиргааны түвшин тогтоосон тодорхойлолт, хөгжлийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт зэрэг бичиг баримтад үндэслэн шийдвэрлэдгээс дээрх шалгуурыг хангахгүй эсхүл тодорхойлолт авахын тулд хохирогч хувийн нууцаа задлах, сул доройгоо дахин мэдрэх зэргээр сэтгэл зүйн хувьд дахин хохирох эрсдэлтэй байдаг.¹³⁰

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлээр Цагдаагийн алба, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газрын даргын дэргэд гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албатай байх, түүний дэргэд мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйчдийн баг ажиллахаар заасан ч өнөөдрийг хүртэл ажиллаж эхлээгүй байна. Дээрхээс харахад ХХГХ-ийн хохирогчийг үнэ төлбөргүй өмгөөлөгчөөр хангах, хууль зүйн туслалцаа үзүүлэх зохицуулалт, тогтолцоо байхгүй байна.¹³¹ Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын дэмжлэгээр зарим хохирогчийг өмгөөлөгчөөр хангадаг ч нийт хохирогчдод хүртээмжгүй байна¹³² гэжээ. Хууль зүйн туслалцаа үзүүлэх хуулийн дагуу улсаас хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааг зөвхөн төлбөрийн чадваргүй хохирогчид үзүүлэхээр хуульчилсан. Өөрөөр хэлбэл, өмнө дурдсанаар төлбөрийн чадваргүй гэдгээ нотлох үүргийг хохирогчид хүлээлгэсэн.

Бусад улсын сайн туршлагыг үзвэл, Нидерланд улсад хохирогчид мэдээлэх өгөх, нэхэмжлэл гаргах эрхийг танилцуулах, үүнд прокурор туслалцаа үзүүлэх, улсаас хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх, цаашлаад шийдвэр гүйцэтгэлийн шатанд улсаас төлөгдөөгүй үлдэгдэл төлбөрийг төлөх зэрэг олон арга хэрэгслийг ашиглаж хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийн баталгааг хангаж байна.¹³³ Мөн Тайланд улсын Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар ийнхүү хохирогчид нөхөн төлбөр олгохоор шийдвэр гарсан тохиолдолд шийдвэрийн биелэлтийг хангуулахад туслах зорилгоор Нийгмийн хөгжил, хүн амын аюулгүй байдлын яамнаас хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлдэг нь хохирогч бодитоор нөхөн төлбөрөө авахад чухал ач холбогдолтой байна.¹³⁴

¹²⁹ “Монгол Улс дахь ХХГХ-ийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа”, УБ, 2022, <https://mongolia.iom.int/sites/g/files/tmzbdl1611/files/documents/mongol-uls-dakh-khun-khudaldaalakh-gemt-khergiyn-suur-sudalгаа.pdf>

¹³⁰ “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал”, УБ, 2021 <https://asiafoundation.org/wp-content/uploads/2021/11/Mapping-the-National-Mechanism-of-Service-Provision-to-Victims-of-Trafficking.pdf>

¹³¹ Мөн тэнд.

¹³² Мөн тэнд.

¹³³ GRETA, Reply from the Netherlands to the Questionnaire for the evaluation of the implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings by the Parties, Third evaluation round, 2022. <https://rm.coe.int/reply-from-the-netherlands-to-the-questionnaire-for-the-evaluation-of-/1680a6615d>

¹³⁴ Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн дагуу тус харилцааг Хууль зүйн туслалцаа үзүүлэх хуулийн дагуу зохицуулахаар эшлэн заасан зохицуулалт нь хууль хоорондын харилцан уялдааг сайжруулахад чиглэжээ. Цаашлаад Хууль зүйн туслалцаа үзүүлэх хуулийн 6.1.2 дахь хэсэгт “төлбөрийн чадваргүй” гэснийг хасахаар томъёолсон байгаа нь оновчтой байна.

Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт нь зорилгодоо нийцэх боловч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн зохицуулалт дутмаг байна. Тухайлбал, Монгол Улсад насанд хүрээгүй этгээд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох нь нийтлэг байх боловч насанд хүрээгүй хохирогчийг хамгаалах тусгай байр болон тэдгээр үзүүлэх урт хугацааны тусламж, үйлчилгээний хүртээмжтэй холбогдох асуудал байсаар байна.

Цаашлаад хохирогчийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэмт хэрэг үйлдсэн эсхүл хохирогчийг хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээг аваагүй, түүнийг төлөөлөх үүрэгтээ хойрго хандсан тохиолдолд төрийн болон төрийн бус байгууллага идэвхтэй оролцох шаардлагатай байгаа боловч хуулийн төсөлд энэ талаарх нарийн зохицуулалтыг тусгаагүй байгаа нь учир дутагдалтай байна.

Механизмын хувьд авч үзвэл, төрөөс энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх төсөл хөтөлбөрийг хохирогчийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн олон хувилбар, төрлөөр зарлаж, сонгогдсон байгууллагад хангалттай хэмжээний санхүүжилт олгож ажиллах нь үр дүнтэй юм.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Аргачлалын 4.10 дахь хэсэгт “Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгах хэрэгслийн хүрээнд дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтооно” гэж заасны дагуу дараах агуулгын хүрээнд харилцан уялдааг үнэлэв.

1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Зорилгодоо нийцэж байна. Гэвч төслийн 10 ¹ .7.2 хэсгийг дахин нягтлах шаардлагатай байна. Тус заа дагуу гагцхүү прокурор, шүүгчийн тогтоол, захирам Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд э хамгаалалтын арга хэмжээг авах үндэслэл бүрд байна. Гэвч хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учирсан эсхүл учирч болзошгүй гэж үзсэн тохиол прокурор, шүүгчийн шийдвэргүйгээр яаралтай нү шилжүүлэх, хамгаалалтад авах боломж хязгаарла байгааг анхаарах нь зүйтэй.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Энэ талаар зохицуулалт байхгүй.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3.1.2 дахь хэсэгт "хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсэн хүнийг, харин Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4.1.1 дэх хэсэгт "гэрч, хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч,

		<p>хохилогчийг ойлгохоор тус тус тусгасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ” гэжээ.</p> <p>Гэвч холбогдох хуульд тусгагдсан нэр томъёо хоорондоо зөрчилдөж байна гэж үзэхэд хүндрэлтэй, учир нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд “хохилогчоор тогтоосон эсэхээс үл хамааран” хохирогч гэж үзэхээр тусгайлан тусгасан байна.</p>
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Зөрчлийг арилгах үүднээс Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Хууль зүйн туслалцааны тухай хууль зэргийг эшлэн заасан байна. Иймд зөрчил үүсэхгүй гэвч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн онцлог, хэрэгцээ шаардлага хангагдах боломж нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар хязгаарлагдаж болзошгүй.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардал байхгүй. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн дагуу бүх төрлийн мэдээлэл хариуцагч хүний хувийн мэдээллийг хамгаалах, зөвшөөрөлтэйгөөр задруулах ашиглах ёстой. Хуулийн төслөөр шүүх, прокурорт уг үүргийг тухайлан хүлээлгэсэн нь давхардсан шинжтэй байж болохоор байгаа ч эсрэгээрээ хохирогчийн мэдээллийг нууцлах үүргийг зөвхөн шүүх, прокурор хүлээж байгаа нь тодорхойгүй. Цагдаагийн болон тагнуулын албан хаагч мөн адил дээрх үүргийг хүлээх нь зүйтэй. Цаашлаад хамгаалах байр болон бусад үйлчилгээг үзүүлэгч этгээд хохирогчид мэдээлэл өгөх, түүний мэдээллийг нууцлах үүрэг хүлээх нь зөв.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Цагдаагийн байгууллага, тагнуул, шүүгч, прокурорын авч хэрэгжүүлэх арга хэмжээг ялгаж тодорхойлсон.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хохирогчийн нөхөн төлбөр авах эрхийг хангахад чиглэсэн зохицуулалт хөндөгдөөгүй байна. Цаашлаад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн онцлог хэрэгцээ, шаардлагад зориулсан тусгай хамгаалах, тусламж, үйлчилгээтэй холбоотой зохицуулалт дутмаг байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Давхардал байхгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх харилцаанд төрийн бус байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч жил ирэх тутам хохирогчдод үйлчилгээ үзүүлэх ТББ-ын тоо нэмэгдэхгүй байна. Төрөөс хохирогчид үзүүлэх үйлчилгээний санхүүжилтийг бусад бизнесийн, худалдан авалтын тендерүүдтэй адилтгаж зарладаг бөгөөд санхүүжилт хангалттай байдаггүй. Иймд улсаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, тусламж,

		үйлчилгээ үзүүлэх хүртээмжийг сайжруулахад чиглэсэн төсөл хөтөлбөрийг боловсруулж, сонгогдсон төрийн бус байгууллагад хангалттай санхүүжилт олгох боломж бий бөгөөд энэ талаар зохицуулалт байхгүй байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Үгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Үгүй.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ХЭҮКтХ-ийн хуулийн нэг зорилго нь ХЭҮК-ын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлох¹³⁵ бөгөөд тус зарчмыг тодорхойлох хүрээнд тус хуулийн 8 дугаар зүйлд Комиссын үйл ажиллагааны зарчмыг тодорхойлохдоо 8.1.4-т “хараат бус бие даасан байх” гэж тодорхойлсон байна. Мөн тус хуулийн нэр томъёоны тайлбарын 3.1.1-т “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллагыг” гэж тодорхойлсон байна.

Харин ХЭҮК-ийн үйл ажиллагаагаа хараат бус, бие даасан зарчмаар хэрэгжүүлэн явуулах гол хүчин зүйл нь хараат бус, бие даасан гишүүн тэдгээрийг томилох хараат бус, бие даасан механизм юм. ХЭҮКтХ-ийн 12 дугаар зүйлд зохицуулсан комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, томилох журмаас үзэхэд хуульд заасан нийтлэг шалгуурыг

¹³⁵ Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль (2020). **1 дүгээр зүйл.** Хуулийн зорилт.

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлж, Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх, дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

хангасан нэр дэвшигчийг нээлттэй үнэлэх, сонгох, шалгаруулах, эцсийн шийдвэрийг УИХ-ын олонхын саналаар гаргах зэрэг нээлттэй, хараат бус, бие даасан байдлыг хангахуйц процедурыг дамжин томилогддог байна.¹³⁶

Харин ХЭҮК-ын даргын нэр дэвшүүлэх, томилох асуудлын хувьд ХЭҮКтХ-ийн 13.4-т зохицуулсан байх бөгөөд тус хуулийн 12 зүйлд заасан дээр дурдсан журмаар томилогдсон гишүүд дотроосоо УИХ-ын дарга санал болгосноор нэг удаа зургаан жилийн хугацаагаар томилох журам үйлчилж байна.¹³⁷ ХЭҮКтХ-д заасан комиссын даргын хэрэгжүүлэх бүрэн эрхээс /эрх, үүрэг/ үзэхэд комиссын дарга нь комиссын үйл ажиллагааг удирдан явуулах, чиглүүлэх зэрэгт чухал үүрэгтэй байх тул ийнхүү комиссын даргын сонгон томилохдоо, комиссын үйл ажиллагааны зарчим буюу бие даасан, хараат бус хараат бус байдлыг хангахуйц журмаар зохицуулах буюу нэгэнт тодорхой журмын дагуу сонгогдсон хараат бус, бие даасан гишүүд дотроосоо, өөрсдийн санал хураалтаар сонгон шалгаруулах нь зүйтэй байна. Учир нь комиссын даргыг томилж буй одоо үйлчилж буй журмаар даргааг шууд УИХ-ын дарга буюу хөндлөнгийн этгээд санал болгож байгаа нь комиссын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлөл үзүүлж болохоор байна.

Иймд тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан ХЭҮКтХ-ийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан ХЭҮК-ын даргыг томилох журмыг “Комиссын даргыг гишүүд дотроосоо олонхын саналаар сонгож санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно” өөрчлөн найруулах нь дээр дурдсан ХЭҮКтХ-ийн хараат бус, бие даасан байх зарчим болон хуулийн зорилгод нийцэж байна.

Комиссын даргын бүрэн эрх

- Комиссыг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;
- Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын даргын хүсэлтээр оролцох;
- Комисст ирсэн гомдол, мэдээллийг шийдвэрлүүлэхээр Комиссын гишүүдэд хуваарилах;
- Комиссын Тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх;
- Комиссын дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;
- Комиссын дотоод үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам баталж мөрдүүлэх;
- Комиссын хуралдааныг товлож, удирдан хуралдуулах;
- Комиссын цахим шуудан болон утсаар гомдол, мэдээлэл хүлээж авах, хариу өгөх журмыг батлах;
- Комиссын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмыг батлах;
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

ХЭҮКтХ-ийн 19 дүгээр зүйлээс

УИХ-аас Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр баталж, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж

¹³⁶ ХЭҮК-ын тухай хууль (2020). 12 дугаар зүйл. Комиссын гишүүнд нэр дэвшүүлэх, томилох

¹³⁷ ХЭҮК-ын тухай хууль (2020). 12 дугаар зүйл 6 дахь хэсэг

мөрдөж эхэлснээр Монгол Улсад хүний эрх хамгаалагчийг хамгаалах үндэсний тогтолцоо бий болсон.¹³⁸

Уг хуулийн 10 дугаар зүйлд ХЭҮК-ын дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороог байгуулахаар зохицуулсан бөгөөд уг хорооны даргыг ХЭҮК-ын “хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн” байхаар 10.2-т мөн зохицуулсан байдаг.¹³⁹

Иймд тус хуульд нийцүүлэн ХЭҮКтХ-д холбогдох нэмэлт зохицуулалт хийж 13.6-д “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2-т заасны дагуу Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнийг Комиссын гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно.” гэж тус хорооны дарга буюу асуудал эрхэлсэн гишүүнийг сонгох журам, үүрэг хэрэгжүүлэх хугацаа зэргийг зохицуулсан байна.

ХЭХЭЗБтХ-ийн дагуу байгуулагдсан хүний эрхийн хамгаалагчийн асуудал эрхэлсэн хороо нь тус хуулийн дагуу дор дурдсан чиг үүргийг гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд тус хуулийн 10.2-т заасны дагуу хорооны бөгөөд Хорооны үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах үүргийг хүлээдэг байна.

Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан хорооны чиг үүрэг

- Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах;
- Гомдол, мэдээллийн талаар нотолгоо, баримт, мэдээлэл цуглуулах;
- Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, энэ хуулийн
- Тус 11.8-д заасан эрсдэлийн үнэлгээ хийх;
- Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн гаргасан дүгнэлтийг Комисст хүргүүлэх;
- Тус хуулийн хэрэгжилт болон хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдалд хяналт шинжилгээ, судалгаа хийж, жил бүр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд тусгуулах;
- Гомдол, мэдээллийн сан бүрдүүлэх.

ХЭХЭЗБтХ-ийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгээс

Гэтэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ХЭҮКтХ-иар ХЭҮК-ийн бүрэн эрхийн хугацаа нь зургаан жил байна гэтэл уг хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн буюу хорооны даргын нэг жил тутам нэг удаа сонгох буюу улиран сонгогдох эрхгүйгээр нэг жилийн бүрэн эрхийн хугацаагаар сонгохоор байна. Иймд бүрэн эрхийн хугацаа нэг жил буюу богино хугацаанд байснаар уг хорооны болон хорооны даргын тогтвортой, үр дүнтэй үйл ажиллагаагаа явуулах байдалд нөлөөлж болзошгүй байна.

¹³⁸ ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл (2023), 433 дахь тал <https://nhrcm.gov.mn/assets/img/58c1302622c8c88d036544f656fdff5d.pdf>

¹³⁹ Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль (2021). 10 дугаар зүйл. Хүний эрх хамгаалагчийн хороо <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16207226850601>

Иймд тус хуулийн төслийн 2 дугаар зүйлийн ХЭҮК-ийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа” гэснийг “олонхын саналаар нууц санал хураалтаар” гэж өөрчлөн хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүн буюу уг хорооны даргын бүрэн эрхийн хугацааны хэт богино хязгаарлалтын халж байгаа нь хууль тогтоомжийн зорилготой зөрчилдөхгүй байгаа боловч уг гишүүний ХЭХЭЗБТХ-д заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх хугацааг нь тодорхой зохицуулаагүй байгаа нь ХЭҮКтХ-ийн “Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлж...түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж ХЭҮКтХ-ийн 1 дүгээр зүйлд заасан зорилгод бүрэн хүрээгүй байна.


ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах хэсгийг сонгож үнэллээ.

Үнэлгээ хийх хэсэг, заалт	
17.1.1.	Цагдаагийн алба хаагчийн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, үндсэн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой сургалтыг мэргэшүүлэх сургалт.
17.1.2.	Цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг дадал, ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтыг ур чадвар хөгжүүлэх сургалт.
17.1.3.	Энэ хуулийн 17.1.1, 17.1.2 т зааснаас бусад сургалтыг албан тушаалын буюу ажлын байрны сургалт.
17.2.	Цагдаагийн албанд анх томилогдох болон албан тушаал дэвших, өөрчлөгдөх тохиолдолд богино болон дунд хугацааны сургалтад хамруулна.
17.3	Энэ хуулийн 17.1.1-д заасан сургалтын хөтөлбөр, агуулга, журмыг Дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд цагдаагийн албаны сургалтын тогтолцоотой холбоотой өөрчлөлт орсон байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Цагдаагийн албаны тухай хуульд сургалтын тогтолцоо бүрэн тодорхойлогдоогүй байсан. Мөн цагдаагийн алба хаагчийн үргэлжилсэн сургалтад мэргэжлийн дээд боловсролын сургалт, мэргэшүүлэх сургалт зэрэг тусдаа бие даасан сургалтын төрлүүдээс гадна ажлын байран дээр зохион байгуулагдсан сургалт буюу албаны сургалт, ажлын байрны сургалт зэрэг ойролцоо сургалтууд багтаж байгаа нь сургалтын тогтолцооны замбараагүй байдлыг үүсгэж байгаа ба ЦБҮАЖ код 118-д сургалтын 3 төрлийг ангилахдаа "ажлын байран дээрх албаны сургалт" гэж томъёолсон боловч тус журмын 118.7.13-т тухайн төрлийн сургалтыг тодорхойлохдоо "ажлын байран дахь албаны сургалт" гэж өөрөөр томъёолсон, давтан, мэргэшүүлэх ба ур чадварын, чадавхжуулах зэрэг олон төрлийн ойлгомжгүй сургалтууд явагдаж ирсэн зэргээс үзэхэд цагдаагийн байгууллагын сургалтын тогтолцоо тогтолцоо биш төөрөгдөл байсан гэж хэлж болохоор байгаа юм. Учир нь Монгол Улс Цагдаагийн албаны сургалтын тогтолцоогоо хуулиар биш журмаар зохицуулснаас хуульд тусгагдаагүй шинэ төрлийн сургалтууд хүртэл сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагддаг болсон нь сургалтын тогтолцооны замбараагүй байдлыг бий болгосон.



Харин энэхүү хуулийн төслөөр цагдаагийн албаны сургалтын тогтолцоог хуулиар шинэчлэн хуульчилж оруулж ирж байгаа нь цагдаагийн албаны сургалтын тогтолцоог цаашид хэлбэржихэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж харж байна.

Төсөлд тусгагдсан сургалтын төрлүүдийг авч үзвэл цагдаагийн албаны сургалт нь:

- мэргэшүүлэх,
- ур чадвар хөгжүүлэх,
- албан тушаалын буюу ажлын байрны гэсэн 3 төрлийн сургалт байхаар зохицуулсан байна.


Ур чадвар хөгжүүлэх сургалт нь “Цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг дадал, ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтыг ур чадвар хөгжүүлэх сургалт”-ыг хэлэхээр заажээ. Европын зарим орнууд болон АНУ, Канад зэрэг орны цагдаагийн боловсролын сургалт явуулдаг академи, сургалтын байгууллагуудыг судалж үзвэл: одоо ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчдад зориулсан боловсрол/сургалт буюу анхан шатны сургалт/боловсролын дараа үүрэг гүйцэтгэгч цагдаагийн алба хаагчдыг үйл ажиллагааны ур чадварыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн өөрчлөлтийн дагуу мэдлэгийг шинэчлэх, тодорхой нөхцөл байдал, алба хаагчдын хэрэгцээ шаардлагыг үндэслэсэн сургалтыг үргэлжилсэн сургалт (Continuing education/training) гэдэг. Цагдаагийн сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг академи, сургуулиуд үргэлжилсэн сургалтаараа галт зэвсэг, кибер гэмт хэрэг, хүүхдийн эрхийг хамгаалах, хохирогчтой харьцах зэрэг тусгай тусгай сургалтуудыг ордог байна.¹⁴⁰ Эдгээрээс үзэхэд хуулийн төслийн ур чадвар хөгжүүлэх сургалт нь уг үргэлжилсэн сургалттай утга таарч байна гэж харж байна. Иймд энэхүү сургалт нь практикт хэрэгжих бүрэн боломжтой юм.

Харин мэргэшүүлэх сургалт гэдгийг “Цагдаагийн алба хаагчийн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, үндсэн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой сургалтыг” гэж тодорхойлсон нь өмнөх тодорхойлолттой харьцуулахад хэт ерөнхий бөгөөд яг ямар онцлогтой, ямар чиглэлийн сургалт болох нь тодорхойгүй байна.

Мөн 3 дахь сургалт буюу “албан тушаалын буюу ажлын байрны сургалт” гэсэн нь мэргэшүүлэх болон ур чадвар хөгжүүлэх сургалтаас бусад бүх сургалтыг хамруулах өргөн агуулгатай сургалт хэрнээ нэг сургалтын нэрийг өөр байдлаар дахин давтаж “буюу” холбоосоор холбож тусгасан нь ойлгомжгүй, тодорхойгүй байдлыг бий болгож магадгүй юм. Мөн энэ нь хууль тогтоомжийн хэмнэлтийн зарчмыг алдагдуулж байна гэж харж байна. Иймээс 17.1.1, 17.1.2 т зааснаас бусад сургалтыг албан тушаалын буюу ажлын байрны сургалт гэхгүйгээр оновчтой нэрлэж, тодорхойлох шаардлагатай гэж дүгнэлээ.

Түүнчлэн, төслийн 17.2 дахь хэсэгт цагдаагийн албанд анх томилогдох болон албан тушаал дэвших, өөрчлөгдөх тохиолдолд *богино болон дунд хугацааны сургалтад* хамруулахаар тусгажээ. Сургалтын тогтолцоог тодорхойлохдоо ямар ч

¹⁴⁰ Police education and training systems in the OSCE region, 2018, p.27, <https://www.osce.org/files/f/documents/f/7/423401.pdf>



хугацаатай холбоотой заалт тусгаагүй атал гэнэт хугацаагаар ондоошсон сургалтууд гарч ирж байгаа нь сургалтын тогтолцоог эвдэхэд хүрч болзошгүй гэж үзэж байна.

Хуулийн төслийн 17.3-т одоогийн хуулийн 17.2-т заасан “Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.” гэснийг Засгийн газрын гишүүн батлахаар болгож сургалтын төрлүүдийг өөрчлөн найруулсан байна. Үүнд зааснаар цагдаагийн албаны сургалтын хөтөлбөр, агуулга, журам гэж 3 тусдаа зүйл батлагдахаар байна. Гэтэл хөтөлбөр гэдэг нь өөрөө сургалтын агуулгыг багтаасан ойлголт байдаг тул өмнөх практикт сургалтын агуулга гэж тусдаа батлагддаггүй байсан. Иймээс агуулгыг хөтөлбөрт нэгтгэх шаардлагатай юм.

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

- a) 1 дүгээр зүйлд “Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн дор дурдсан дор дурдсанаар өөрчөн найруулсугай.” гэжээ. Хуулийн төсөлд дараах техникийн алдаа гарсан байна. Үүнд:
 - ✓ “17 дугаар зүйлийн” өөрчлөнө гэж утгагүй зохицуулалт болж байгаа тул “17 дугаар зүйлийг” гэх;
 - ✓ “дор дурдсан дор дурдсанаар” гэж давхар бичсэнийг засах;
 - ✓ “өөрчөн” гэснийг “өөрчлөн” болгож өөрчлөх
- b) 1 дүгээр зүйлийн 17.4-т “ур чадвэр хөгжүүлэх” гэж алдаатай бичсэн байх тул “чадвар” болгох;
- c) 17.1.1 дэх заалтын урд талын зайг бусад мөртэй ижилтгэх.


ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.5 дахь хэсэгт дараах нэмэлтийг оруулахаар тусгажээ.

- Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх эмнэлгийн байгууллага нь харуул хамгаалалтын нэгж, харуул хамгаалалтын ажилтантай байна.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.10 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж тусгасан. Үүний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А-240/А/369 дугаар тушаалаар “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан. Тус журамд зааснаар “Албадан эмчлүүлэгчийн зүгээс гарч болзошгүй хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын болон харуул хамгаалалтын арга хэмжээг тус журмын 1.4-т тусгагдсан байгууллагууд хамтран авч хэрэгжүүлсэн байна” гэж тусгасан ба “Харуул хамгаалалтын ажилтан нь албадан эмчлүүлэгчийн хяналтын хувийн хэргийг хөтлөн, эргэлт уулзалтын бүртгэл, гаргасан зөрчил, эмчилгээнд гадагшаа авч явсан тухай, тусгай хэрэгсэл хэрэглэсэн тухай, усанд орсон ба нар, салхинд гаргасан тухай тэмдэглэлийг хөтөлж хавсаргана.” гэж үүргийг



тодорхойлсон. Мөн тус журмын 5 дугаар бүлэгт зааснаар харуул, хамгаалалтын зохион байгуулалтыг дараах байдлаар хэрэгжүүлэхээр байна.


- Хамгаалалтын нэг ээлжид 3-аас доошгүй хамгаалалтын ажилтан үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулна.

- Албадан эмчлүүлэгсдийн өрөө, коридор, шатны хонгил зэрэг газруудад телекамер байрлуулж, эмнэлгийг бүхэлд нь хянах боломжтойгоор зохион байгуулна. Гадна болон дотор хамгаалалтад орчин үеийн хяналт, хамгаалалтын техник хэрэгсэл ашиглаж болно.

- Хамгаалалтын ажилтан нэг бүрийг тусгай хэрэгслээр хангаж, хяналтын цэгт холбооны иж бүрэн хэрэгсэл, теле хяналтын дэлгэцийг байршуулна.

- Хамгаалалтын ажилтан нь албадан эмчлэх эмнэлэгт сэтгэцийн байдал тогтоолгохоор болон эмчлүүлэхээр ирсэн этгээдийг хүлээн авах үед болон өдөр тутмын хамгаалалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах эрх, үүрэгтэй байна.

- шүүхийн шийтгэх тогтоол, шинжээч томилох тогтоол, холбогдох бусад баримт бичиг нь эмчлүүлэгчийн овог, нэр, регистрийн дугаар, фото зурагтай тохирч буй эсэхийг тулган шалгах;
- эмчлүүлэгчийн биед үзлэг хийж, илэрсэн гэмтэл, шарх, сорви, онцлог содон тэмдэг /"шивээс, мэнгэ" гэх мэт/ зэргийг дэлгэрэнгүй тэмдэглэж авах;
- эмчлүүлэгчийн өмссөн хувцас, авч яваа бусад эд зүйлд үзлэг хийж, эмнэлэгт нэвтрүүлэхийг хориглосон эд зүйлсийг хураан авч гэр бүл, төрөл садангийн хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон өвчтөнийг хүргэж ирсэн албан тушаалтанд хүлээлгэн өгч, энэ тухай тэмдэглэл үйлдэн, байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулж баталгаажуулах;
- эмнэлгийн захиргаа болон эрхлэгч эмчийн зөвшөөрөлгүйгээр хяналт тавьж буй прокурор, эмнэлгийн ажилчдаас бусад гадны хүнийг албадан эмчлэх эмнэлгийн байранд нэвтрүүлэхгүй байх;
- эмчлүүлэгч өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй үйлдэл хийсэн болон хийхээр завдсан, эмчилгээ хийлгэхээс татгалзсан тохиолдолд үзүүлж буй эсэргүүцлийн шинж, тухайн нөхцөл байдлаас шалтгаалан тусгай хэрэгсэл /резинэн бороохой, гав, нулимс асгаруулагч хий, хүлэг, ороох цамц, зөөлөн даруулга/-ийг холбогдох хууль, журамд заасны дагуу хэрэглэж, энэ тухай тэмдэглэл үйлдэж, харуул хамгаалалтын хэсгийн даргад танилцуулна. Харуул хамгаалалтын хэсгийн дарга нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд энэ тухай мэдэгдэнэ.
- албадан эмчлэх эмнэлэгт нэвтрэх, гадагш гарах иргэдийн биеийн байцаалт, зөвшөөрлийн хуудсыг шалгаж, шаардлагатай тохиолдолд биед үзлэг хийх;
- эмчлүүлэгчийг баталсан хуваарийн дагуу эмнэлгийн гадна орчин /эмнэлгийн хашаан дотор/-д харуул хамгаалалтын ажилтан, асрагчийн хяналт дор салхилуулах үед хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, хянан харгалзах;
- хамгаалалтын ажилтан нь эмчлүүлэгч амиа хорлох, биедээ гэмтэл учруулах үйлдэл хийхийг завдах, өөр хоорондоо болон эмч, сувилагч, асрагчтай маргалдах, зодолдох, үймээн дэгдээх зэргийг таслан зогсоох арга хэмжээ авах;



- холбогдох хууль, дүрэм, журмын сурталчилгааг батлагдсан хуваарийн дагуу эмчлүүлэгчдийн дунд явуулах;

- Хамгаалалтын ажилтан нь ээлж хүлээлцэх бүрд эмчлүүлэгчийн бие, өрөө тасалгаа, ор, шүүгээ болон бусад хувийн эд зүйлсэд сувилагч, асрагч нарын хамт үзлэг хийж, хориглосон эд зүйлс илэрвэл хураан авч устгах ба энэ тухай тэмдэглэл хөтөлнө.

- Эмчлүүлэгчдээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэргийн газрыг хамгаалалтад авч, нэн даруй Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэнэ.

- Эмчлүүлэгч оргосон тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын шуурхай эргүүл, харьяалах нутаг дэвсгэрийн цагдаагийн хэлтэс, эмнэлгийн захиргаанд тус тус мэдэгдэж эрэн сурвалжлах ажилд тухайн өдрийн ээлжинд үүрэг гүйцэтгэж буй эмнэлгийн алба хаагчидтай хамтран ажиллана¹⁴¹.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2012-2021 оны хооронд буюу 10 жилийн хугацаанд гэмт хэрэг үйлдсэн 144 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн бөгөөд дээрх хэрэг хариуцах чадваргүй хүний дийлэнх нь шизофрени, шизофренийн хэв шинжит ба дэмийрэх эмгэг өвчтэй байсан ба хий үзэгдэл, дэмийрэл, сэтгэл хөөрөл, гутрал, эмгэг төрх төст шинж, хам шинж илрэн гардгийн улмаас нийгэмд аюултай үйлдэл хийсэн байна¹⁴².


Өнөөгийн байдлаар 2018 оноос хойш тус клиникт 99 хүн хэвтэж эмчлүүлснээс практикт багагүй асуудал тулгарсаар байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх явцад эмчлүүлж буй этгээдээс халдан довтлох (2023 оны эхний хагас жилийн байдлаар 5 тохиолдол гарсан), эмчилгээний байгууллагын орчин нөхцөл, стандарт, хүний нөөцийн болон эмчлүүлж буй этгээдийн халамжийн үйлчилгээтэй холбоотой олон асуудал тулгамдаж байна.

Шүүхээс 2012-2022 оны хооронд гэмт хэрэг үйлдсэн 144 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн нь нийт ял оногдуулсан хүнтэй харьцуулахад 0.14 хувийг эзэлж байна.

¹⁴¹ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А-240/А/369 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”, <https://www.ncs.cd.gov.mn/wp-content/uploads/2020/02/20170921a240a369.pdf>

¹⁴² Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв. Статистик үзүүлэлт. УБ, 2018-2022, 9 дэх тал.

Шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн байдал




Хууль зүй, дотоод хэргийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/98, А/131 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр тус төвийн Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникийн харуул хамгаалалтын ажлыг хүлээлцэж, цаашид ШШГЕГ-ын харьяа Баривчлах төв тус клиникт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх харуул хамгаалалтыг хэрэгжүүлэн ажиллахаар болсон.

Ингэснээр 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс урд үүрэг гүйцэтгэж байсан Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг дагалдуулан 24/48 цагийн хугацаатай Шүүхийн шийдвэрийн харуул хамгаалалтын 4 албан хаагчийг дадлагажуулан нийт 27- 30 албадан эмчлүүлэгчдэд хяналт тавин 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл ажиллуулан, тухайн өдрөөс бие даан харуул хамгаалалтыг хариуцан гүйцэтгэж иржээ¹⁴³.

Хамгаалалтын ажилтны бие хамгаалах тусгай хэрэгсэл дутмаг байгаа төдийгүй сэтгэцийн эмгэгтэй өвчтөний зүгээс өөрийг бие махбод болон бусдад үзүүлэх эрсдэл өндөр байна. Зөвхөн 2023 он гарснаас хойш өвчтөний зүгээс хамгаалалтын ажилтанд халдсан дараах тохиолдол гарчээ.

- 2023 оны 06 дугаар сар эмчлүүлэгч Д.Ж /эмэгтэй/ нь эмчлүүлэгч Д.Б намайг байнга гутаан доромжил муухай үнэртэж байна гэж хэлсэн гэх шалтгаанаар үснээс нь зулгааж хоорондоо зодолдсон бөгөөд таслан зогсоох гэсэн хамгаалалтын ажилтан, сувилагчийг эсэргүүцэж алба хаагчдын пост руу хүч хэрэглэж нэвтэрсэн;

¹⁴³ Мянганбаяр Ц. “СЭМҮТ-ийн албадан эмчлүүлэгчдэд харуул хамгаалалтын хяналт тавихад тулгамдаж буй асуудал” сэдэвт илтгэл. Гэмт явдалтай тэмцэх асуудал. УБ,2021, 84 дэх тал.



- 2023 оны 03 дугаар сар эмчлүүлэгч Г.Х /эрэгтэй/ өрөөндөө байхдаа уур хүрээд байсан гэх шалтгаанаар бугуйн гаваар эмчлүүлэгч М.У-гийн нуруун тус газарт нь цохисон ба гавыг нь тайлах бүрд хүч түрэмгийлсэн үйлдэл байнга гаргадаг;

- 2023 оны 03 дугаар сар эмчлүүлэгч Г.Г /эрэгтэй/ шалтгаангүй уцаарлаж эмчлүүлэгч М.У-гийн мөрнөөс хазсан. Хамгаалалтын ажилтан эмчлүүлэгчдэд номхотгох арга хэмжээ хэрэглэх явцад чи намайг уядаг хэн бэ гэж баруун гараас нь хазаж гэмтээсэн;

- 2023 оны 09 дүгээр сар эмчлүүлэгч М.А нь эмчлүүлэгч Ү.Н -ийг үл ялих зүйлээр шалтаглан нүүрэн тус газар цохисон, шаардлага тавьсан хамгаалалтын ажилтныг эсэргүүцсэн;

- 2023 оны 11 дүгээр сар эмчлүүлэгч Г тамхи өгөхгүй байна гэх шалтгаанаар гарын гавыг эвдэж хамгаалалтын ажилтан руу халуун цай цацсан.

Сэтгэцийн клиникийн эмнэлэг нь аюулгүй байдлыг хангах чиглэлээр тоноглогдоогүй, хамгаалалтын алба хаагчийн хүрэлцээ, тусгай хэрэгслийн хүртээмж муу зэрэг нь цаашид сөрөг үр дагавар гарч болзошгүй байна.

Түүнчлэн тус сэтгэцийн клиникт 24 цагаар үүрэг гүйцэтгэж буй алба хаагч хаалттай хорих ангийн алба хаагчаас бага нээлттэй, баривчлах байр, ерөнхий газарт ажиллаж буй алба хаагчтай адил цалин хангамж авч байгаад анхаарах шаардлага байна.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэгдсэн хүнд сэтгэцийн албадан эмчилгээ хийгдэж байх хугацаанд харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах алба хаагчийн нөөцийг бүрдүүлэх, сурган бэлтгэх, томилон ажиллуулахад анхаарах шаардлага, хэрэгцээ тулгамдсан асуудлын нэг байна. Учир нь энэхүү объектод үүрэг гүйцэтгэж буй алба хаагч өмнө нь тус байгууллагын талаарх ойлголт, мэдээлэл дутмаг, сэтгэл зүйн бэлтгэл хангагдаагүй, зохих ажлын туршлага хуримтлуулж амжаагүй байх үед шууд томилогдон ажилласан байна. Нөгөөтээгүүр томилогдсон алба хаагчийн зүгээс ажлын байрны стрессээ тайлах аргад суралцаагүй, ажлын ачаалал тэнцвэржүүлэх буюу зохицуулж чадаагүйгээс шалтгаалан ажлаас халшрах, цаашлаад ажлаас гарах тохиолдол өндөр байдаг байна.

2023 оны 10 дугаар сарын байдлаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний өвийн Шүүх сэтгэц эмгэг судлалын клиникт эмчлүүлж буй 38 хүний аюулгүй байдал, аруул хамгаалалт, хяналтыг 24 цагийн хугацаатай тавин ажиллаж буй хамгаалалтын ажилтнууд нь 20-24 насны 2 сараас 3 жил хүртэл ажилласан алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаа нь хүний нөөцийн хувьд анхаарлаа хандуулах асуудлын нэг гэж үзсэн.

Судлаачдын зөвлөснөөр сэтгэцийн эмгэг судлалын клиникт томилогдон ажиллах алба хаагчийн зан байдлын тодорхой идэвхжүүлэлтэд захиргааны зүгээс тулгуурлах бөгөөд хамгаалалтын ажилтны тогтвортой ажиллах хөдөлмөрийн үйл ажиллагаа болон сахилга бат, зайлшгүй болохыг ухамсарлуулан дэмжлэг үзүүлэх, үүргийн мэдрэмж, заавал биелүүлэх ёстой хууль, эрхийн акт, гүйцэтгэлийн хяналт, шалгалтын тусламжтайгаар ажилтанд шууд урамшууллын болон нийгмийн хамгаалал, эдийн

засгийн, бусад нөлөөлөл үзүүлэхэд алба хаагчийн урам зориг нэмэгдэж, тогтвортой ажиллахад нөхцөл бүрдэнэ¹⁴⁴.


Дээрхээс дүгнэвэл, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын дагуу харуул хамгаалалтын ажилтан ажиллаж байгаа бөгөөд тус практик нэгэнт тогтсон байна. Гэхдээ харуул хамгаалалтын ажилтны хөдөлмөрийн, эдийн засгийн болон нийгмийн хамгааллын баталгааг хангах шаардлага бий болоод байна. Тус хуулийн төслөөр харуул хамгаалалтын нэгж, харуул хамгаалалтын ажилтантай байх талаар хуульчилж өгсөн нь тухайн ажилтны эрх зүйн баталгааг хангаж буй хэрэг учраас ач холбогдолтой байна. Цаашлаад хөдөлмөрийн, эдийн засгийн болон нийгмийн хамгааллын баталгааг хангах талаар зохицуулалтыг тус хуулийн төсөлд эсвэл холбогдох журамд оруулж тусгах нь зүйтэй. Мөн харуул хамгаалалтын нэгжийг шинээр хуульчилж буй учир тус хуулийн төсөлд эсвэл холбогдох журамд зохион байгуулалтын талаар зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсэгт “Төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах тухай нэхэмжлэлийг шүүх хангасан бол энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж төлбөрийг барагдуулна.” гэж өөрчлөлт оруулахаар тусгажээ. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалттай харьцуулж авч үзвэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
Төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах эсэх асуудлыг үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгийн хариуцлагын харилцааг зохицуулсан хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ.	Төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах тухай нэхэмжлэлийг шүүх хангасан бол энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж төлбөрийг барагдуулна.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2017-2021 оны 05 дугаар сар хүртэл нийт 96265 гүйцэтгэх хуудасны 6.668.097.344.1 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 21546 гүйцэтгэх хуудасны 3.376.632.975.8 төгрөгийн төлбөрөөс 9089 гүйцэтгэх хуудасны 677.797.873.1 төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ. Үүнийг он тус бүрээр ангилбал:

¹⁴⁴ Дотоод хэргийн их сургууль, “Гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй хүнд оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилт” Судалгааны тайлан, <https://sudalгаа.gov.mn/gemt-khereg-yldsen-setgetsijn-emgegtey-khnd-onogduulsan-emnelgiyn-chan-gu8>



- 2017 онд нийт 18921 гүйцэтгэх хуудасны 946.705.526.4 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 4563 гүйцэтгэх хуудасны 473.370.092.5 төгрөгийн төлбөрөөс тус онд 2069 гүйцэтгэх хуудасны 148.551.946.5 төгрөг;

- 2018 онд нийт 19224 гүйцэтгэх хуудасны 1.354.149.233.0 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 4603 гүйцэтгэх хуудасны 823.622.505.7 төгрөгийн төлбөрөөс тус онд 2250 гүйцэтгэх хуудасны 223.008.357.8 төгрөг;

- 2019 онд нийт 24331 гүйцэтгэх хуудасны 1.876.772.028.8 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 4478 гүйцэтгэх хуудасны 615.867.099.3 төгрөгийн төлбөрөөс тус онд 2291 гүйцэтгэх хуудасны 99.838.444.9 төгрөг;

- 2020 онд нийт 19043 гүйцэтгэх хуудасны 1.292.321.670.4 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 4493 гүйцэтгэх хуудасны 639.691.734.3 төгрөгийн төлбөрөөс тус онд 2001 гүйцэтгэх хуудасны 149.397.157.4 төгрөг;

- 2021 оны 05 дугаар сарын байдлаар нийт 14746 гүйцэтгэх хуудасны 1.198.148.885.5 төгрөгийн дүн бүхий гүйцэтгэх хуудаснаас хуулийн этгээдэд холбогдох 3409 гүйцэтгэх хуудасны 824.081.544.0 төгрөгийн төлбөрөөс тус онд 478 гүйцэтгэх хуудасны 57.001.966.5 төгрөгийн төлбөрийг тус тус барагдуулжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, түүнийг боловсронгуй болгох арга замыг тодруулах зорилгоор нийт 188 шийдвэр гүйцэтгэгчээс цахимаар санал авахад дараахь хариултыг өгсөн.

Нэг. “Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтад өгөх таны үнэлгээ” гэдэг асуултад хангалттай гэж 6 хувь буюу 10, сайжруулах шаардлагатай гэж 94 хувь буюу 170 шийдвэр гүйцэтгэгч хариулжээ.


Хоёр. “Төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг сайжруулах асуудалд хамаарах хэсгийг тодорхойлно уу” гэсэн асуултад “мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах” гэж 11% буюу 19 шийдвэр гүйцэтгэгч, эд хөрөнгийг хураан авах, худалдан борлуулах, төлбөрт суутгахад гэж 22% буюу 37 шийдвэр гүйцэтгэгч, бусдын эзэмшилд байгаа мөнгөн болон бусад хөрөнгөөс төлбөр гаргуулахад гэж 48% буюу 80 шийдвэр гүйцэтгэгч, өөрчлөн зохион байгуулагдах үед төлбөр гаргуулахад гэж 17% буюу 28 шийдвэр гүйцэтгэгч, үйл ажиллагаа дуусгавар болох үед төлбөр гаргуулах үед гэж 2% буюу 3 шийдвэр гүйцэтгэгч хариулжээ.

Гурав. Төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах тулгамдаж буй асуудлын талаарх санал асуулгад давхардсан тоогоор 120 гаруй санал ирснээс бүлэглэн авч үзвэл:

1. үйл ажиллагаа явуулахгүй байгаа хуулийн этгээдээс төлбөр гаргуулахад хүндрэлтэй байдаг;

2. хуулийн этгээд төлбөрийн чадваргүй бол үүсгэн байгуулагч нарын хөрөнгө зааглагдсан эсэхийг тодруулах гэж хугацаа алддаг;

3. шийдвэр гүйцэтгэх явцад шүүхэд хандаж ажиллагааг зогсоодог;



4. хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн банкин дахь харилцах данснаас суутгал хийхэд төлбөр төлөгч этгээд бус гэсэн үндэслэлээр хасалт хийдэггүй. Компанийн данс хаалттай үед үүсгэн байгуулагч хувьцаа эзэмшигч дансаараа компанийн гүйлгээг хийж байна;

5. төлбөр төлөгч хуулийн этгээдийн хаяг тодорхойгүй;

6. төрийн байгууллагаас төлбөр гаргуулахад төсөв байхгүй төсвийн тодотголд дараа жил суулгаж өгнө гэх тайлбар өгдөг зэрэг нийтлэг асуудлуудыг гаргасан.

ДХИС-ийн “Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв”-өөс хийсэн “Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” судалгааны тайланд хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг боловсронгуй болгох дараах арга замыг тодорхой болгосон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар компанийн хувьцаа эзэмшигчээс 4 нөхцөлөөр төлбөрийг гаргуулж байна. Үүнд:

1. Компанийн хувьцааг 100 хувь эзэмшигч буюу үүсгэн байгуулагчаас нь төлбөр гаргуулах;

2. Компани өөрийн хөрөнгөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр төлбөр гаргуулах;

3. Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй үндэслэлээр;


4. Компанийн хувьцаа эзэмшигч компанийн хөрөнгийг өөртөө шилжүүлсэн, нуун дарагдуулсан гэсэн үндэслэлээр тус тус төлбөр гаргуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93.4-т “төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах эсэх асуудлыг үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгийн хариуцлагын харилцааг зохицуулсан хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ” гэж заажээ. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах ажиллагааг гүйцэтгэхдээ дараах үе шатыг дамжин хийх ёстой:

а. Тухайн хуулийн этгээдийг төлбөрийн бүрэн чадамжгүй болохыг бүрэн нотолсон байх;

б. Хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах ажиллагааг хийх;

Компанийн тухай хуулийн 9.3-т “хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ” гэж заасан нь энэ хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчмыг заасан зохицуулалт байдаг. Энэ нь компанийн өрийг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх ба хувьцаа эзэмшигчийн хөрөнгөөр гүйцэтгэх боломжгүй юм. Компанийн тухай хуулийн 9.5-т “хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна” гэж заасан.



Эндээс компанид оруулсан эд хөрөнгийг хувийн эд хөрөнгөнөөс зааглагдаагүй гэдгийг тогтоох арга нь:

1.Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчийн үүргийг тодорхойлсон байдаг.

2.Хөрөнгийн бодит шилжилтээр тогтоох ёстой, үүнд хувьцаа эзэмшигч компанид оруулсан хөрөнгөө компанийн нягтлан бодох бүртгэлд тусгасан эсэх, оруулсны дараа өөрийн хувийн хөрөнгө рүү шилжүүлээгүй байх, ноогдол ашгаас бусдаар өөртэй шилжүүлэн авах, компанийн ашиг, орлогыг хувийн дансандаа шилжүүлсэн байвал хувийн эд хөрөнгөнөөс зааглагдаагүй гэх үндэслэл болно. Компанийн хувьцаа эзэмшигч компанийн эд хөрөнгөөс хувийн эд хөрөнгөнөөс зааглаагүй тохиолдолд өөрийн хувийн эд хөрөнгөнөөс бүрэн хариуцлага хүлээнэ. Шийдвэр гүйцэтгэгч зааглагдаагүй эд хөрөнгийг тогтоох үүргийг хүлээн төлбөрийг гаргуулах нь зүйтэй юм. Энэ үүргийг гүйцэтгэхэд санхүү, нягтлан бодох бүртгэл, мөрдөн шалгах ажиллагааны тусгай мэдлэг шаардлагатай юм¹⁴⁵.

Дээрхээс дүгнэвэл, хуулийн этгээдэд холбогдох мөнгөн төлбөрийн үүргийг 70 хувьтай гүйцэтгэдэг болох нь тодорхойлогдож байна. Мөн төлбөрийг гаргуулах шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухайд хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах тал дээр асуудал үүсэж байна. Үүнийг шийдвэрлэх сайн туршлагын тухайд санхүү, нягтлан бодох бүртгэл, мөрдөн шалгах ажиллагааны тусгай мэдлэг шаардлагатай болохыг тухайлан авч үзсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай тус хуулийн төсөлд тухайн асуудлыг шүүх нэхэмжлэлийг хангасан тохиолдолд гэж илүү мэргэшсэн хяналттай субъектэд хариуцуулж байгаа нь үр дүнтэй, практикт нийцсэн байна.


“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай тус хуулийн төсөлд 190 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 190.9, 190.10 дахь хэсгийн “Эмнэлгийн чанартай албадлагын” гэснийг “Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх” гэж, мөн зүйлийн 190.4, 190.5, 190.6, 190.7, 190.8 дахь хэсгийн “эмнэлгийн чанартай албадлагын” гэснийг “сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх” гэж тус тус өөрчлөхөөр зохицуулжээ. Энэ нь тус хуулийн төсөлтэй зэрэг боловсруулагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гарч буй өөрчлөлт юм.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ”-г “албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ” гэж өөрчлөөд үүнд хамгаалах зорилгоор тусгаарлан эмчлэх, сэтгэцийн эмгэг судлаачийн хяналтад эмчлэх, донтох зуршлын эсрэг эмчилгээ, сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх арга хэмжээ авахаар тусгажээ.

Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай тус хуулийн төсөлд дээрх нэр томъёог шинэчлэн зохицуулахдаа Эрүүгийн хууль дээр тус өөрчлөлт орох нь зүйтэй эсэхэд үндэслэн шийдвэрлэх шаардлагатай.

¹⁴⁵ Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв, “Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт”, УБ, 2021, 139-141 дэх тал.



Мөн түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дугаар зүйл нь бүхэлдээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг зохицуулалт хэм хэмжээ байхад үүнийг ганцхан сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх арга хэмжээнд хамааруулан зохицуулж байгаа нь эрх зүйн хийдэл үүсгэх магадлалтай. Тийм учраас хуулийн төслийн тус зохицуулалтыг анхаарч авч үзэх хэрэгтэй.

ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Тус судалгааны хүрээнд “Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийн зохицуулалт, агуулга нь нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилгод нийцэж буй эсэх, зохион байгуулалтыг өөрчилж буй зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, шинээр тусгагдсан зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, хуулийн төсөл нь хууль зүйн техникийн хувьд алдаатай эсэхэд дүн шинжилгээ хийсэн бөгөөд дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:


Хуулийн төслөөр иргэний мэдээлэл авах эрхийг хангах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд мэдээлэл ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлах шаардлагаар Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг УИХ-д тайлагнах, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсгийн аж ахуй нэгж, байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг уг хуулийн 12.5 дахь хэсэгт заасан журмын дагуу мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх үүргийг хүлээхээс гадна дээрх тайлан мэдээг олон нийтэд заавал мэдээлж байх үүргийг тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгод нийцжээ. Мөн хуулийн төсөл нь бусад хууль, тогтоомжтой харилцан уялдаатай байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Хуулийн төслийн зохицуулалтууд нь үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгод болон бусад хууль, тогтоомж, олон улсын гэрээ, конвенцийн зорилгод нийцсэн байна. Төсөлд нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хэрхэн хангах талаар тусгажээ. Энэ нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан журмаар зохицуулж буй хохирогчид аюулын зэргийн үнэлгээ хийхтэй холбогдсон харилцаа, нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд цагдаагийн байгууллага хяналт тавихтай холбогдсон зохицуулалтыг хуульд тусгаж захиргааны хэм хэмжээний актын тоог бууруулах, тухайн асуудлыг хуулиар шийдвэрлэхэд чиглэсэн зохицуулалт болжээ.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Хуулийн төслийн зохицуулалтад төрийн алба хаагч, төрийн бус байгууллагын алба хаагч зэргээр хэрэглэгдэх оновчгүй нэр томьёо ашигласан байх тул хууль тогтоомжийг боловсронгуй болгох хуулийн төслийн зорилгод нийцээгүй байна гэж дүгнэх боломжтой. Иймд нийтлэг байдлаар илэрхийлэх үүднээс алба хаагч бус ажилтан, албан хаагч зэрэг тохирох хэлбэрээр тусгах нь зүйтэй. Мөн нууцын баталгааг ямар хэлбэрээр гаргах нь хуулийн төсөлд тусгагдаагүй байх тул нууцын баталгааг гаргах хэлбэр, журмыг хуульчилснаар практикт хэрэгжилтэд асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх юм. Түүнчлэн “Биечилсэн хамгаалалтын арга хэмжээг биечлэн гүйцэтгэнэ.” гэж бичигдсэн байх бөгөөд төсөлд биечлэн хамгаалалтыг тайлбарлаагүйгээс ойлгомжгүй байдлыг



үүсгэсэн, “улсын төсвөөс санхүүжнэ” гэсэн ерөнхий зохицуулалтыг нарийвчлан зохицуулаагүй зэргийг анхаарч үзэн хуулийн төслийн бусад зохицуулалтын ойлгомжтой, харилцан уялдаатай байдлыг хангах шаардлагатай.

Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:


Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.5.8 дахь хэсэг хэт ерөнхий байгаагаас хүний эрх өргөнөөр хязгаарлагдах эрсдэлийг бий болгож байгаа тул түүнийг хүчингүй болгох нь боломжит хувилбар боловч нөгөө талаас дайчилгааг зарласан тохиолдолд хууль зүйн үндэслэлгүйгээр эсхүл журмаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл эсхүл цахим орчинд хяналт тогтоох эрсдэл үүсэж болзошгүйг мөн анхаарах нь зүйтэй.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээний талаар зохицуулалтыг 5 зүйл болгон тусгасан бөгөөд эдгээр нь одоогийн Эрүүгийн хуулийн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг нарийвчлан зохицуулсан зохицуулалт юм. Хуулийн төслөөр албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг хэрэглэх, түүний төрөл, өөрчлөх зогсоох, хугацааг тооцох асуудлыг нэлээд нарийвчлан тусгасан бөгөөд тэдгээрээс сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх албадлагын арга хэмжээ нь ердийн болон тусгай тасагтай байхаар тусгажээ. Энэ нь одоогийн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгон, тус албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэлийг тодорхой байдлаар зохицуулжээ. Иймд тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Гэхдээ төслийн албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтуудыг цаашид ч илүү боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байгааг дурдах нь зүйтэй. Мөн нэр томъёоны хувьд Эрүүгийн хуульд албадлагын арга хэмжээ гэх ойлголт хуульчлагдсан бөгөөд төсөлд албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ, сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх албадлагын арга хэмжээ, сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ гэж ялгамжтай байдлаар тусгасан байгааг анхаарах нь зүйтэй.

Хуулийн төслийн зохицуулалтаас үзвэл Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийг илүү нарийвчлан тусгасан бөгөөд “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ийн хэрэгжилттэй холбогдуулан НҮБ-ийн Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын тайланд өгсөн зөвлөмжид “Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг конвенцийн 1 дүгээр зүйлд заасан “аливаа байдлаар алагчилж, эсхүл айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор эрүүдэн шүүх, мөн гуравдагч этгээдэд хамааралтай байх гэсэнтэй бүрэн нийцүүлэн тодорхойлох гэсэн зөвлөмжид нийцүүлэн тодорхой хэмжээнд өөрчилсөн ч конвенцын заалттай бүрэн нийцээгүй байна. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүү шүүлт тулгах хэлбэрийг өргөжүүлэн зохицуулж, эрүү шүүлт тулгах эсхүл гутаан доромжлох, шахалт дарамт үзүүлэх сэдэлт, зорилго нь гуравдагч хүн ч эрүүгийн хариуцлага хүлээхээр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Практикт гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд шүүхээс эмнэлгийн



чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг гаргасан тохиолдолд тус албадлагын арга хэмжээг СЭМҮТ-ийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник хэрэгжүүлж байна. Тус албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зарим асуудлыг дурдвал, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэх хугацаа, хугацааны дээд хэмжээг тодорхой тусгаагүй, тус албадлагын арга хэмжээг өөрчлөх, зогсоохтой холбоотой асуудлыг хэт ерөнхий байдлаар хуульчилсан гэх мэт.


Хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн зохицуулалтаас нэлээд өргөн хүрээнд албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээний зохицуулалт тусгагдаж байгаагийн хувьд хугацааны зохицуулалт ерөнхий байдлаар хуульчлагдаж, сэтгэцийн эмнэлэг ердийн болон тусгай тасагтай байх үндэслэлийг тусгаж, албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ авагдсан хүнд оношилгоо болон эмчилгээний туршилт хийхийг хориглох заалтыг шинээр тусгаж өгчээ. Эдгээр зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой бөгөөд цаашид албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээтэй холбоотой зохицуулалтыг улам боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байгааг дурдах нь зүйтэй.

Манай улсын хувьд хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... Хүнийг хууль бусаар хорьсон нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн шинжгүй..." гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, одоогийн Эрүүгийн хууль дахь "Хүнийг хүчээр алга болгох" гэмт хэрэг нь олон улсын конвенцод заасан тус гэмт хэргийн шинжийг агуулаагүй бөгөөд "Хүнийг хууль бусаар хорих" гэмт хэргийн шинжийг илүүтэй агуулсан зохицуулалтыг "Хүнийг хүчээр алга болгох" гэж томъёолон хуульчилсан байна. Харин хуулийн төсөлд тус 2 гэмт хэргийг ялгамжтай байдлаар тодорхойлон тусгажээ. Хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн гол онцлог бол уг гэмт этгээдийн ард төрийн байгууллага, засгийн газар зэрэг эрх бүхий этгээд байдаг тул зөвхөн төрийн албан хаагч дангаар (тухайлбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй төрийн албан хаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч г.м) хүнийг хууль бусаар хорьсон бол шууд хүнийг хүчээр алга болгох гэмт хэргээр зүйлчилж болохоор байгааг анхааран үзэх нь зүйтэй. Иймд энэхүү гэмт хэргүүдийн гэмт хэргийн шинж, гэмт хэргийн бүрэлдэхүүний хоорондын ялгааг ялгамжтай байдлаар хуульчлах, мөн зөвхөн төрийн албан хаагчийн үйлдсэн гэмт үйлдлийг хүчээр алга болгох гэмт хэрэгт тооцох нь учир дутагдалтай байх тул хуулийн төсөлд тусгагдсан субъектийг конвенцод нийцүүлэн өөрчлөх хэрэгтэй гэж дүгнэлээ. Түүнчлэн, төсөлд заасан төрөөс эрх олгогдсон этгээд болон төрөөс шууд болон шууд бусаар дэмжлэг авсан этгээдийн хамаарлыг тодруулах шаардлагатай юм.

Түүнчлэн судалгааны ойлгомжтой байдал болон харилцан уялдаатай байдлын шалгуур үзүүлэлтэд хамааруулж авч үзсэн зөвлөмжийг дахин анхаарч хуулийн төсөлд засвар оруулах шаардлагатай байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулах талаар нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нь зорилгодоо нийцэж байгаа буюу одоо бий болоод буй асуудлыг шийдвэрлэсэн ач



холбогдол бүхий зохицуулалт байна. Гэхдээ одоо байгаа систем, сангийн сул талыг засварлан зорьж буй давуу талд хүрэх нь зүйтэй.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн өөрчлөгдсөн зохицуулалтууд нь ихэвчлэн бусад хуулийн шинэчилсэн найруулга болон нэмэлт, өөрчлөлттэй холбоотой нь тодорхойлогдож байна. Эрх бүхий албан тушаалтан, хэрэгжүүлэгч этгээдүүдийн тухайд харьяаллын зарим зөрчлүүд нь нэмэгдэж, хасагдаж зохицуулагдаж байгаа ч давхардал, хийдэл, зөрчлийг үүсгэх магадлалтай байна. Ялангуяа хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн харьяаллын хооронд зөрчил үүсэхээр байна. Түүнчлэн хуулийн төсөлд эрх бүхий албан тушаалтан, хэрэгжүүлэгч этгээдүүдийн харьяаллыг өөрчилж зохицуулахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн одоо үйлчилж буй заалтыг бүхлээр нь бичиж байгаа нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. Иймд оруулах гэж буй нэмэлт эсвэл өөрчлөлтийг зөвхөн хуулийн төслөөр тухайлан зохицуулах нь зүйтэй.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:


Зөрчлийн тухай хуулийн тус нэмэлт, өөрчлөлтөөр баривчлах шийтгэлээс чөлөөлөх хүмүүсийн зохицуулалтыг өргөжүүлж зохицуулсан нь зорилго, зарчимд нийцэхээр байна.

Хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүрэг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан үүрэг тул харилцан уялдаатай үр дүнтэй зохицуулалт байна. Нэг цэгийн үйлчилгээний журам нь мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлд тусгагдсан учир харилцан уялдаатай байна. Гэр бүлийн хамааралтай хүний биед халдахаас бусад гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд торгох шийтгэл оногдуулахаар зохицуулсан нь бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн зүйлгүй тул харилцан уялдаатай байна.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль нь 2021 онд батлагдсан ба тус хуульд цөөн тооны нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Одоогийн хуулийн төслөөр тус хуулийг зөрчих зөрчлийн 60 орчим хувьд өөрчлөлт оруулж байгаа нь өмнө нь хэвийн үйлчилж байсан тус хоёр хуулийн үйлчлэлд өөрчлөлт оруулах магадлалтай. Иймд хууль, хуулийн төслийн харилцан уялдааг дахин харах шаардлагатай.

Хуулийн төслөөр хөдөлмөрийн тухай хууль зөрчих зөрчлийн 80-90 хувьд нь өөрчлөлт оруулж байгаа нь шинэ Хөдөлмөрийн тухай хууль 2022 онд батлагдсантай холбоотой байхаар байна. Гэвч хуулийн төсөлд өмнөх зөрчлийн зохицуулалтын ихэнх хэсэгт өөрчлөлт оруулж, бүтцийг өөрчилсөн байгаа нь өмнөх бий болоод байсан хууль хэрэглээг өөрчилж, харилцан уялдаагүй байдлыг бий болгож магадгүй юм. Иймд 2022 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуультай хуулийн төсөлд заасан зөрчлийг нийцүүлэхээс гадна өмнөх зөрчлийн бүтэц, найруулгыг хадгалах нь чухал.

Монгол Улсын иргэн гадаад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:



Хуулийн төслийн зохицуулалт нь зорилгод нийцсэн үр дүнтэй байхаас гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжтой харилцан уялдаатай байна.


Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Хуулийн төсөл нь хэрэгцээ шаардлагын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", 2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.", Арван зургаадугаар зүйлийн 4 дэх заалтад "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж тус тус заасан үндсэн хуулийн зохицуулалтыг өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж буй өмгөөлөгчийн хувьд адил үйлчлэх практик хэрэгцээ шаардлагын хангахын зэрэгцээ өмгөөллийн тухай хуулийн "...өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах..." зорилгод нийцэж байна.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын "онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн" гэснийг хасах нь хууль хоорондын уялдаа холбоог хангахад чухал ач холбогдолтой. Учир нь 2002 оны Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлд "онц аюултай гэмт хэрэгтэн" гэх ойлголтыг хуульчилж өгсөн бөгөөд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар "онц аюултай гэмт хэрэгтэн" гэх хууль зүйн үр дагавар үүсгэдэг ойлголтыг хассан нь олон улсын туршлагад үндэслэн хүний эрх, эрх чөлөөг хангах, эрүүгийн эрх зүйн суурь зарчимд нийцүүлсэн эерэг өөрчлөлт болсон билээ. Гэтэл Эрүүгийн хуулиас "онц аюултай гэмт хэрэгтэн" гэх ойлголтыг хассан боловч хууль хоорондын уялдаа холбоог хангаж, Эрүүгийн хууль шинэчлэгдсэн батлагдсантай холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын "онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн" гэх хэсгийг хасалгүй орхигдуулсан гэж үзэж байна. Иймд хуулийн төсөлд тус зохицуулалтыг хасахаар тусгасан нь хууль хоорондын уялдаа холбоог сайжруулах, хүний эрхийг хангах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгодоо хүрсэн гэж дүгнэж байна.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт "Хохирлыг хоригдсон этгээдийн садан төрөл, бусад хүмүүс барагдуулж болно" гэж заасныг хасахаар тусгасан нь хуулийн төслийн хүний эрхийг хамгаалах, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх зорилгод нийцэж байна. Учир нь тус хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасан зохицуулалт нь тухайн гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийг хамгаалах, хохирлоо нөхөн төлүүлэхэд чиглэсэн зохицуулалт мэт боловч нөгөө талдаа гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг



садан төрөл, бусад хүмүүсээр төлүүлэхээр зохицуулсан нь гэм буруутны ял зэмлэлийг бусдад халдаан хэрэглэж буй явдал юм. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль тогтоомжтой зөрчилдөж байна. Иймд тус зохицуулалтыг хасахаар хуулийн төсөлд тусгасан нь зорилгодоо хүрсэн байна.


Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “заавал хянана” гэснийг “хянаж болно” гэж өөрчлөхөөр хуулийн төсөлд тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан хувь хүний захидал харилцааны нууцад халдах, ШШГТХ-д заасан захидал илгээх эрхийг хэлбэрийн төдий байдлаар хангах нөхцөлийг бүрдүүлж байсан. Тус зохицуулалтыг “заавал хянана” гэснийг “хянаж болно” буюу сонгох боломжтой байдлаар хуульчилсан нь хүний эрхийг хангахад чиглэсэн эерэг өөрчлөлт болж байна. Нөгөөтээгүүр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд шаардлагатай тохиолдолд баривчлагдсан, цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагчийн захидал цахилгааныг хянан үзэж болохоор хуулийн төсөлд тусгасан нь аль аль талынх нь эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн оновчтой зохицуулалт болсон гэж дүгнэж байна. Иймд төслийн энэхүү зохицуулалт практикт хэрэгжих бүрэн боломжтой зохицуулалт юм.

Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Хуулийн төслөөр төрийн нууц, албаны нууц гэх ойлголтыг ялгахад тулгамдаж буй хүндрэлтэй байдлыг шийдвэрлээгүй байх тул албаны нууц гэх ойлголтын тодорхойлолтыг дахин сайжруулах нь зүйтэй байна. Ингэхдээ “албаны нууц” гэдэгт хуульд заасан тодорхой шалгуурыг хангасан тул тухайн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад хамааруулсан, Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуульд заасан хязгаарлалттай мэдээллийн нэг төрлийг ойлгохоор тусгахыг зөвлөж байна. Мөн хуулийн төслийг харилцан уялдаатай болгоход чиглэсэн хэд хэдэн өөрчлөлтийг оруулах шаардлагатай.

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалахад Зохицуулах хороо чухал үүрэг гүйцэтгэхээр байх тул Зохицуулах хорооны дарга, гишүүд нь салбарт үйлчилгээ үзүүлж буй аж ахуй нэгжээс гадна аливаа нам, эсвэл, улс төрийн нөлөө бүхий этгээдээс хараат бус ажилладаг байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлага байсаар байна. Тухайлбал нам, эвслийн гишүүнчлэлгүй байх, улс төрийн нөлөө бүхий этгээдтэй харилцан хамааралтай биш байх зэрэг шаардлагуудыг тавих нь тохиромжтой байна. Цаашлаад ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх ерөнхий зохицуулалт үгүйлэгдэж байна. Тухайлбал, өөрийн болон өөрт хамааралтай этгээдийн ашиг сонирхолд холбогдох аливаа асуудалд саналын эрхтэй оролцохгүй байх зэрэг шаардлагыг тавих, тус шаардлагыг зөрчвөл тус хорооны дарга, гишүүдэд хариуцлага тооцох үндэслэл болохоор зохицуулах нь хорооны дарга, гишүүдийн гадны нөлөөллөөс ангид, хараат бус ажиллах боломжийг хангахад чухал нөлөө үзүүлнэ. Дээрх нэмэлт хөшүүргүүдийг оновчтой тодорхойлох нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хараат бус байдлыг хангах” зорилгод нийцнэ.



Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хараат бус байдал төдийлөн хангагдаагүй байна. Иймд мэргэжлийн хараат бус Зохицуулах хороог бүрдүүлэхэд гишүүдэд тавигдахаас шаардлагаас гадна Ерөнхий сайдаас бусад төрийн эрх бүхий байгууллагад, тухайлбал УИХ, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг байгууллагаас Зохицуулах хорооны гишүүнд нэр дэвшүүлэх хувилбарыг хэрэгжүүлж болохоор байх бөгөөд цаашлаад гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх үндэслэлийг тухайлан зохицуулах нь хараат бус байдлыг практикт хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байна. БНСУ-ын жишигт үндэслэвэл, Зохицуулах хорооны гишүүнд тавигдаж буй “үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй” гэх шаардлагыг чангатгаж гишүүнээр томилогдохоос өмнөх тодорхой хугацаанд энэ төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхлээгүй байх, удирдах албан тушаалтнаар ажиллаагүй байх зэргээр зохицуулах хараат бус байдлыг практикт хэрэгжүүлэхэд нөлөөтэй.

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Хуулийн төслийн танилцуулгын 4, 5 дахь хэсэгт тусгагдсан зохицуулалтыг хуулийн төсөлд оруулж зохицуулаагүй байна. Тодруулбал, Цалин хөлсийг тооцох аргачлалыг боловсронгуй болгож, илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс, шагнал урамшууллыг оруулахгүй байх зохицуулалт болон “албан тушаал бууруулах” хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг хасах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаагүй байна. Иймд хуулийн төсөлд тухайн зохицуулалтуудыг тусгах нь хуулийн төслийн зорилгод нийцэхээр байна.


Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Хуулиар эрх олгосны дагуу олон тооны журмаар хүний эрх, эрх чөлөөнд халдаж байгааг бууруулах үүднээс холбогдох журмууд дахь хүний эрхийг хөндөж буй зохицуулалтыг хуулиар зохицуулах чиглэлийг Засгийн газраас өгсөн. Гагцхүү журам батлах эрх зүйн үндэслэлийг хуулиас хасах нь холбогдох харилцааг зохицуулалтгүй үлдээх сөрөг үр дагавартай. Иймд Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн дагуу батлагдсан журмуудад юун түрүүнд дүн шинжилгээ хийж, уг журам дахь хүний эрхийг хөндсөн голлох зохицуулалтыг тодорхойлж, тэдгээрийг хуульд нэмэх дарааллаар ажиллахыг зөвлөж байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Хуулийн төслийн 11.1.1 дэх заалтад “шүүх хуралдааны нарийн бичгийн дарга” гэж нэмж, уг ажлыг нь хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох зохицуулалт хийх нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хуулийн дээр дурдсан холбогдох зохицуулалт, УДШ болон ҮХЦ-ийн тогтоол, шийдвэрүүдтэй нийцэж байх тул уг хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:



Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт нь зорилгодоо нийцэх боловч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн зохицуулалт дутмаг байна. Тухайлбал, Монгол Улсад насанд хүрээгүй этгээд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох нь нийтлэг байх боловч насанд хүрээгүй хохирогчийг хамгаалах тусгай байр болон тэдгээр үзүүлэх урт хугацааны тусламж, үйлчилгээний хүртээмжтэй холбогдох асуудал байсаар байна.

Цаашлаад хохирогчийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэмт хэрэг үйлдсэн эсхүл хохирогчийг хамгаалах талаар шаардлагатай арга хэмжээг аваагүй, түүнийг төлөөлөх үүрэгтээ хойрго хандсан тохиолдолд төрийн болон төрийн бус байгууллага идэвхтэй оролцох шаардлагатай байгаа боловч хуулийн төсөлд энэ талаарх нарийн зохицуулалтыг тусгаагүй байгаа нь учир дутагдалтай байна.

Механизмын хувьд авч үзвэл, төрөөс энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх төсөл хөтөлбөрийг хохирогчийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн олон хувилбар, төрлөөр зарлаж, сонгогдсон байгууллагад хангалттай хэмжээний санхүүжилт олгож ажиллах нь үр дүнтэй юм.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:


Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа” гэснийг “олонхын саналаар нууц санал хураалтаар” гэж өөрчлөн хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүн буюу уг хорооны даргын бүрэн эрхийн хугацааны хэт богино хязгаарлалтын халж байгаа нь хууль тогтоомжийн зорилготой зөрчилдөхгүй байгаа боловч уг гишүүний ХЭХЭЗБТХ-д заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх хугацааг нь тодорхой зохицуулаагүй байгаа нь ХЭҮКтХ-ийн “Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлж...түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж ХЭҮКтХ-ийн 1 дүгээр зүйлд заасан зорилгод бүрэн хүрээгүй байна. Иймд тухайн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Хуулийн төслийн 17.3-т одоогийн хуулийн 17.2-т заасан “Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.” гэснийг Засгийн газрын гишүүн батлахаар болгож сургалтын төрлүүдийг өөрчлөн найруулсан байна. Үүнд зааснаар цагдаагийн албаны сургалтын хөтөлбөр, агуулга, журам гэж 3 тусдаа зүйл батлагдахаар байна. Гэтэл хөтөлбөр гэдэг нь өөрөө сургалтын агуулгыг багтаасан ойлголт байдаг тул өмнөх практикт сургалтын агуулга гэж тусдаа батлагддаггүй байсан. Иймээс агуулгыг хөтөлбөрт нэгтгэх шаардлагатай юм. Мөн хуулийн төслийн техникийн зарим засварыг хийснээр илүү ойлгомжтой болохоор байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд:

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын дагуу харуул хамгаалалтын ажилтан ажиллаж



байгаа бөгөөд тус практик нэгэнт тогтсон байна. Гэхдээ харуул хамгаалалтын ажилтны хөдөлмөрийн, эдийн засгийн болон нийгмийн хамгааллын баталгааг хангах шаардлага бий болоод байна. Тус хуулийн төслөөр харуул хамгаалалтын нэгж, харуул хамгаалалтын ажилтантай байх талаар хуульчилж өгсөн нь тухайн ажилтны эрх зүйн баталгааг хангаж буй хэрэг учраас ач холбогдолтой байна. Цаашлаад хөдөлмөрийн, эдийн засгийн болон нийгмийн хамгааллын баталгааг хангах талаар зохицуулалтыг тус хуулийн төсөлд эсвэл холбогдох журамд оруулж тусгах нь зүйтэй. Мөн харуул хамгаалалтын нэгжийг шинээр хуульчилж буй учир тус хуулийн төсөлд эсвэл холбогдох журамд зохион байгуулалтын талаар зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Хуулийн этгээдэд холбогдох мөнгөн төлбөрийн үүргийг 70 хувьтай гүйцэтгэдэг. Мөн төлбөрийг гаргуулах шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухайд хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах тал дээр асуудал үүсэж байна. Үүнийг шийдвэрлэх сайн туршлагын тухайд санхүү, нягтлан бодох бүртгэл, мөрдөн шалгах ажиллагааны тусгай мэдлэг шаардлагатай болохыг тухайлан авч үзсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай тус хуулийн төсөлд тухайн асуудлыг шүүх нэхэмжлэлийг хангасан тохиолдолд гэж илүү мэргэшсэн хяналттай субъектэд хариуцуулж байгаа нь үр дүнтэй, практикт нийцсэн байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ”-г “албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ” гэж өөрчлөөд үүнд хамгаалах зорилгоор тусгаарлан эмчлэх, сэтгэцийн эмгэг судлаачийн хяналтад эмчлэх, донтох зуршлын эсрэг эмчилгээ, сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх арга хэмжээ авахаар тусгажээ. Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай тус хуулийн төсөлд дээрх нэр томъёог шинэчлэн зохицуулахдаа Эрүүгийн хууль дээр тус өөрчлөлт орох нь зүйтэй эсэхэд үндэслэн шийдвэрлэх шаардлагатай.


Мөн түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дугаар зүйл нь бүхэлдээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг зохицуулалт хэм хэмжээ байхад үүнийг ганцхан сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх арга хэмжээнд хамааруулан зохицуулж байгаа нь эрх зүйн хийдэл үүсгэх магадлалтай. Тийм учраас хуулийн төслийн тус зохицуулалтыг анхаарч авч үзэх хэрэгтэй.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Авлигын эсрэг хууль, 2006.
3. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 2013.
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016.
5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019.
6. Гэр бүлийн тухай хууль, 1999.
7. Зөрчлийн тухай хууль, 2017.
8. Иргэний хууль, 2002.
9. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966.
10. Монгол Улсын иргэн хувийн хэргээр гадаадад зорчих, цагаачлах тухай хууль, 1994.
11. Монгол Улсын Хилийн тухай хууль. 2016.
12. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль.
13. Өмгөөллийн тухай хууль, 2019.
14. Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2019.
15. Төрийн болон албаны нууцын тухай хууль, 2016.
16. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, 2023.
17. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017.
18. Хувийн хамгаалалтын тухай хууль, 2001.
19. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012.
20. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2021.
21. Хууль зүйн туслалцааны тухай хууль, 2022.
22. Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенц, 2007.
23. Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль, 2020.
24. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2021.
25. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989.
26. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016.
27. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, 1999.
28. Хөдөлмөрийн тухай хууль, 2021.
29. Цагдаагийн албаны тухай хууль, 2017.
30. Эрүүгийн хууль, 2002.
31. Эрүүгийн хууль, 2016.
32. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017.
33. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, 2022.
34. МХХ-ны зөвлөлийн хурлын тогтоол дугаар 13 “Журам батлах” тухай.
35. МХХ-ны “Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тогтоох журам, 2023.
36. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа, явуулах түүнд хяналт тавих журам, 2020.
37. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа, явуулах түүнд хяналт тавих журам, 2024.
38. Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам, 2021.

- 
39. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А-240/А/369 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”.
 40. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, 1984;
 41. Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, 2014.
 42. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, 2016.
 43. Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, 2013.
 44. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, 2022.
 45. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, 2024.
 46. Хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ конвенцид нийцүүлэх зорилгоор боловсруулсан хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗДХЯ, 2024.

Шүүхийн шийдвэр

1. Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн дугаар 02 тогтоол.
2. Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн дугаар 06 тогтоол.
3. УДШ-ийн 2006 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дугаар 08 тогтоол.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг нийтлэл, 2017.
2. Гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй хүнд оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилт /Судалгааны тайлан/, ШШГЕГ-ын харьяа ХӨТЯЭА.
3. Л.Эрдэнэбаяр, Сэтгэц судлал, Уб, 2012.
4. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, Уб, 2022, 31-32 дахь тал.
5. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2022, МУГХУСА33, 2023.
6. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, ХЭҮК, 2023.
7. Хүний эрхийн үндэсний комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны тайланд хийсэн шинжилгээний танилцуулга, УИХТГ, 2023.
8. ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, 2023.
9. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь /Судалгааны товч тайлан/, 2021.
10. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан журмуудын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, МУГХУСА33, 2023.

11. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ХЗДХЯ, 2024.
12. Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, хандлагыг үнэлэх /Судалгааны тайлан/, 2023.
13. Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2022.
14. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик: Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал, 2021.
15. Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, MJL Attorneys, 2023, 28 дахь тал.
16. ХЗҮХ, Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалт (Олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага) сэдэвт судалгааны тайлан, 2023.
17. ХЗҮХ, Төрийн болон албан нууцын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийг үнэлэх нь судалгаа, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2023.
18. Монгол Улс дахь ХХГХ-ийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгаа, 2022.
19. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал, 2021.
20. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2022, УБ, 2023
21. НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг: Монголд хийсэн айлчлалын урьдчилсан дүгнэлт (2022 оны Аравдугаар сарын 3-14 өдрүүд)
22. Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Үндсэн хууль манай сургуульд, УБ, 2022
23. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв. Статистик үзүүлэлт, УБ, 2018-2022
24. Дотоод хэргийн их сургууль, “Гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй хүнд оногдуулсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилт” Судалгааны тайлан.
25. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв, “Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт”, УБ, 2021
26. Мянганбаяр Ц. “СЭМҮТ-ийн албадан эмчлүүлэгчдэд харуул хамгаалалтын хяналт тавихад тулгамдаж буй асуудал” сэдэвт илтгэл. Гэмт явдалтай тэмцэх асуудал. УБ,2021

Цахим эх сурвалж

1. Монголын хуульчдын холбооны гишүүний татварын асуудлыг шийдвэрлүүлэх талаар хуралдав, 2022.10.14.
https://www.facebook.com/ama.org.mn/posts/8045024418900923/?paipv=0&ea_v=AfYCG3mBOU9YNzwMGUSrSDnYDzMQ29iw7MGFiDs0XhTLPS5mhHI0y5dTU6h4H2kk-q8&_rdr
2. Харилцаа холбооны зохицуулах хорооны албан ёсны вэб сайт,
<https://crc.gov.mn/about-us/show/organizational-structure/mn>
3. Х.Нямбаатар: Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем ирэх оноос ажиллаж эхэлнэ, <https://montsame.mn/mn/read/307709>
4. “Зөрчлийн бүртгэл мэдээллийн цахим сан”-г ашиглах сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулагдлаа, <https://police.gov.mn/a/6327>
5. 2023 оны 3 сарын 23-24-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын Шүүхийн цахимжуулалт” ОУБХ-д ЦХХХ-ны дэд сайд Ж.Эрхэмбаатарын хэлэлцүүлсэн “Монгол Улсын шүүхийн болон хуулийн байгууллагуудыг цахимжуулах мэдээлэл технологийн үүрэг” сэдэвт илтгэлээс.

Гадаад хэл дээрх

Хууль тогтоомж

1. Act on the establishment and operation of Korea Communications Commission.
2. The Tshwane Principles on National Security and the Right to Information.
3. The Tshwane Principles on National Security and the Right to Information: An Overview in 15 Points, <https://www.justiceinitiative.org/publications/tshwane-principles-national-security-and-right-information-overview-15-points>.
4. Crime Victims Rights Protection act, Taiwan
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=I0050005>
5. 18 U.S. Code § 3525 - Victims Compensation Fund,
<https://www.law.cornell.edu/uscode/text/18/3525>

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. GRETA, Reply from the Netherlands to the Questionnaire for the evaluation of the implementation of the Council of Europe Convention on Action against Trafficking in Human Beings by the Parties, Third evaluation round, 2022. <https://rm.coe.int/reply-from-the-netherlands-to-the-questionnaire-for-the-evaluation-of-/1680a6615d>.
2. La Rue, Frank, UN. Human Rights Council, Special Rapporteur on the Promotion and Protection of the Right to Freedom of Opinion and Expression, 2011.05.27. <https://digitallibrary.un.org/record/706200>.
3. Bureau of Anti-Trafficking in Women and Children and Japan International Cooperation Agency, MDT Operational Guideline for the Protection of Victims of Human Trafficking.
https://www.jica.go.jp/Resource/project/thailand/016/materials/ku57pq00001yw2db-att/mdt_guideline_practical_version.pdf
4. Human Rights and Development Foundation, Compensation for Victims of Trafficking in Persons, 2019 https://hrdfoundation.org/wp-content/uploads/2019/09/HRDF_Final-victim-compensation.pdf
5. A/HRC/7/2, para. 26 (para. 1 of the general comment on the definition of enforced disappearance)
6. A/HRC/7/2, para. 26 (para. 7 of the general comment on the definition of enforced disappearance).
7. Police education and training systems in the OSCE region, 2018,
<https://www.osce.org/files/f/documents/f/7/423401.pdf>.
8. Office for Victims of Crime, Current Funding Opportunities,
<https://ovc.ojp.gov/funding/current-funding-opportunities>
9. Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment ADOPTED 09 December 1988 BY General Assembly resolution 43/173,
<https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/body-principles-protection-all-persons-under-any-form-detention>
10. Online Crime File Management System Posted by JPINFOTECHPROJECTS,
<https://jpinfotech.org/online-crime-file-management-system/>

Цахим эх сурвалж

1. <http://assembly.coe.int/committeedocs/2011/ajdoc45.pdf>
2. <https://digitallibrary.un.org/record/3795922?ln=en>
3. <https://digitallibrary.un.org/record/3949022?ln=en>
4. <https://www.icj.org/wpcontent/uploads/2017/08/South-Asia-Enforced-Disappearance-Publications-Reports-Thematic-Reports-2017-ENG.pdf>